

# ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТУХАЙ

2005 оны 7 дугаар сарын 01-ний өдөр

Улаанбаатар хот

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

### 1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь газрын тосны бүтээгдэхүүнийг импортлох, үйлдвэрлэх, худалдах, тээвэрлэх, хадгалах болон эдгээр үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

### 2 дугаар зүйл.Газрын тосны бүтээгдэхүүний импорт, үйлдвэрлэл, худалдаа, тээвэрлэлт, хадгалалтын тухай хууль тогтоомж

2.1.Газрын тосны бүтээгдэхүүний импорт, үйлдвэрлэл, худалдаа, тээвэрлэлт, хадгалалтын тухай хууль тогтоомж нь Газрын тосны тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль, Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хууль, Барилгын тухай хууль, Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль, Эрүүл ахуйн тухай хууль, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Химийн хорт бодисоос хамгаалах тухай хууль, Төмөр замын тээврийн аюулгүй байдлын тухай хууль, Автотээврийн тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

*/Энэ хэсэгт 2016 оны 2 дугаар сарын 04-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

*/Энэ хэсэгт 2017 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./*

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

### 3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Монгол Улсын нутаг дэвсгэрт газрын тосны бүтээгдэхүүний импорт, үйлдвэрлэл, худалдаа, тээвэрлэлт, хадгалалтын үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдэд энэ хууль үйлчилнэ.

### 4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёо

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“газрын тосны бүтээгдэхүүн” гэж газрын тос болон химийн нэгдлүүдийг боловсруулах замаар гарган авсан бүх төрлийн шатахуун, тусгай шингэн, шатдаг хий, тос тосолгооны материал, битум, мазут болон бусад бүтээгдэхүүнийг;

4.1.2.“тоног төхөөрөмж” гэж газрын тосны бүтээгдэхүүнийг импортлох, үйлдвэрлэх, худалдах, тээвэрлэх, хадгалах, чанарын шалгалт хийхэд ашиглах шахуурга, түгээгүүр, хэмжих, тохируулах, ачих, буулгах хэрэгсэл, хадгалах сав, дамжуулах хоолой, хаалт зэрэг механик болон автомат ажиллагаатай техник хэрэгслийг;

4.1.3.“агуулах” гэж газрын тос болон газрын тосны бүтээгдэхүүнийг хүлээн авах, хадгалах, савлах, бөөний худалдаа эрхлэхэд зориулсан байгууламж, тоног төхөөрөмж, техник хэрэгслийн цогцолборыг;

4.1.4. “түгээх станц” гэж газрын тосны бүтээгдэхүүнийг хүлээн авах, хадгалах, тээврийн хэрэгслийг цэнэглэх, савласан бүтээгдэхүүний жижиглэнгийн худалдаа эрхлэхэд зориулсан барилга, байгууламжийн цогцолборыг;

4.1.5. “компанийн нөөц” гэж газрын тосны бүтээгдэхүүний бөөний худалдаа, үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн хангамж, худалдааны хэвийн үйл ажиллагааг тасралтгүй явуулахад шаардагдах хэмжээний тухайн этгээдийн эзэмшлийн агуулах, саванд хадгалагдаж байгаа газрын тосны бүтээгдэхүүнийг;

4.1.6. “газрын тосны бүтээгдэхүүний бөөний худалдаа” гэж газрын тосны бүтээгдэхүүнийг нэг удаад тээврийн хэрэгслийн нэг торхны хэмжээнээс багагүй хэмжээгээр борлуулалт хийхийг.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ**

### **ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ИМПОРТ, ҮЙЛДВЭРЛЭЛ, ХУДАЛДАА, ТЭЭВЭРЛЭЛТ, ХАДГАЛАЛТЫН ТАЛААРХ ТӨРИЙН ЗОХИЦУУЛАЛТ**

**5 дугаар зүйл. Газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа, тээвэрлэлт, хадгалалтын талаархи Засгийн газар болон газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх**

5.1. Газрын тосны бүтээгдэхүүний талаар Засгийн газар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

5.1.1. газрын тосны бүтээгдэхүүний импорт, үйлдвэрлэл, худалдаа, тээвэрлэлт, хадгалалт, хөрөнгө оруулалтын талаар баримтлах бодлогын хэрэгжилтэд хяналт тавих;

5.1.2. газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөц бүрдүүлэх журам батлах;

5.1.3. газрын тосны бүтээгдэхүүний бөөний худалдаа, үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн нөөцийн хэмжээ, нөөц бүрдүүлэх журмыг батлах;

5.1.4. газрын тосны бүтээгдэхүүний үнийн хэвийн бус өсөлт, хангамжийн тасалдал, хомсдол үүсэх нөхцөлд зохицуулалт хийх;

5.1.5. импортолж байгаа газрын тосны бүтээгдэхүүний чанарын хяналтыг хилийн боомтуудад хийх бодлогыг хэрэгжүүлэх, нөхцөлийг бүрдүүлэх.

5.2. Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага газрын тосны бүтээгдэхүүний талаар дор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

5.2.1. газрын тосны бүтээгдэхүүний импорт, үйлдвэрлэл, худалдаа, тээвэрлэлт, хадгалалт, хөрөнгө оруулалтын талаар төрөөс баримтлах бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

5.2.2. газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл, бүх төрлийн шатахууныг импортлох, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, уг зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох;

*/Энэ заалтыг 2013 оны 2 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

5.2.3. газрын тосны бүтээгдэхүүний импорт, үйлдвэрлэл, худалдаа, тээвэрлэлт, хадгалалтын асуудалтай холбогдсон дүрэм, журам, нормыг баталж, мөрдүүлэх;

5.2.4. газрын тосны бүтээгдэхүүний бөөний худалдаа, үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нөөцийн талаар санал боловсруулан Засгийн газраар шийдвэрлүүлж хэрэгжүүлэх;

5.2.5. газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөлтэй холбоотой

нарийвчилсан журмыг баталж мөрдүүлэх.

*/Энэ заалтыг 2013 оны 2 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар нэмсэн/*

5.3.Газрын тосны бүтээгдэхүүнийг тээвэрлэх тээврийн хэрэгсэлд тавих техникийн шаардлагыг тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, стандартчиллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай хамтран тогтооно.

## **6 дугаар зүйл.Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх**

6.1.Газрын тосны бүтээгдэхүүний импорт, үйлдвэрлэл, худалдаа, тээвэрлэлт, хадгалалтын талаар газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.1.1.газрын тосны бүтээгдэхүүний талаархи бодлогыг хэрэгжүүлэх;

6.1.2.газрын тосны бүтээгдэхүүнийг импортлох, үйлдвэрлэх, худалдах, тээвэрлэх, хадгалахтай холбоотой стандарт, дүрэм, журам, нормын төслийг боловсруулах;

6.1.3.газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэр, агуулах, түгээх станц барьж байгуулах, шинэчлэх зураг төсөлд техник, технологийн талаар дүгнэлт гаргах;

6.1.4.газрын тосны бүтээгдэхүүний барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажил эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход мэргэжлийн дүгнэлт гаргах;

6.1.5.газрын тосны бүтээгдэхүүний барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авах комиссын бүрэлдэхүүнд ажиллах;

6.1.6.газрын тосны бүтээгдэхүүний импорт, үйлдвэрлэл, худалдаа, тээвэрлэлт, хадгалалтын талаар мэдээллийн сан бүрдүүлэх, бодлого зохицуулалтад шаардлагатай нэмэлт судалгаа, мэдээллийг холбогдох байгууллагаас гаргуулан авах;

6.1.7.газрын тосны бүтээгдэхүүний зах зээлд шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэхэд шаардлагатай мэдээллийг Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хуулийн 14.1.5-д заасны дагуу холбогдох байгууллага болон төрийн захиргааны төв байгууллагад гаргаж өгөх, энэ талаар санал гаргах;

6.1.8.газрын тосны бүтээгдэхүүнийг импортлох, үйлдвэрлэх, худалдах, тээвэрлэх, хадгалах талаар сургалт явуулах, мэдээлэл арга зүйн туслалцаа үзүүлэх, зөвлөгөө өгөх;

6.1.9.газрын тосны бүтээгдэхүүний олон улсын биржийн үнийг судлах, импортлогчийн нийлүүлэгчээс худалдан авах үнийг хянах.

6.2.Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 6.1-д заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцад шаардлагатай гэж үзвэл мэргэжлийн хяналтын байгууллагатай хамтран хяналт тавьж, холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ ИМПОРТЛОХ ҮЙЛДВЭРЛЭХ, ХУДАЛДАХ, ТЭЭВЭРЛЭХ, ХАДГАЛАХ**

### **7 дугаар зүйл.Газрын тосны бүтээгдэхүүнийг импортлох**

7.1.Бүх төрлийн шатахууныг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр импортлох бөгөөд импортлогч дор дурдсан үүрэг хүлээнэ:

*/Энэ хэсэгт 2013 оны 2 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

7.1.1.чанарын хувьд олон улсын стандартад нийцсэн газрын тосны бүтээгдэхүүнийг импортлох;

7.1.2.импортолсон бүтээгдэхүүн олон улсын стандартад нийцсэн эсэх талаар итгэмжлэгдсэн сорилтын лабораториор дүгнэлт гаргуулах;

7.1.3.бөөний худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь эзэмшилдээ стандартын шаардлага хангасан агуулахтай байх;

*/Энэ заалтад 2013 оны 2 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

7.1.4.газрын тосны бүтээгдэхүүнийг нийлүүлэгчтэй байгуулсан гэрээний үндсэн дээр импортлох.

7.2.Монгол Улсад газрын тосны бүтээгдэхүүний 30-аас дээш хувийг дангаараа нийлүүлж байгаа гадаадын хуулийн этгээд дотоодын зах зээлд өөрийн хөрөнгө оруулалт бүхий хуулийн этгээд болон өөрийн харъяалал, хяналтад байдаг нэгжээрээ дамжуулан бүтээгдэхүүнээ борлуулахыг хориглоно.

## **8 дугаар зүйл.Газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэх**

8.1.Газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлнэ.

8.2.Газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрийн технологи, тоног төхөөрөмж олон улсын стандартад нийцсэн байна.

8.3.Газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд зааснаас гадна дор дурдсан бичиг баримт бүрдүүлнэ:

8.3.1.байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэсэн дүгнэлт;

8.3.2.газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн төсөл;

8.3.3.мэргэжлийн байгууллагаар боловсруулж, улсын экспертизийн хяналт хийлгэсэн газрын тосны бүтээгдэхүүний барилга байгууламжийн зураг төсөл, газар эзэмших зөвшөөрөл;

8.3.4.газрын хөрсний геологийн дүгнэлт;

8.3.5.мэргэжлийн хяналтын байгууллагын ариун цэвэр, эрүүл ахуйн дүгнэлт;

8.3.6.галын аюулгүй байдлын дүгнэлт.

8.4.Газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч дараахь үүрэг хүлээнэ:

8.4.1.үндэсний стандартад нийцсэн газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэх;

8.4.2.газрын тосны бүтээгдэхүүний чанарын шинжилгээ, туршилт хийх итгэмжлэгдсэн лабораторитой байх;

8.4.3.үйлдвэрийн хаягдлыг хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд хор нөлөө үзүүлэхээргүй орчинд хадгалах, зайлуулах, устгах нөхцөлийг бүрдүүлэх.

## **9 дүгээр зүйл.Газрын тосны бүтээгдэхүүнийг худалдах**

9.1.Бүх төрлийн шатахууны бөөний болон жижиглэнгийн худалдааг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлнэ.

*/Энэ хэсгийг 2013 оны 2 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

9.2.Энэ хуулийн 9.1-д заасны дагуу тусгай зөвшөөрөл авахаар хүсэлт гаргагч нь энэ хуулийн 5.2.5-д заасан журам болон Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд зааснаас гадна дор дурдсан бичиг баримтыг бүрдүүлнэ:

*/Энэ хэсэгт 2013 оны 2 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

9.2.1.хэмжих хэрэгсэл, шингэний тоолуурыг Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хуулийн дагуу загварын туршилтад хамруулсан бичиг баримт;

9.2.2.стандартын шаардлага хангасан агуулах, түгээх станцын үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ, эсхүл эдгээрийн түрээсийн гэрээ.

9.3.Газрын тосны бүтээгдэхүүний бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэгч дараахь үүрэг хүлээнэ:

9.3.1.газрын тосны бүтээгдэхүүний бөөний худалдаа эрхлэгч бүтээгдэхүүн борлуулах тухай бүрдээ худалдан авагчид чанарын гэрчилгээ олгох;

9.3.2.чанарын баталгаатай газрын тосны бүтээгдэхүүн худалдах;

9.3.3.газрын тосны бүтээгдэхүүнийг улсын баталгаатай түгээгүүрээр худалдах;

9.3.4.газрын тосны бүтээгдэхүүнийг баталгаагүй түгээгүүр, авто болон вагонцистернээс шууд худалдахгүй байх;

9.3.5.газрын тосны бүтээгдэхүүнийг стандартын шаардлага хангасан саванд хадгалж, зөвшөөрөгдсөн талбай, орчинд худалдах;

9.3.6.тос, тосолгооны материал, тусгай шингэнийг зөвхөн зориулалтын саванд үйлдвэрийн аргаар технологийн дагуу савлаж худалдах;

9.3.7.бөөний худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч газрын тосны бүтээгдэхүүний чанарын шинжилгээний лабораторитой байх.

## **10 дугаар зүйл.Газрын тосны бүтээгдэхүүнийг тээвэрлэх**

10.1.Газрын тосны бүтээгдэхүүнийг тээвэрлэлтийн нөхцөл, техникийн шаардлага хангасан зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.

10.2.Зориулалтын саванд савласан тос, тосолгооны материал, хийг аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан тэвш, чингэлэгт тээвэрлэнэ.

10.3.Тээвэрлэгч тээвэрлэлтийн талаар эрх бүхий байгууллагаас батлан гаргасан техникийн аюулгүй ажиллагаа, тээвэрлэлтийн нөхцөлтэй холбогдсон дүрэм, журам, стандартын үзүүлэлт, шаардлагыг хангана.

10.4.Тээвэрлэгч зориулалтын тээврийн хэрэгсэлд тогтоосон журмын дагуу таних тэмдэг тавина.

10.5.Тээврийн хэрэгслийн өмчлөгч, эзэмшигч, жолооч тээврийн хэрэгслийг гал түймрээс урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, байгаль орчныг хамгаалах, иргэдийн эрүүл мэнд, амгалан тайван байдлыг алдагдуулахгүй байх нөхцөлийг хангасан зориулалтын зөвшөөрөгдсөн байр, зогсоол, талбайд тавина.

10.6.Тээвэрлэгч тээвэрлэж байгаа газрын тосны бүтээгдэхүүний нэр төрөл, чанарыг тодорхойлсон гэрчилгээ бөөний худалдаа эрхлэгчээс авна.

10.7.Газрын тосны бүтээгдэхүүнийг нийтийн тээврийн хэрэгсэл болон стандартын шаардлага хангаагүй зориулалтын бус тээврийн хэрэгслээр тээвэрлэхийг хориглоно.

## **11 дүгээр зүйл.Газрын тосны бүтээгдэхүүнийг хадгалах**

11.1.Газрын тосны бүтээгдэхүүнийг стандартын шаардлага хангасан зориулалтын агуулах, саванд хадгална.

11.2.Газрын тосны бүтээгдэхүүнийг хадгалах агуулах эзэмшигч хуулийн этгээд дор дурдсан шаардлагыг биелүүлэх үүрэгтэй:

11.2.1.байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэх;

11.2.2.газрын хөрсний геологийн дүгнэлтийг эрх бүхий байгууллагаар хийлгэх;

11.2.3.эрх бүхий мэргэжлийн байгууллагаар боловсруулж, улсын экспертизийн хяналт хийлгэсэн зураг, төслийн дагуу барьсан байх, газар эзэмших зөвшөөрөлтэй байх;

11.2.4.мэргэжлийн хяналтын байгууллагаар ариун цэвэр, эрүүл ахуйн дүгнэлт гаргуулах;

11.2.5.галын аюулгүй байдлын дүгнэлт гаргуулах;

11.2.6.агуулах, шатахуун түгээх станцын барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авсан тухай улсын комиссын акт, барилга байгууламжийн үндсэн бүтэц, инженерийн шугам сүлжээний төлөв байдлыг тодорхойлсон техникийн дүгнэлттэй байх.

11.3.Газрын тосны бүтээгдэхүүнийг хадгалах зориулалтын савыг өмчлөгч савыг улсын бүртгэлд бүртгүүлнэ. Газрын тосны бүтээгдэхүүн хадгалах зориулалтын савыг улсын бүртгэлд бүртгэх журмыг газрын тосны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батална.

11.4.Газрын тосны бүтээгдэхүүнийг хадгалахад дараах зүйлийг хориглоно:

11.4.1.зориулалтын бус барилга байгууламжид, мөн улсын комисс хүлээн аваагүй барилга байгууламжид газрын тосны бүтээгдэхүүнийг хадгалах;

11.4.2.стандартын шаардлага хангаагүй саванд хадгалах;

11.4.3.нэвчилт, шүүрэлттэй дамжуулах хоолой ашиглах;

11.4.4.аянга зайлуулагч, газардуулгын байгууламжгүй, уг байгууламжийн эсэргүүцлийг нь мэргэжлийн эрх бүхий байгууллагаар хэмжүүлж баталгаажуулаагүй сав, тоног төхөөрөмж ашиглах;

11.4.5.газрын тосны бүтээгдэхүүнийг автоцистернээс газардуулгагүй буулгах;

11.4.6.газрын тосны бүтээгдэхүүнийг зориулалтын буулгах байгууламжгүй саванд буулгах.

## **12 дугаар зүйл.Газрын тосны бүтээгдэхүүний холбоотой үйл ажиллагаа эрхлэгчдийн нийтлэг үүрэг**

12.1.Газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, худалдагч, бүтээгдэхүүн хадгалж байгаа этгээд дахин ашиглахаа больсон агуулах, сав, тоног төхөөрөмжийг зайлуулах, газрын тосны бүтээгдэхүүний үлдэгдлийг цэвэрлэх, газрыг тэгшилж хөрсийг хэвийн байдалд оруулан хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд хоргүй болгох, бохирдсон болон эвдэрч гэмтсэн газрын хөрсийг нөхөн сэргээж ургамалжуулах үүрэгтэй.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ НӨӨЦ**

### **13 дугаар зүйл.Газрын тосны бүтээгдэхүүний нөөц**

13.1.Газрын тосны бүтээгдэхүүний нөөц нь улсын болон компанийн нөөцөөс бүрдэнэ.

13.2.Улсын нөөцийг Засгийн газраас баталсан журмын дагуу бүрдүүлнэ.

13.3.Газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл, бөөний худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Засгийн газраас тогтоосон журмын дагуу компанийн нөөцийг бүрдүүлнэ.

**ТАВДУГААР БҮЛЭГ**  
**ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ИМПОРТ, ҮЙЛДВЭРЛЭЛ, ХУДАЛДАА,**  
**ТЭЭВЭРЛЭЛТ, ХАДГАЛАЛТАД ТАВИХ ХЯНАЛТ, ХУУЛЬ ТОГТООМЖ**  
**ЗӨРЧИГЧДӨД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА**

**14 дүгээр зүйл.Газрын тосны бүтээгдэхүүний импорт, үйлдвэрлэл, худалдаа, тээвэрлэлт, хадгалалтад тавих хяналт**

14.1.Газрын тосны бүтээгдэхүүний импорт, үйлдвэрлэл, худалдаа, тээвэрлэлт, хадгалалт болон эдгээр үйл ажиллагааны аюулгүй байдалд тавих хяналтыг мэргэжлийн хяналтын байгууллага хэрэгжүүлнэ.

14.2.Газрын тосны бүтээгдэхүүний импорт, үйлдвэрлэл, худалдаа, тээвэрлэлт, хадгалалтад тавих хяналтыг хэрэгжүүлэхдээ Төрийн хяналт, шалгалтын тухай хуулийг баримтална.

**15 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

15.1.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

*/Энэ зүйлийг 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА      Ц.НЯМДОРЖ**

# ГАЗРЫН ХЭВЛИЙН ТУХАЙ

1988 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр

Улаанбаатар хот

*/Энэ хуулийн гарчигт 1994 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

### **1 дүгээр зүйл. Газрын хэвлийн тухай Монгол Улсын хуулийн зорилт**

Газрын хэвлийн тухай Монгол Улсын хуулийн зорилт нь өнөөгийн болон хойч үеийнхний ашиг сонирхолд нийцүүлэн газрын хэвлийг ашиглах, хамгаалахтай холбогдсон нийгмийн харилцааг зохицуулахад оршино.

### **2 дугаар зүйл. Газрын хэвлийн тухай Монгол Улсын хууль тогтоомж**

1. Газрын хэвлийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

*/Энэ хэсгийг 1994 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

*/Энэ хэсгийг 1994 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар нэмсэн/*

### **3 дугаар зүйл. Монгол Улсын газрын хэвлий бол төрийн өмч**

Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар газрын хэвлий нь төрийн өмч, өөрөөр хэлбэл бүх ард түмний хөрөнгө мөн.

Газрын хэвлийг зөвхөн ашиглуулахаар олгоно. Газрын хэвлийг төр өмчлөх эрхийг аливаа хэлбэрээр зөрчихийг хориглоно.

### **4 дүгээр зүйл. Газрын хэвлий, түүний улсын нэгдмэл сан**

1. Хөрснөөс доош газрын гүн рүү үргэлжлэх орон зай, түүнийг эзлэн орших материаллаг бүх зүйлс /бүх төрлийн чулуулаг, ашигт малтмал болон геологийн бусад биет, түүнчлэн барилга байгууламж/ -ийг газрын хэвлий гэнэ.

2. Газрын хэвлий нь ашиглаж байгаа эсэхээс үл хамааран бүхэлдээ улсын нэгдмэл санг бүрдүүлнэ.

*/Энэ зүйлийг 1994 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

### **5 дугаар зүйл. Газрын хэвлийг ашиглах, хамгаалах талаархи төрийн удирдлага**

*/Энэ зүйлийг 1994 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/*

### **6 дугаар зүйл. Газрын хэвлийг ашиглах, хамгаалах талаархи үйл ажиллагааг төрөөс удирдах**

1. Улсын Их Хурал газрын хэвлийг ашиглах, хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ газрын хэвлийг ашиглах, хамгаалах талаархи төрийн бодлогыг тодорхойлох;

- 2/ газрын хэвлийн улсын нэгдмэл санг захиран зарцуулах бодлогын үндсийг тодорхойлж, чиглэлийг тогтоох;
- 3/ хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.
2. Засгийн газар газрын хэвлийг ашиглах, хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
- 1/ газрын хэвлийг ашиглах, хамгаалах талаархи төрийн бодлогыг хэрэгжүүлж, газрын хэвлийн тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулж хангах;
- 2/ газрын хэвлийг ашиглах, хамгаалах техникийн нэгдсэн бодлогыг тодорхойлох;
- 3/ хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.
3. Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага газрын хэвлийг ашиглах, хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
- 1/ газрын хэвлийг ашиглах, хамгаалах талаархи төрийн бодлогыг хэрэгжүүлэх, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах;
- 2/ газрын хэвлийн баялаг, эрдэс түүхий эдийг зохистой ашиглах бодлогыг тодорхойлж хэрэгжүүлэх;
- 3/ газрын хэвлийг ашиглах, геологийн судалгаа хийх үйл ажиллагаанд төрийн хяналтыг хэрэгжүүлэх;
- 4/ ердийн ашигт малтмалаас бусад ашигт малтмалын орд ашиглахад зориулан аж ахуйн нэгж, байгууллагад зохих хууль тогтоомжийн дагуу уурхайн эдэлбэр олгох;
- 5/ хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.
4. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага газрын хэвлийг ашиглах, хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
- 1/ газрын хэвлийг ашиглах, хамгаалах талаархи төрийн бодлогыг хэрэгжүүлэх, газрын хэвлийг ашиглах үйл ажиллагааг байгаль орчинд сөрөг нөлөө багатайгаар хэрэгжүүлэхэд төрийн хяналт тавих;
- 2/ газрын хэвлийг зохистой ашиглуулах, хамгаалах бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;
- 3/ хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.
- /Энэ зүйлийг 1994 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

## **7 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Засаг даргын бүрэн эрх**

1. Аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал газрын хэвлийг ашиглах, хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
- 1/ нутаг дэвсгэртээ газрын хэвлийг ашиглах, хамгаалах талаархи төрийн бодлого, газрын хэвлийн тухай хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр болон гаргасан шийдвэрийнхээ биелэлтэд хяналт тавих;
- 2/ энэ хэсгийн 1-д заасан асуудлын талаар аймаг, нийслэлийн Засаг даргын тайлан, мэдээллийг хэлэлцэх.
2. Аймаг, нийслэлийн Засаг дарга газрын хэвлийг ашиглах, хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
- 1/ нутаг дэвсгэртээ газрын хэвлийг ашиглах, хамгаалах талаархи төрийн бодлогыг хэрэгжүүлж, газрын хэвлийн тухай хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, мөн хуульд заасан эрх хэмжээний дотор аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулж хангах;
- 2/ нутаг дэвсгэртээ хийгдсэн геологийн судалгааны болон нутаг

дэвсгэртээ оршиж байгаа ашигт малтмалын талаархи мэдээллийг зохих журмын дагуу холбогдох аж ахуйн нэгж, байгууллагаас гаргуулан авч танилцах;

3/ газрын хэвлийг ашиглах, хамгаалах ажилд хяналт шалгалт хийх;

4/ энэ хуулийн 21 дүгээр зүйлд заасан тохиолдолд газрын хэвлийг ашиглах эрхийг хуульд заасан эрх хэмжээнийхээ дотор дуусгавар болгох;

5/ газрын хэвлийг дур мэдэн ашиглах болон ашигт малтмал бүхий талбайд барилга байгууламж дур мэдэн барихыг зогсоох;

6/ хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

*/Энэ зүйлийг 1994 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

## **8 дугаар зүйл. Сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Засаг даргын бүрэн эрх**

1. Сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал газрын хэвлийг ашиглах, хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ нутаг дэвсгэртээ газрын хэвлийг ашиглах, хамгаалах талаархи төрийн бодлого, газрын хэвлийн тухай хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр болон гаргасан шийдвэрийнхээ биелэлтэд хяналт тавих;

2/ энэ хэсгийн 1-д заасан асуудлын талаар сум, дүүргийн Засаг даргын тайлан, мэдээллийг хэлэлцэх.

2. Сум, дүүргийн Засаг дарга газрын хэвлийг ашиглах, хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ нутаг дэвсгэртээ газрын хэвлийг ашиглах, хамгаалах талаархи төрийн бодлогыг хэрэгжүүлж, газрын хэвлийн тухай хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, мөн хуульд заасан эрх хэмжээнийхээ дотор сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулж хангах;

2/ нутаг дэвсгэртээ газрын хэвлийн баялгийг ашиглуулахтай холбогдуулан эдэлбэр газар олгох;

3/ ашигт малтмалын нөөцийг илрүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

4/ ердийн ашигт малтмал, газар доорхи цэнгэг усыг ашиглах тухай саналыг холбогдох байгууллагад тавих;

5/ ердийн ашигт малтмалын ордыг зохистой ашиглах болон газрын хэвлийг ашиглах явцад эвдэрсэн газрыг аюул осолгүй болгож, аж ахуйн хэрэгцээнд цаашид ашиглаж болохуйцаар засаж тохижуулахад хяналт тавих, засаж тохижуулсан газрыг хүлээн авах;

6/ хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

*/Энэ зүйлийг 1994 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

## **9 дүгээр зүйл. Газрын хэвлийг ашиглагч**

1. Газрын хэвлийг Монгол Улсын аж ахуйн нэгж, байгууллага, иргэд ашиглаж болно.

2. Монгол Улсын хууль тогтоомжид заасан тохиолдолд газрын хэвлийг гадаад улсын хуулийн этгээд, иргэн, харьяалалгүй хүнд зохих журмын дагуу ашиглуулж болно.

*/Энэ хэсгийг 1994 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

## **10 дугаар зүйл. Газрын хэвлийг ашиглах зориулалт**

1. Газрын хэвлийг дор дурдсан зориулалтаар ашиглуулахаар олгоно:

1/ геологийн судалгаа хийх;

2/ ашигт малтмал олборлох;

3/ ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар доор барилга байгууламж, түүний дотор нефть, хий, бусад бодис, материал хадгалах, хортой бодис, үйлдвэрлэлийн хаягдлыг хамгаалан булах, бохир ус зайлуулахад зориулан барилга байгууламж барих, ашиглах;

4/ аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн бусад хэрэгцээг хангах.

2. Газрын хэвлийд ашигт малтмалын хайгуул хийх, ашигт малтмал олборлохтой холбогдсон харилцааг Ашигт малтмалын тухай хуулиар зохицуулна.

*/Энэ хэсгийг 1994 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар нэмсэн/*

3. Газрын хэвлийг ашиглагчид нь газар эзэмшигч, ашиглагчдаас зохих журмын дагуу зөвшөөрөл авна.

*/Энэ хэсгийг 1994 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар нэмсэн/*

## **11 дүгээр зүйл. Газрын хэвлийг ашигласны төлбөр**

1. Газрын хэвлийг төлбөртэй ашиглана.

2. Газрын хэвлийг ашигласны төлбөрийн дээд, доод хэмжээг хуулиар тогтооно.

*/Энэ зүйлийг 1994 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

## **12 дугаар зүйл. Геологийн судалгаа хийхэд зориулан ашиглуулахаар газрын хэвлийг олгох**

1. Геологийн судалгаа хийх /геологийн тогтоц, ашигт малтмалын байршлын зүй тогтлыг судлан ордыг илрүүлж үнэлгээ өгөх, ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газрын хэвлийг ашиглах, уул-техникийн болон шаардлагатай бусад нөхцөлийг тодруулах зэрэг/ -эд зориулан ашиглуулахаар газрын хэвлийг олгох асуудлыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага шийдвэрлэнэ.

2. Геологийн судалгаа хийгч нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйл ажиллагаагаа явуулах тухайгаа сум, дүүргийн Засаг даргад бүртгүүлсний дараа ажлаа эхэлнэ.

*/Энэ зүйлийг 1994 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

## **13 дугаар зүйл. Ашигт малтмал олборлоход зориулан газрын хэвлийг олгох**

Уурхайн эдэлбэр олгосон тухай актыг үндэслэн ашигт малтмалыг олборлоход зориулан газрын хэвлийг олгоно.

## **14 дүгээр зүйл. Ашигт малтмалын ордыг ашиглахад зориулан уурхайн эдэлбэр олгох**

*/Энэ зүйлийг 1994 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/*

## **15 дугаар зүйл. Ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар ашиглуулахаар газрын хэвлийг олгох**

1. Ашигт малтмал олборлох, газар доор нефть, хий, бусад бодис, материал хадгалах, хортой бодис, үйлдвэрлэлийн хаягдлыг хамгаалан булах, бохир ус зайлуулахаас өөр зориулалтаар ашиглуулахаар газар доор барилга байгууламж

барих, ашиглахад зориулан газрын хэвлийг дор дурдсан байгууллага, албан тушаалтан олгоно:

1/ улсын болон аймаг, нийслэлийн чанартай барилга байгууламж барих, ашиглахад зориулан тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга;

2/ орон нутгийн чанартай барилга байгууламж барих, ашиглахад зориулан тухайн сум, дүүргийн Засаг дарга.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан барилга байгууламжийн ажлыг эхлэхдээ тухайн сум, дүүргийн Засаг даргад мэдэгдэнэ.

3. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага эзэмшил газрынхаа хилийн дотор ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар аж ахуйн болон ахуйн хэрэгцээндээ зориулан тухайн сум, дүүргийн Засаг даргаас тогтоосон журмын дагуу газрын хэвлийг ашиглах эрхтэй.

4. Газар доор нефть, хий, бусад бодис, материал хадгалах, хортой бодис, үйлдвэрлэлийн хаягдлыг хамгаалан булах, бохир ус зайлуулах зориулалттай барилга байгууламж барих, ашиглахад зориулан газрын хэвлийг тухайн аймаг, нийслэлийн Засаг даргын зөвшөөрлийг үндэслэн сум, дүүргийн Засаг дарга олгоно.

5. Газар доор нефть, хий, бусад бодис, материал хадгалах, хортой бодис, үйлдвэрлэлийн хаягдлыг булах, бохир ус зайлуулахдаа эрх бүхий төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон тусгай нөхцөл, шаардлага хангасан байвал зохино.

6. Хүн амын эрүүл мэнд, мал, ан амьтан, байгаль орчинд онцгой нөлөө бүхий хортой бодисыг хамгаалан булахад зориулан газрын хэвлийг ашиглуулах тухай асуудлыг Засгийн газар шийдвэрлэнэ.

7. Энэ зүйлийн 6 дахь хэсэгт заасан зориулалтаар газрын хэвлийг ашиглуулахыг Засгийн газраас зөвшөөрсөн тохиолдолд газрын хэвлийг аймаг, нийслэлийн Засаг дарга олгоно. Гүйцэтгэгч байгууллага нь хортой бодисыг хамгаалан булснаа байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлнэ.

*/Энэ зүйлийг 1994 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

**16 дугаар зүйл. Түгээмэл тархацтай ашигт малтмалын жагсаалт**

*/Энэ зүйлийг 1994 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/*

**17 дугаар зүйл. Түгээмэл тархацтай ашигт малтмалын ордыг ашиглахад зориулан уурхайн эдэлбэр олгох нөхцөл**

*/Энэ зүйлийг 1994 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/*

**18 дугаар зүйл. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс ердийн ашигт малтмал олборлох, газар доорхи цэнгэг усыг ашиглах**

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэд нь аж ахуйн болон ахуйн хэрэгцээндээ зориулан сум, дүүргийн Засаг даргын зөвшөөрлийг үндэслэн уурхайн эдэлбэр авахгүйгээр ердийн ашигт малтмал олборлох, газар доорхи цэнгэг усыг ашиглах эрхтэй.

**19 дүгээр зүйл. Газрын хэвлийг ашиглах хугацаа**

1. Газрын хэвлийг хугацаагүй буюу хугацаатайгаар ашиглалтад олгож болно.

2. Газрын хэвлийг урьдчилан тодорхой хугацаа тогтоолгүйгээр ашиглалтад олгосон бол хугацаагүй түрээслэн ашиглах гэнэ.

3. Газрын хэвлийг ашиглалтад хугацаатай олгох нийт хугацаа 30 жилээс

илүүгүй байна. Шаардлагатай бол тогтоосон хугацааг газрын хэвлийг түрээслэн ашиглуулахаар анх олгосон байгууллагын шийдвэрээр сунгаж болох бөгөөд нэг удаад сунгах хугацаа 20 жилээс дээшгүй байна.

4. Ашигт малтмалын ордыг ашиглах, хугацааг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад уурхайн эдэлбэрийн зөвшөөрлийг бүртгүүлсэн өдрөөс эхлэн тооцно.

*/Энэ зүйлийг 1994 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

## **20 дугаар зүйл. Газрын хэвлийг ашиглагчийн үндсэн эрх, үүрэг**

1. Ашиглагч нь газрын хэвлийг олгосон зориулалтын дагуу ашиглах үүрэг, эрхтэй.

2. Газрын хэвлийг ашиглагч нь дор дурдсан шаардлагыг хангах үүрэгтэй:

1/ газрын хэвлийн геологийн судалгааг бүрэн хийлгэж, зөв зохистой, иж бүрэн ашиглах, хамгаалах;

2/ газрын хэвлийг ашиглахдаа ажиллагчдын болон хүн амын аюулгүй байдлыг хангах;

3/ газрын хэвлийг ашиглахад үүсч болзошгүй хортой нөлөөнөөс хий мандлын агаар, газар, ой, ус, рашаан, мал ан амьтан, байгаль орчны бусад объект, барилга байгууламжийг найдвартай хамгаалах, түүнчлэн тусгай хамгаалалттай газар, байгалийн болон түүх, соёлын дурсгалт зүйлийн хадгалалт, хамгаалалтыг хангах;

4/ газрын хэвлийг ашиглах явцад эвдэрсэн газрыг аюул осолгүй болгож, цаашид ашиглаж болохуйцаар засаж тохижуулан анх зөвшөөрөл олгосон нутгийн захиргааны байгууллагад хүлээлгэн өгөх;

5/ газрын хэвлийг ашиглах үед илэрсэн үнэт металл, үнэт чулуу болон шинжлэх ухаан, түүх, соёлын үнэт зүйлийг улсад тушаах.

3. Газрын хэвлийг ашиглагчид нь газар өмчлөх, эзэмших, ашиглах талаархи бусдын эрхийг аливаа хэлбэрээр хөндөхгүй байх үүрэгтэй бөгөөд ийм зөрчлийн улмаас тэдгээрт учруулсан хохирлыг өөрийн хөрөнгө, зардлаар нөхөн төлнө.

*/Энэ хэсгийг 1994 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар нэмсэн/*

4. Төрийн болон ашиглагч бусад байгууллага, иргэдийн ашиг сонирхлыг хангахын тулд Монгол Улсын хууль тогтоомжид заасан тохиолдолд тухайн газрын хэвлийг ашиглагчийн эрхийг хязгаарлаж болно.

## **21 дүгээр зүйл. Газрын хэвлийг ашиглах эрхийг дуусгавар болгох үндэслэл, журам**

1. Газрын хэвлийг ашиглах эрхийг дор дурдсан тохиолдолд бүрэн буюу хэсэгчлэн дуусгавар болгоно:

1/ газрын хэвлийг цаашид ашиглах шаардлагагүй болсон;

2/ газрын хэвлийг ашиглахаар тогтоосон хугацаа дууссан;

3/ төрийн буюу олон нийтийн бусад хэрэгцээнд зориулан газрын хэвлийг буцаан авах зайлшгүй шаардлага гарсан;

4/ газрын хэвлийг ашиглаж байсан аж ахуйн нэгж, байгууллагыг татан буулгасан;

5/ хүн амын эрүүл мэндэд аюултай байдал бий болсон.

2. Хэрэв газрын хэвлийг ашиглагч нь дор дурдсан зөрчил гаргавал газрын хэвлийг ашиглах эрхийг дуусгавар болгож болно:

1/ газрын хэвлийг олгосноос хойш 3 жилийн хугацаанд ашиглаж эхлээгүй;

2/ газрын хэвлийг олгосон зориулалтаас өөрөөр ашигласан;

3/ энэ хуулийн 20 дугаар зүйлийн шаардлагыг биелүүлээгүй;

4/ газрын хэвлийг ашиглах, хамгаалах бусад журмыг өөр хэлбэрээр ноцтой зөрчсөн.

3. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэд газрын хэвлийг аж ахуйн болон ахуйн хэрэгцээндээ зориулан ашиглах талаар тогтоосон журам, нөхцөлийг зөрчвөл газрын хэвлийг ашиглах эрхийг нь дуусгавар болгож болно.

4. Газрын хэвлийг ашиглах эрхийг дуусгавар болгох өөр үндэслэлийг Монгол Улсын хууль тогтоомжоор тогтоож болно.

5. Газрын хэвлийг ашиглах эрхийг уурхайн эдэлбэр олгосон тухай акт буюу газрын хэвлийг ашиглуулах тухай зөвшөөрөл олгосон байгууллага нь акт буюу зөвшөөрлөө хүчингүй болгох замаар дуусгавар болгоно.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ ГАЗРЫН ХЭВЛИЙН ГЕОЛОГИЙН СУДАЛГАА**

### **22 дугаар зүйл. Газрын хэвлийн геологийн судалгаа хийхэд тавих үндсэн шаардлага**

Газрын хэвлийн геологийн судалгаа хийж байгаа Монгол Улсын аж ахуйн нэгж, байгууллага болон бусад байгууллага дор дурдсан үндсэн шаардлагыг хангасан байвал зохино:

1/ геологийн судалгааны ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй оновчтой, зөв зохистой, үр ашигтай хийх;

2/ газрын хэвлийн геологийн тогтоц, түүнчлэн хайгуул хийсэн ордыг ашиглах, ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар доор барилга байгууламж барих, ашиглахад нөлөөлдөг гидрогеологи, уул-техникийн болон бусад нөхцөлийг бүрэн судлах;

3/ үндсэн болон түүнтэй хамт орших ашигт малтмал, тэдгээрт байгаа бүрэлдэхүүн хэсгийг бүрэн илрүүлж, тэдгээрийн нөөцийн хэмжээ, чанар боловсруулах технологийг үнэн зөв тодорхойлох, ашигт малтмалын ордод геологи-эдийн засгийн үнэлгээ өгөх;

4/ геологийн судалгааны ажлыг ашигт малтмалын чанарыг бууруулахгүй, зүй бус хаягдал гаргахгүй аргаар хийх;

5/ газрын хэвлийгээс гаргасан чулуулаг, ашигт малтмалыг байгаль орчинд хортой нөлөө үзүүлэхгүйгээр хадгалж хамгаалах, тэдгээрийг цаашид ашиглах нөхцөлийг бүрдүүлэх;

6/ ордыг ашиглах үед болон аж ахуйн бусад зориулалтаар ашиглаж болох хайгуулын малталт, өрөмдлөгийн цооногийг хүн, мал, ан амьтанд аюулгүйгээр бүрэн бүтэн байлгах, харин ашиглахгүй хайгуулын малталт, өрөмдлөгийн цооногийг дарж цаашид ашиглаж болохуйцаар засаж тохижуулан тухайн сум, дүүргийн Засаг даргад хүлээлгэн өгч, геологийн судалгааны ажлын дүнгээ мэдээлж бүртгүүлэх;

7/ газрын хэвлийг цаашид судлах, ашигт малтмалын ордыг хайх, ашиглах, түүнчлэн газрын хэвлийг ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар ашиглахад хэрэглэж болох геологийн болон гүйцэтгэл-техникийн баримт бичиг, чулуулаг, хүдрийн дээж, цооногийн чөмөг, ашигт малтмалын сорьцын хувийг бүрэн бүтэн байлгах.

### **23 дугаар зүйл. Газрын хэвлийн геологийн судалгааны ажлын улсын тоо бүртгэл**

1. Газрын хэвлийн геологийн судалгааг зэрэгцэн хийхгүй байх зорилгоор геологийн судалгааны ажлыг улсын бүртгэлд бүртгэнэ.

2. Улсын бүртгэлд бүртгүүлэлгүйгээр геологийн судалгаа хийхийг хориглоно.

3. Газрын хэвлийн геологийн судалгааны үр дүнг нэгтгэн ашиглах зорилгоор геологийн судалгааны ажлын үр дүн, уг ажлын явцад илрүүлсэн ашигт малтмалын орд, илрэлийн улсын тоо бүртгэл хөтөлнө.

#### **24 дүгээр зүйл. Эрдэс түүхий эдийн жишиг**

1. Ордын үйлдвэрлэлийн үнэт чанарыг тодорхойлох, түүний ашигт малтмалын нөөцийг тооцохын тулд эрдэс түүхий эдийн жишгийг орд тус бүрээр тогтооно. Энэхүү жишиг нь ашигт малтмалын хэмжээ, чанар ордыг ашиглах уул-геологийн болон бусад нөхцөлд тавих эдийн засгийн үндэслэл бүхий шаардлагын цогц байвал зохино.

2. Эрдэс түүхий эдийн жишгийг үндсэн болон түүнтэй хамт орших ашигт малтмал, түүнчлэн тэдгээрт байгаа үнэт бүрэлдэхүүн хэсгийг бүрэн гүйцэд ашиглахаар тооцож боловсруулан батлуулна.

#### **~~25 дугаар зүйл. Ашигт малтмалын хайгуул хийсэн ордыг үйлдвэрийн ашиглалтад шилжүүлэх~~**

*/Энэ зүйлийг 1994 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/*

#### **~~26 дугаар зүйл. Ашигт малтмалын ордыг анхлан ивээгч~~**

*/Энэ зүйлийг 1994 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/*

### **ГУРАВДУГААР БҮЛЭГ**

## **АШИГТ МАЛТМАЛЫГ ОЛБОРЛОХ, ЭРДЭС ТҮҮХИЙ ЭДИЙГ БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН БОЛОН АШИГТ МАЛТМАЛ ОЛБОРЛОХООС ӨӨР ЗОРИУЛАЛТААР ГАЗАР ДООР БАРИХ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ ЗОХИОХ, ТЭДГЭЭРИЙГ БАРИХ, АШИГЛАЛТАД ОРУУЛАХ**

#### **27 дугаар зүйл. Ашигт малтмал олборлох үйлдвэрийн газрын болон ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар доор барих барилга байгууламжийн зураг төсөл зохиох**

1. Ашигт малтмал олборлох үйлдвэрийн газрын болон ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар доор барих барилга байгууламжийн зураг төслийг тэдгээрийг барихаар төлөвлөж байгаа талбайн газрын хэвлийн геологийн болон бусад судалгааны материалыг үндэслэн тухайн нутаг дэвсгэрийн хөгжлийн хэтийн төлөвийг харгалзан зохионо.

2. Ашигт малтмал олборлох үйлдвэрийн газрын зураг төслийг гагцхүү ашигт малтмалын нөөцийг нь баталж, ордыг үйлдвэрийн ашиглалтад зориулан шилжүүлж, ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийг нь баталсны дараа зохионо. Онцгой шаардлага гарвал ашигт малтмал олборлох аж ахуйн нэгж, байгууллагын зураг төслийг Засгийн газрын зөвшөөрснөөр ашигт малтмалын нөөц батлахаас өмнө зохиож болно.

*/Энэ хэсгийн сүүлчийн өгүүлбэрийг 1994 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

3. Ашигт малтмал олборлох үйлдвэрийн газрын болон ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар доор барих барилга байгууламжийн байршлыг тэдгээрийн зураг төслийн ажил эхлэхээс өмнө зохих нутгийн захиргааны байгууллага, геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон холбогдох бусад байгууллагатай тохиролцоно.

## **28 дугаар зүйл. Ашигт малтмал олборлох үйлдвэрийн газрын зураг төсөл зохиоход тавих үндсэн шаардлага**

1. Ашигт малтмал олборлох үйлдвэрийн газрын зураг төсөлд дор дурдсан үндсэн шаардлагыг тусгасан байвал зохино:

1/ газар дээрх болон доорхи үйлдвэрийн газрын барилга байгууламжийн байршлыг ашигт малтмалын нөөцийг үр ашигтай, зөв зохистой ашиглах шаардлагад нийцүүлэн тогтоох;

2/ үндсэн болон түүнтэй хамт орших ашигт малтмалын нөөц, тэдгээрт байгаа үйлдвэрлэлийн ач холбогдол бүхий бүрэлдэхүүн хэсгийг газрын хэвлийгээс эдийн засгийн хувьд илүү зохистой, гүйцэд гаргаж авах шаардлагыг хангахуйц ашигт малтмалын ордын нөөцийг олборлохоор нээх арга, ашиглах системийг сонгож тогтоох;

3/ ашигт малтмал олборлох тэргүүний техник технологийг нэвтрүүлэх;

4/ ашигт малтмалын ордыг ашиглах үед үржил шимтэй хөрсийг тусгайлан хуулж ашиглах буюу хадгалах, уулын малталтын чулуулгийг зөв зохистой ашиглах;

5/ үйлдвэрлэлийн явцад дайвраар олборлосон бөгөөд ашиглаагүй байгаа ашигт малтмал, түүнчлэн ашигтай бүрэлдэхүүн хэсгийг агуулсан үйлдвэрлэлийн хаягдлыг бүртгэн авч хадгалж хамгаалах;

6/ ашигт малтмал олборлох үйлдвэрийн газрыг барих, ашиглах явцад газрын хэвлийд геологийн судалгаа хийж геологи, маркшейдерийн баримт бичгийг бүрдүүлэх;

7/ хүн амын аюулгүй байдлыг хангах, газрын хэвлийн болон байгаль орчны бусад объект, барилга байгууламжийг хамгаалах.

## **29 дүгээр зүйл. Эрдэс түүхий эдийг боловсруулах үйлдвэрийн газрын болон ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар доор барих барилга байгууламжийн зураг төсөл зохиоход тавих үндсэн шаардлага**

1. Эрдэс түүхий эдийг боловсруулах үйлдвэрийн газрын болон ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар доор барих барилга байгууламжийн зураг төсөл энэ хуулийн 28 дугаар зүйлийн 7-д зааснаас гадна дор дурдсан шаардлагыг хангасан байвал зохино:

1/ олборлосон эрдэс түүхий эдээс үйлдвэрийн ач холбогдол бүхий бүрэлдэхүүн хэсгийг иж бүрэн, бүрэн гүйцэд ялган авч чадахуйц технологи хэрэглэх;

2/ боловсруулалтын хаягдлыг бүрэн гүйцэд ашиглах;

3/ ашигтай бүрэлдэхүүн хэсгийг агуулсан бөгөөд ашиглаагүй байгаа үйлдвэрлэлийн хаягдлыг бүртгэх, хадгалж хамгаалах.

2. Ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар доор барих барилга байгууламжийн зураг төсөл зохиох, барих, ашиглалтад оруулахдаа энэ зүйлийн холбогдох заалт болон энэ хуулийн 20 дугаар зүйлийн шаардлагыг хангасан байвал зохино.

## **30 дугаар зүйл. Барилга байгууламж барих, ашиглахад тавих үндсэн шаардлага**

Ашигт малтмал олборлох, эрдэс түүхий эдийг боловсруулах үйлдвэрийн газрын болон ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар доор барилга байгууламжийг энэ хуулийн 28, 29 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангаагүй зураг төслөөр барих, шинэчлэх, өргөтгөх, ашиглалтад оруулахыг хориглоно.

**ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ  
ГАЗРЫН ХЭВЛИЙГ АШИГТ МАЛТМАЛ  
ОЛБОРЛОХ ЗОРИУЛАЛТААР АШИГЛАХ**

*/Энэ бүлгийн гарчигт 1994 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

**31 дүгээр зүйл. Газрын хэвлийг ашигт малтмал олборлох зориулалтаар ашиглах журам**

1. Ашигт малтмал олборлох аж ахуйн нэгж, байгууллага батлагдсан зураг төсөл, уулын ажлын төлөвлөгөө, техник ашиглалтын журмын дагуу газрын хэвлийг ашиглана.

2. Ашигт малтмал олборлох аж ахуйн нэгж, байгууллагын техник ашиглалтын журмыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөлтэйгээр холбогдох төрийн захиргааны төв байгууллага батална.

3. Ашигт малтмал олборлох аж ахуйн нэгж, байгууллага нь байгаль орчныг бохирдуулсан, түүний баялгийг зүй бусаар ашигласан, гэмтээж сүйтгэсэн зэргээс учирсан хохирлыг арилгах үүрэгтэй.

*/Энэ зүйлийг 1994 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

**32 дугаар зүйл. Газрын хэвлийг ашигт малтмал олборлох зориулалтаар ашиглахад тавих үндсэн шаардлага**

*/Энэ зүйлийн гарчигт 1994 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

Газрын хэвлийг ашигт малтмал олборлох зориулалтаар ашиглахдаа дараахь үндсэн шаардлагыг хангасан байвал зохино:

*/Энэ хэсэгт 1994 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

1/ үндсэн болон түүнтэй хамт орших ашигт малтмал, түүний үйлдвэрлэлийн ач холбогдол бүхий бүрэлдэхүүн хэсгийг үр ашигтай иж бүрэн, бүрэн гүйцэд олборлох аргыг хэрэглэх;

2/ ашигт малтмалын хаягдал, бохирдлыг тогтоосон хэмжээнээс хэтрүүлэхгүй байх, ордын зөвхөн баялаг хэсгийг нь сорчлон олборлохгүй байх;

3/ ашигт малтмалын ордод хийвэл зохих гүйцээх болон ашиглалтын хайгуул, геологийн бусад ажил, түүнчлэн ашиглалтын геологи, маркшейдерийн ажлыг бүрэн гүйцэтгэж, техникийн зохих баримт бичгийг гүйцэд хөтлөх;

4/ ашигт малтмалын нөөцийн байдал, хөдөлгөөн, хаягдал, бохирдлыг тооцож байх;

5/ уулын ажлын явцад ашиглаж байгаа болон түүнтэй зэрэгцэн оршиж байгаа ордыг гэмтээхгүй байх, нөөцөд үлдээсэн ашигт малтмалыг хадгалж хамгаалах;

6/ үйлдвэрлэлийн явцад дайвраар олборлосон бөгөөд ашиглаагүй байгаа ашигт малтмал, ашигтай бүрэлдэхүүн хэсгийг агуулсан үйлдвэрлэлийн хаягдлыг бүртгэх, хадгалах;

7/ уулын малталтын чулуулаг, үржил шимтэй хөрс, үйлдвэрлэлийн хаягдлыг зөв зохистой ашиглах байршуулах;

8/ ажиллагчид болон хүн амын аюулгүй байдлыг хангах, газрын хэвлий,

байгаль орчны бусад объект, барилга байгууламжийг хамгаалах, аюул ослоос урьдчилан сэргийлэх, аюул ослын үр дагаврыг арилгах төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэх, ордыг ашиглаж дууссаны дараа тогтоосон журмын дагуу дарах буюу улс ардын аж ахуйн хэрэгцээнд цаашид ашиглаж болохуйцаар засаж тохижуулах.

### **33 дугаар зүйл. Эрдэс түүхий эдийг боловсруулахад тавих үндсэн шаардлага**

Эрдэс түүхий эдийг боловсруулахдаа дор дурдсан үндсэн шаардлагыг хангасан байвал зохино:

1/ эрдэс түүхий эдэд байгаа ашигтай бүрэлдэхүүн хэсгийг иж бүрэн, бүрэн гүйцэд ялган авах технологи хэрэглэх;

2/ эрдэс түүхий эдийн ашигтай бүрэлдэхүүн хэсгийн ялгарцын түвшин, хэмжээг боловсруулалтын шат бүрт бүртгэж, хяналт тавьж байх;

3/ эрдэс түүхий эдийн найрлага, технологийн шинж чанарыг цаашид судлан, боловсруулалтын технологийг боловсронгуй болгох;

4/ эрдэс түүхий эдийг боловсруулахад гарсан хаягдлыг ашиглах;

5/ ашигтай бүрэлдэхүүн хэсгийг агуулсан бөгөөд ашиглаагүй байгаа үйлдвэрлэлийн хаягдлыг бүртгэн тооцож хамгаалж байх.

### **~~34 дүгээр зүйл. Ашигт малтмал олборлох үйлдвэрийн газрыг өөрчлөн байгуулах, татан буулгах, нөөцөд үлдээх~~**

*/Энэ зүйлийг 1994 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/*

### **35 дугаар зүйл. Түрээслэгч нь газрын хэвлийг бусдад ашиглуулах**

Уурхайн эдэлбэр түрээслэгч нь ордыг үйлдвэрлэлийн аргаар ашиглах боломжгүй болох нь тогтоогдсон хэсгийг аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд ажил гүйцэтгэх гэрээгээр ашиглуулж болно.

*/Энэ зүйлийг 1994 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

## **ТАВДУГААР БҮЛЭГ ГАЗРЫН ХЭВЛИЙГ АШИГТ МАЛТМАЛ ОЛБОРЛОХООС ӨӨР ЗОРИУЛАЛТААР АШИГЛАХ**

### **36 дугаар зүйл. Газрын хэвлийг ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар ашиглах журам**

1. Ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар доор барилга байгууламж барих, ашиглах болон бусад ийм зорилгоор газрын хэвлийг ашиглахдаа эрх бүхий байгууллагын зөвшөөрч баталсан зураг төслийг баримтална.

2. Зураг төсөлд үйлдвэрлэлийн хаягдал, бохир ус, хортой болон бусад бодисыг хор хөнөөлгүй болгох буюу тэдгээрийг тогтоосон хилийн дотор тусгайлан хадгалж хамгаалах, газрын гадарга, уулын малталт, усны объектод нэвтрэхээс сэргийлэх арга хэмжээг тусгана.

3. Энэ зүйлд заасан шаардлагыг зөрчсөн тохиолдолд геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон тусгай эрх бүхий төрийн бусад байгууллага нь үйлдвэрлэлийн хаягдал, бохир ус, хортой болон бусад бодисыг газар доор хамгаалан булах буюу урсгах, хадгалахыг таслан зогсоох, хориглох үүрэгтэй.

## **ЗУРГАДУГААР БҮЛЭГ ГАЗРЫН ХЭВЛИЙГ АШИГЛАХ АЖЛЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛ**

### **37 дугаар зүйл. Газрын хэвлийг ашиглах ажлын аюулгүй байдлыг хангах**

1. Ашигт малтмал олборлох үйлдвэрийн газрыг болон ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар доор барилга байгууламжийг барих, шинэчлэх, өргөтгөх, ашиглах, геологи хайгуулын болон газрын хэвлийг ашиглахтай холбогдсон бусад ажил гүйцэтгэхдээ хүн амын аюулгүй байдлыг хангах, ажиллагчдын амь нас, эрүүл мэндийг хамгаалах шаардлагыг хангасан байвал зохино.

2. Газрын хэвлийг ашиглаж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад аюулгүй ажиллагааны дүрэм, хэм хэмжээний биелэлтийг хангах үүргийг тэдгээрийн эрх баригчид хүлээх бөгөөд тухайн аж ахуйн нэгж, байгууллагын салбар, нэгж бүрт уг дүрэм, хэм хэмжээний биелэлтэд хяналт тавих ажлыг тодорхой ажилтанд тухайлан хариуцуулсан байвал зохино.

### **38 дугаар зүйл. Газрын хэвлийг ашиглах явцад аюулгүй байдлыг хангах үндсэн шаардлага**

1. Газрын хэвлийг ашиглахдаа дор дурдсан үндсэн шаардлагыг хангасан байвал зохино:

1/ аюулгүй ажиллагааны дүрэм, хэм хэмжээг бүх ажилчин, албан хаагчдаар судлуулж мөрдүүлэх;

2/ аюул ослоос урьдчилан сэргийлэх, аюул ослын үр дагаврыг арилгах арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх;

3/ ажиллагчдын амь насанд аюултай нөхцөл байдал бий болсон тохиолдолд ажлаа зогсоож, тэднийг аюулгүй газарт гаргаж, уг нөхцөл байдлыг арилгаж хэвийн болгох шаардлагатай арга хэмжээг шуурхай авах;

4/ аюулгүй ажиллагааны болон ариун цэврийн дүрэм, хэм хэмжээний шаардлагад тохирсон машин техник, тоног төхөөрөмж, материал, ажлын тусгай хувцас, бие хамгаалах бусад хэрэгслээр хангаж хэрэглүүлж байх;

5/ тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг зохих ёсоор бүртгэн тооцох, хадгалах, зарцуулах, аюул осолгүй хэрэглэх.

2. Уулын ажил эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага нь уурхайн доторхи агаарын найрлагыг сайжруулах, уулын ажлын технологи, аюулгүй ажиллагааны арга, техник хэрэгслийг боловсронгуй болгох асуудлыг тусгасан, мэргэжлээс шалтгаалах өвчин, үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн техник, зохион байгуулалтын иж бүрэн арга хэмжээ авч уулын ажил гүйцэтгэдэг ажилтан, албан хаагчдын аюул осолгүй, хэвийн ажиллаж, амьдрах нөхцөл болон ариун цэврийн дүрэм, хэм хэмжээг байнга боловсронгуй болгож байна.

*/Энэ хэсгийг 1994 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

~~3. /Энэ хэсгийг 1994 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/~~

4. Уулын малталт нь газар доор ажиллаж байгаа хүмүүсийн амь нас, эрүүл мэндэд аюул учруулж болохоор буюу уурхайн доторхи агаарын хүчилтөрөгч, хортой болон тэсрэх аюултай хий, тоосны хэмжээ, түүнчлэн агаарын халуун, хүйтэн нь аюулгүй ажиллагааны болон ариун цэврийн дүрэм, хэм хэмжээний шаардлагад тохирохгүй байвал уулын ажил гүйцэтгэхийг хориглоно.

5. Уулын болон тэсэлгээний ажил удирдахыг зохих тусгай мэргэжлийн ажилтанд, тэсэлгээний ажил хийхийг тийм ажил эрхлэн гүйцэтгэх эрх бүхий хүмүүст тус тус зөвшөөрнө.

### **39 дүгээр зүйл. Уулын ажил гүйцэтгэж байгаа хүмүүсээс аюулгүй ажиллагааны дүрэм, хэм хэмжээг сахин биелүүлэх талаар гүйцэтгэх үүрэг**

Уулын ажил гүйцэтгэж байгаа хүмүүс дор дурдсан үүрэгтэй байна:

1/ аюулгүй ажиллагааны дүрэм, хэм хэмжээний шаардлагыг чанд сахин биелүүлэх;

2/ ажлын байр, тоног төхөөрөмжийг тогтмол шалган, аюулгүй ажиллагааны дүрэм, хэм хэмжээг гажуудуулсан зөрчлийг нэн даруй арилгах арга хэмжээ авах;

3/ ажил дээрээ тусгай хувцас, бие хамгаалах хэрэгслийг зөв хэрэглэх;

4/ ажил гүйцэтгэхдээ аюул осол, золгүй тохиолдолд хүргэж болзошгүй арга хэрэглэхийг цээрлэх;

5/ аюул осол гарч болох нөхцөл байдал бүрдвэл ажлаа зогсоож, энэ тухай ажил удирдаж байгаа хүнд нэн даруй мэдэгдэж, аюул ослоос урьдчилан сэргийлэх, аюул ослын үр дагаврыг арилгах төлөвлөгөөг чанд баримтлан ажиллах.

### **40 дүгээр зүйл. Уул уурхайн аврах алба**

1. Уулын ажлын аюул ослоос урьдчилан сэргийлэх, аюул ослын үр дагаврыг арилгах үүрэг бүхий уул уурхайн аврах албыг тусгай дүрмийн дагуу байгуулж ажиллуулна.

2. Ашигт малтмал олборлох аж ахуйн нэгж, байгууллага энэхүү албаны үйлчилгээнд хамрагдана.

3. Уул уурхайн аюул ослоос аврах үйл ажиллагааны дүрмийг холбогдох яам, тусгай газар, геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай тохиролцож батална.

*/Энэ хэсгийг 1994 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

4. Ашигт малтмал олборлох үйлдвэрийн газарт аюул осол гарсан тохиолдолд нутгийн захиргааны байгууллага, түүнчлэн аж ахуйн нэгж, байгууллага харьяалал харгалзахгүйгээр тээврийн хэрэгсэл, материал тоног төхөөрөмж, эмийн зүйл олгох, холбооны хэрэгслээр үйлчлэх, аюул ослын үр дагаврыг арилгахад шаардагдах бусад тусламж үзүүлэх үүрэгтэй.

## **ДОЛДУГААР БҮЛЭГ ГАЗРЫН ХЭВЛИЙГ ХАМГААЛАХ**

### **41 дүгээр зүйл. Газрын хэвлийг хамгаалах талаар тавих үндсэн шаардлага**

1. Монгол Улсын газрын хэвлий нь улсын хамгаалалтад байна.

2. Газрын хэвлийг хамгаалахдаа дор дурдсан үндсэн шаардлагыг хангасан байвал зохино:

1/ газрын хэвлийн геологийн судалгааг иж бүрэн гүйцэд хийх;

2/ газрын хэвлийг ашиглуулахаар олгох журмыг чанд сахин биелүүлэх, түүнийг дур мэдэн ашиглах явдлыг гаргуулахгүй байх;

3/ үндсэн болон түүнтэй хамт орших ашигт малтмал, тэдгээрт байгаа бүрэлдэхүүн хэсгийн нөөцийг зөв зохистой, и ж бүрэн, бүрэн гүйцэд ашиглах;

4/ ашигт малтмалын нөөцийг ашиглахад үүсч болзошгүй аюул, хортой нөлөөнөөс газрын хэвлийг хамгаалах;

5/ ашигт малтмалын ордыг усанд автах, үер, гал түймрээс болон ашигт малтмалын чанар, ордын үйлдвэрийн үнэт чанарыг бууруулах буюу түүнийг

ашиглалтыг хүндрүүлж болох бусад хүчин зүйлээс сэргийлэн хамгаалах;  
6/ ашигт малтмал бүхий талбайд барилга байгууламж дур мэдэн барих, уг талбайг ашиглах талаар тогтоосон журмыг зөрчихөөс урьдчилан сэргийлэх;

7/ ашиглаж байгаа болон нөөцөд үлдээсэн уулын малталт, өрөмдлөгийн цооног, түүнчлэн газар доорхи барилга байгууламжийн бүрэн бүтэн байдлыг газрын хэвлий ашиглах явцад үүсч болзошгүй аюул, хортой нөлөөнөөс хамгаалах.

8/ газар доор нефть, хий, материалыг хадгалах, хортой болон бусад бодис, үйлдвэрлэлийн хаягдлыг хамгаалан булах, бохир ус зайлуулах үед газрын хэвлий бохиртохоос сэргийлэх.

3. Энэ зүйлд заасан шаардлагыг зөрчсөн тохиолдолд геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тусгай эрх бүхий төрийн бусад байгууллага газрын хэвлийг ашиглахыг Монгол Улсын хууль тогтоомжид заасан журмаар хязгаарлах, зогсоох буюу хориглох арга хэмжээ аван.

#### **41<sup>1</sup> дүгээр зүйл. Байгаль орчныг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх**

1. Газрын хэвлийг ашиглагч нь байгаль орчныг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэгтэй бөгөөд энэ зорилгоор газрын хэвлийг болон ашигт малтмалын ордыг ашиглах зураг төсөл, техникийн баримт бичигт экологийн магадлан шинжилгээ, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар хийлгэнэ.

2. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг үндэслэн байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг арилгах, ашигт малтмалын орд, түүний хэсэг дэр малтсан газрыг дарах буюу цаашид ашиглаж болохуйцаар засаж тохижуулах, хөрсийг нь нөхөн сэргээх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

3. Газрын хэвлийг ашиглагч энэ зүйлийн 1,2 дахь хэсэгт заасан арга хэмжээг хэрэгжүүлэх санхүүгийн баталгаа болгож мөнгөн барьцааг сум, дүүргийн нутгийн захиргааны байгууллагад шилжүүлнэ.

4. Мөнгөн барьцааны хэмжээ, түүнийг улсын орлого болгох асуудлыг Ашигт малтмалын тухай хуулиар зохицуулна.

*/Энэ зүйлийг 1994 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар нэмсэн/*

#### **42 дугаар зүйл. Ашигт малтмал бүхий талбайд барилга байгууламж барих нөхцөл**

1. Барилга байгууламж барих талбайн газрын хэвлийд ашигт малтмал байхгүй тухай дүгнэлтийг геологийн байгууллагаас авалгүйгээр хот, суурин газар, үйлдвэрийн цогцолбор, барилга байгууламжийн зураг төсөл зохиох буюу тэдгээрийг барихыг хориглоно.

2. Ердийн ашигт малтмалаас бусад ашигт малтмал бүхий талбайд барилга байгууламж барих, мөн ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар доор барилга байгууламж барих зөвшөөрлийг гагцхүү онцгой тохиолдолд геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно. Энэ тохиолдолд газрын хэвлийгээс ашигт малтмал олборлох боломжийг хангасан байвал зохино.

3. Ердийн ашигт малтмал бүхий талбайд барилга байгууламж барих, түүнчлэн ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар доор барилга байгууламж барих зөвшөөрлийн зохих нутгийн захиргааны байгууллага олгоно.

#### **43 дугаар зүйл. Шинжлэх ухаан, түүх, соёлын онцгой үнэт зүйлийг агуулсан газрын хэвлийн хэсгийг хамгаалах**

1. Геологийн ховор илэрц, эрдэсжилтийн онцгой тогтоц, палеонтологийн болон шинжлэх ухаан, түүх, соёлын хувьд онцгой үнэт зүйл бүхий газрын хэвлийн хэсгийг төрийн хамгаалалтад авна. Төрийн хамгаалалтад авсан газрын хэвлийн хэсгийн бүрэн бүтэн байдалд харшлах аливаа үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

2. Газрын хэвлийг ашиглах явцад геологийн ховор илэрц, эрдэсжилтийн онцгой тогтоц, солир, палеонтологи, археологийн болон шинжлэх ухаан, түүх соёлын хувьд сонирхол татах бусад зүйл илэрвэл газрын хэвлийг ашиглагчид ажлаа зогсоож, энэ тухай төрийн зохих байгууллагад нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

#### **44 дүгээр зүйл. Газрын хэвлийг хамгаалах, ашиглах арга хэмжээг хэрэгжүүлэхэд олон нийтийн байгууллага, хөдөлмөрийн хамт олон, иргэдийн оролцоо**

1. Олон нийтийн байгууллага, хөдөлмөрийн хамт олон нь хууль тогтоомж, дүрмийнхээ дагуу газрын хэвлийг хамгаалах, зохистой ашиглах арга хэмжээг хэрэгжүүлэхэд оролцож, төрийн байгууллагад тус дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.

*/Энэ хэсгийг 1994 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

2. Иргэд нь газрын хэвлийн хамгаалалт, ашиглалтыг сайжруулах тодорхой санал санаачилга гаргаж, энэ талаар илэрсэн зөрчлийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдээлж, таслан зогсоох болон төрийн байгууллагаас зохиож байгаа бусад ажилд идэвхтэй оролцож байвал зохино.

### **НАЙМДУГААР БҮЛЭГ. АШИГТ МАЛТМАЛЫН НӨӨЦ, ОРДЫН БОЛОН ГАЗРЫН ХЭВЛИЙН УЛСЫН ТОО БҮРТГЭЛ**

#### **45 дугаар зүйл. Ашигт малтмалын нөөц, ордын улсын тоо бүртгэл**

1. Ашигт малтмалын нөөц, орд, илрэлийг улсын нэгдсэн тоо бүртгэлд заавал бүртгэнэ.

2. Газрын хэвлийн геологийн судалгааг төлөвлөх, ашигт малтмал олборлох үйлдвэрийг байршуулах, ашигт малтмалын ордыг иж бүрэн, оновчтой ашиглах, түүнчлэн улс ардын аж ахуйн бусад зорилтыг шийдвэрлэх зорилгоор ашигт малтмалын ордын улсын данс хөтөлж, ашигт малтмалын нөөцийн улсын баланс зохионо.

3. Ашигт малтмалын нөөц, ордын болон газрын хэвлийн улсын тоо бүртгэл, ашигт малтмалын ордын данс, нөөцийн балансыг Улсын геологийн сан эрхлэн хөтөлнө.

*/Энэ хэсгийг 1994 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар нэмсэн/*

#### **46 дугаар зүйл. Ашигт малтмалын ордын улсын данс**

Ашигт малтмалын ордын улсын данс нь үндсэн болон түүнтэй хамт орших ашигт малтмал, тэдгээрт байгаа бүрэлдэхүүн хэсгийн нөөцийн хэмжээ, чанар, ордыг ашиглах уул-техник, гидрогеологийн болон бусад нөхцөл, түүний геологичдийн засгийн үнэлгээг орд тус бүрээр, ашигт малтмалыг илрэл бүрээр нь тусган харуулсан байвал зохино.

#### **47 дугаар зүйл. Ашигт малтмалын нөөцийн улсын баланс**

Ашигт малтмалын нөөцийн улсын балансад үйлдвэрийн ач холбогдол бүхий орд тус бүрийн байршил, ашигт малтмалын нөөцийн хэмжээ, чанар, судалсан байдал,

үйлдвэрлэлийн ашиглалтын түвшин, олборлолт, хаягдлын тухай болон хайгуул хийсэн ашигт малтмалын нөөцөөр үйлдвэрийг хэрхэн хангасныг тусган харуулна.

#### **48 дугаар зүйл. Ашигт малтмалын нөөцийн үнэмшлийг тогтоох**

Газрын хэвлийн хайгуул хийсэн ордын ашигт малтмалын нөөцийг үнэн зөв байдал, тоо хэмжээ, чанар, орших нөхцөл, судалгааны түвшин, эдийн засгийн ач холбогдол, ордыг үйлдвэрлэлийн ашиглалтад бэлтгэсэн байдалд Улсын геологийн сан, мэдээллийн байгууллага магадлан шинжилгээ хийж үнэмшлийг тогтооно.

*/Энэ зүйлийг 1994 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

#### **49 дүгээр зүйл. Ашигт малтмалын нөөцийг балансаас хасах**

Олборлосон ашигт малтмалыг, түүнчлэн үйлдвэрийн ач холбогдлоо алдсан, олборлолтын явцад хаягдсан, геологи, хайгуулын цаашдын ажлын буюу орд ашиглах явцад нотлогдоогүй ашигт малтмалын нөөцийг улсын балансаас хасах асуудлыг уг нөөцийг баталсан байгууллага шийдвэрлэнэ.

#### **50 дугаар зүйл. Ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар ашиглах газрын хэвлийн улсын тоо бүртгэл**

Ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар ашиглах газрын хэвлийн улсын тоо бүртгэлийг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эрхлэн хөтөлнө.

### **ЕСДҮГЭЭР БҮЛЭГ ГАЗРЫН ХЭВЛИЙН АШИГЛАЛТ, ХАМГААЛАЛТ ГЕОЛОГИЙН СУДАЛГААНЫ АЖИЛД ТАВИХ ХЯНАЛТ**

#### **51 дүгээр зүйл. Газрын хэвлийн ашиглалт, хамгаалалт геологийн судалгаанд тавих төрийн хяналтын зорилт**

1. Газрын хэвлийн ашиглалт, хамгаалалтад тавих төрийн хяналтын зорилт нь тус улсын яам, тусгай газар, аж ахуйн нэгж, байгууллага, иргэн, түүнчлэн гадаад улсын хуулийн этгээд, иргэн, харьяалалгүй хүн хэвлийг ашиглах, хамгаалах талаар тогтоосон журмыг сахиж, түүнийг ашиглахад аюулгүй ажиллагааг хангах, болзошгүй аюул, хортой нөлөөнөөс хүн ам болон мал, ан амьтан, байгаль орчин, барилга байгууламжийг хамгаалах, сэргийлэх, уг аюул, хортой нөлөөг арилгах үүргийн биелэлтийг хангах, ашигт малтмалын нөөц, ордын болон газрын хэвлийн улсын тоо бүртгэлийн журам, түүнчлэн газрын хэвлийн тухай хууль тогтоомжийн бусад заалтыг хэрэгжүүлэх явдлыг хангахад оршино.

*/Энэ хэсгийг 1994 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

2. Газрын хэвлийн геологийн судалгаанд төрийн хяналтыг харьяалал харгалзахгүйгээр тавих бөгөөд түүний зорилт нь холбогдох аж ахуйн нэгж, байгууллагаас геологийн зураглал, эрэл, хайгуул, гидрогеологи, инженер-геологи, геофизик, геохимийн болон газрын хэвлийн геологийн судалгааны бусад ажлыг зохих ёсоор үр ашигтай гүйцэтгүүлэхэд оршино.

#### **52 дугаар зүйл. Газрын хэвлийн ашиглалт, хамгаалалт геологийн судалгаанд хяналт тавих байгууллага**

1. Геологи, уул уурхайн болон байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нутгийн захиргааны байгууллага газрын хэвлийн ашиглалт, хамгаалалт, геологийн судалгаанд тус тус хяналт тавина.

2. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, тэдгээрийн Засаг дарга нь газрын хэвлийн ашиглалт, хамгаалалтад тавих төрийн хяналтыг нутаг дэвсгэртээ эрх хэмжээнийхээ дагуу хэрэгжүүлнэ.

*/Энэ зүйлийг 1994 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

### **53 дугаар зүйл. Газрын хэвлийн ашиглалт, хамгаалалтад тавих төрийн хяналтыг хэрэгжүүлэх**

1. Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь дор дурдсан журам шаардлагын биелэлтийг хянаж, илэрсэн зөрчлийг арилгах, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна:

1/ ашигт малтмалын ордын ашиглалтын байдал, газрын хэвлийн хамгаалалтын шаардлагын биелэлт;

2/ олборлох үйлдвэрийн газар ашигт малтмалын нөөцийг бүртгэх, балансаас цаг тухайд нь хасах талаар тогтоосон журмыг биелүүлж байгаа байдал;

3/ газрын хэвлийг ашиглах аюулгүй ажиллагааны дүрэм, хэм хэмжээний биелэлт;

4/ газрын хэвлийг ашиглахад гарч болзошгүй аюул, хортой нөлөөнөөс хүн ам болон мал, ан амьтан, байгаль орчин, барилга байгууламж, ашиглаж байгаль болон нөөцөд үлдээсэн уулын малталт, өрөмдлөгийн цооногийг хамгаалах, аюул осолгүй байдлыг хангах арга хэмжээний биелэлт;

5/ газар доор хадгалсан нефть, хий, материал, хамгаалан булсан хортой болон бусад бодис, үйлдвэрлэлийн хаягдал, бохир ус газрын гадаргад болон уулын малталт, усны объектод нэвтрэхээс сэрэмжлэн хамгаалах талаар тогтоосон журам, тавьсан шаардлагын биелэлт;

6/ ашигт малтмалын орд ашиглах явцад геологи, маркшейдерийн ажил гүйцэтгэх зааврыг биелүүлж байгаа байдал.

2. Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дор дурдсан эрх эдэлнэ:

1/ аюулгүй ажиллагааны болон газрын хэвлийг хамгаалах журам, хэм хэмжээг зөрчсөн тохиолдолд түүнийг ашиглахтай холбогдсон ажлыг түр зогсоох;

2/ газрын хэвлийг дур мэдэн ашиглах болон ашигт малтмал бүхий талбайд барилга байгууламж дур мэдэн барихыг зогсоох;

3/ аюулгүй ажиллагааны болон газрын хэвлийг хамгаалах журмыг гажуудуулсан зөрчлийг арилгуулах тухай заавал биелүүлэх шаардлагыг холбогдох аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтанд тавьж биелэлтийг хангуулах;

4/ газрын хэвлийг ашиглах явцад гарсан аюул ослын нөхцөл, шалтгааныг шалган тогтоож, түүний дүнг үндэслэн холбогдох аж ахуйн нэгж, байгууллагын эрх баригчдаас заавал биелүүлбэл зохих заалт, шийдвэр гаргах.

3. Засгийн газар нь газрын хэвлийн ашиглалт, хамгаалалтад хяналт тавих үүргийг холбогдох бусад байгууллагад хариуцуулах замаар аюулгүй ажиллагааны болон газрын хэвлийг хамгаалах журам, хэм хэмжээг зөрчихөөс сэргийлэх, зөрчлийг таслан зогсоох арга хэмжээ авч хэрэгжүүлж болно.

*/Энэ хэсгийг 1994 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

#### **54 дүгээр зүйл. Газрын хэвлийн геологийн судалгаанд тавих улсын хяналтыг хэрэгжүүлэх**

1. Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь газрын хэвлийн геологийн судалгааны чиглэл, арга зүй, иж бүрэн байдал, чанарт хяналт тавина.

2. Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь геологийн судалгаатай холбогдуулан дараахь эрх эдэлнэ:

1/ газрын хэвлийд геологийн судалгаа хийх үед гарсан зөрчил, дутагдлыг арилгах талаар заавал биелүүлэх шаардлагыг холбогдох аж ахуйн нэгж, байгууллагад тавьж, биелэлтийг нь хангуулах;

2/ газрын хэвлийн геологийн судалгаа нь баталсан зураг төсөлд тохироогүй буюу түүнийг улсын бүртгэлд бүртгүүлээгүй, түүнчлэн энэ ажлыг хийх журам, хэм хэмжээг зөрчсөн байвал түүнийг зогсоох.

*/Энэ хэсгийг 1994 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

3. Засгийн газар нь газрын хэвлийд геологийн судалгаа хийх хэм хэмжээг зөрчихөөс сэргийлэх, зөрчлийг таслан зогсоохтой холбогдсон бусад журам тогтоож болно.

*/Энэ хэсгийг 1994 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

#### **55 дугаар зүйл. Газрын хэвлийн ашиглалт, хамгаалалтанд тавих дотоодын хяналт шалгалт**

1. Яам, тусгай газар, бусад байгууллага нь тус тусын харъяа аж ахуйн нэгж, байгууллагаас газрын хэвлийг ашиглах, хамгаалах, геологийн судалгаа хийх талаар тогтоосон журмыг сахин биелүүлэх, үндсэн болон түүнтэй хамт орших ашигт малтмал, тэдгээрт байгаа бүрэлдэхүүн хэсэг, эрдэс, түүхий эдийг бүрэн гүйцэд ялгаж авах, газрын хэвлийг ашиглахад аюулгүй ажиллагааны шаардлагыг биелүүлэх, хүн амын аюулгүй байдлыг хангах, байгаль орчин, барилга байгууламжийг хамгаалах арга хэмжээ авч хэрэгжүүлэх, ашигт малтмалын нөөц, ордыг бүртгэх журам, түүнчлэн газрын хэвлийн хууль тогтоомжийн бусад заалтыг хэрхэн биелүүлж байгааг хянан шалгана.

2. Геологи, маркшейдерийн болон бусад алба нь ашигт малтмалын ордыг зөв ашиглаж байгаа эсэхэд хяналт тавина.

3. Геологи, маркшейдерийн албаны дүрмийг зохих яам, тусгай газар болон геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөж батална.

### **АРАВДУГААР БҮЛЭГ. ГАЗРЫН ХЭВЛИЙГ АШИГЛАХ АСУУДЛААР ГАРСАН МАРГААНЫГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ**

#### **56 дугаар зүйл. Маргааныг хянан шийдвэрлэх харьяалал**

1. Газрын хэвлийг ашиглах асуудлаар аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хооронд гарсан маргааныг дор дурдсан харьяаллын дагуу хянан шийдвэрлэнэ:

1/ нутаг дэвсгэрт нь ердийн ашигт малтмалыг олборлох зориулалтаар газрын хэвлийг ашиглах талаар болон энэ хуулийн 18 дугаар зүйлд заасан асуудлаар гарсан маргааныг аймаг, нийслэлийн Засаг дарга;

2/ ердийн ашигт малтмалаас бусад ашигт малтмалын ордыг ашиглах, түүнчлэн ашигт малтмалыг олборлохоос өөр зориулалтаар газрын хэвлийг ашиглах асуудлаар гарсан маргааныг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;

З/ газрын хэвлийд геологийн судалгаа хийх асуудлаар гарсан маргааныг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага.

2. Газрын хэвлийг ашиглах асуудлаар гарсан эд хөрөнгийн маргааныг шүүх хянан шийдвэрлэнэ.

*/Энэ хэсгийг 1994 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

### **57 дугаар зүйл. Газрын хэвлийг ашиглах асуудлаар гарсан маргааныг хянан шийдвэрлэх журам**

1. Газрын хэвлийг ашиглах асуудлаар гарсан маргааныг аль нэг талын хүсэлтээр буюу маргаан шийдвэрлэх байгууллагын санаачилгаар энэ хууль болон Монгол Улсын хууль тогтоомжийн холбогдох бусад актад заасан журмаар хянаж шийдвэрлэнэ.

2. Маргааныг хянан хэлэлцэж байгаа байгууллага зохих материал хүлээн авсан өдрөөс хойш нэг сарын дотор шийдвэр гаргах бөгөөд уг шийдвэрт гарсан зөрчлийг арилгах талаар авах арга хэмжээг заана.

## **АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ**

### **58 дугаар зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

1. Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

2. Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

*/Энэ зүйлийг 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

### **59 дүгээр зүйл. Хохирлыг нөхөн төлөх**

Газрын хэвлийн хууль тогтоомжийг зөрчсөний улмаас учруулсан хохирлыг аж ахуйн нэгж, байгууллага, иргэд Монгол Улсын хууль тогтоомжид заасан нөхцөл, журам, хэмжээгээр төлнө. Албан тушаалтан болон бусад ажилтны буруугаас учирсан хохирлыг аж ахуйн нэгж, байгууллага нөхөн төлсөн боол гэм буруутай хүмүүст тогтоосон журмын дагуу материалын хариуцлага хүлээлгэнэ.

### **60 дугаар зүйл. Газрын хэвлийг дур мэдэн ашиглах буюу ашигт малтмал бүхий талбайд барилга байгууламж дур мэдэн барихыг зогсоох**

Газрын хэвлийг дур мэдэн ашиглах буюу ашигт малтмал бүхий талбайд барилга байгууламж дур мэдэн барихыг гаргасан зардлыг нөхөн төлөхгүйгээр зогсоож болно.

## **АРВАН ХОЁРДУГААР БҮЛЭГ ӨЛӨН УЛСЫН ГЭРЭЭ**

*/Энэ бүлгийг 1994 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/*

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Н. БАГАБАНДИ

# ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН ТУХАЙ

1994 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр

Улаанбаатар хот

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ Нийтлэг үндэслэл

### 1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь байгалийн бүс, бүслүүрийн онцлог, өвөрмөц тогтоц, ховор, ховордсон ургамал, амьтан бүхий газар, түүх, соёлын дурсгалт болон үзэсгэлэнт газрын хэв шинжийг хадгалах, хувьсч өөрчлөгдөх зүй тогтлыг судлах, танин мэдэх зорилгоор газар нутгийг тусгай хамгаалалтад авах, ашиглах, түүний унаган төрхийг хадгалах, хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

### 2 дугаар зүйл. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль тогтоомж

1. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Газрын тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

*/Энэ хэсэгт 2014 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

### 3 дугаар зүйл. Тусгай хамгаалалттай газар нутгийн ангилал

1. Улсын тусгай хамгаалалттай газар нутгийг дараахь байдлаар ангилна:

- 1/ дархан цаазат газар;
- 2/ байгалийн цогцолборт газар;
- 3/ байгалийн нөөц газар;
- 4/ дурсгалт газар.

2. Аймаг, нийслэл, сум, дүүрэг өөрийн нутаг дэвсгэрт байгаа тодорхой газар нутгийг орон нутгийн тусгай хамгаалалтад авч болно.

### 4 дүгээр зүйл. Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүс

1. Улсын тусгай хамгаалалттай газар нутаг орчны бүстэй байж болно. Орчны бүсийн эрх зүйн байдлыг тусгай хуулиар зохицуулна.

*/ Энэ хэсгийг 1997 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/.*

2. Хуульд өөрөөр заагаагүй бол Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн заагийг зохих шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний Тэргүүлэгчдийн саналыг харгалзан тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага / цаашид "төрийн захиргааны төв байгууллага" гэх/ тогтооно.

*/Энэ хэсэгт 2014 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

### 5 дугаар зүйл. Улсын хилийн болон хил орчмын газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах

1. Улсын хил орчмын тодорхой нутаг дэвсгэрийг хил залгаа улстай тохиролцсоны үндсэн дээр улсын тусгай хамгаалалттай газар нутгийн ангилалд хамруулж болно.

2. Улсын хил орчмын газар нутгийг Улсын тусгай хамгаалалтад авах асуудлыг шийдвэрлэхдээ Улсын хил хамгаалах байгууллагатай урьдчилан зөвшилцсөн байна.

3. Улсын хил хамгаалах байгууллага нь зохих хууль тогтоомжийн дагуу улсын хилийн болон хил орчмын дэглэмд нийцүүлэн улсын хил дээрх болон улсын хил орчмын тусгай хамгаалалттай газар нутагт үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх журмыг хамгаалалтын захиргаа буюу зохих шатны Засаг даргатай тохиролцон тогтооно.

4. Тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалуулах зорилгоор хилийн төлөөлөгч, орлогч, туслагчид байгаль орчны хяналтын улсын байцаагчийн бүрэн эрхийг төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр олгож болно. Хилийн төлөөлөгч, орлогч, туслагч байгаль орчны хяналтын улсын байцаагчийн бүрэн эрхийг зөвхөн хилийн бүсэд хэрэгжүүлнэ.

## **6 дугаар зүйл. Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтыг санхүүжүүлэх**

1. Тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалах ажлын төсөв нь байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг нөхөн сэргээх, газрыг засаж тохижуулах арга хэмжээг хэрэгжүүлэх, мониторингийн аргаар судалгаа, шинжилгээ хийх, сурталчлах зардал, ажиллагсдын цалин хөлс зэргээс бүрдэнэ.

2. Тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалах ажлыг санхүүжүүлэх хөрөнгө нь дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:

- 1/ улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт;
- /Энэ заалтад 2003 оны 1 дүгээр сарын 2-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/*
- 2/ аялал, жуулчлалын болон бусад ажил, үйлчилгээний орлого;
- 3/ иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хандив, тусламж;
- 4/ тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдийн учруулсан хохирлын нөхөн төлбөрийн орлого.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ**

### **Дархан цаазат газар, түүний хамгаалалтын дэглэм**

#### **7 дугаар зүйл. Дархан цаазат газар**

Байгалийн бүс, бүслүүрийн онцлог, хэв шинжийг төлөөлж чадах унаган төрхөө хадгалсан байдал, шинжлэх ухааны онцгой ач холбогдлыг нь харгалзан байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах зорилгоор улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгийг дархан цаазат газар гэнэ.

#### **8 дугаар зүйл. Дархан цаазат газрын бүс**

Дархан цаазат газрыг байгалийн хэв шинж, төлөв байдал, хөрс, ус, ургамал, амьтны аймгийн онцлог, хүний үйл ажиллагаанд өртөх байдал зэргийг харгалзан дараахь бүсэд хуваана:

- 1/ онгон бүс;
- 2/ хамгаалалтын бүс;
- 3/ хязгаарлалтын бүс.

#### **9 дүгээр зүйл. Онгон бүсийн дэглэм**

1. Онгон бүсэд байгалийн унаган төрх, хэв шинжийг нь хадгалах шаардлагад нийцүүлж зөвхөн хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлнэ.

2. Онгон бүсэд байгалийн төлөв байдлыг нь хөндөхгүйгээр зөвхөн ажиглах хэлбэрээр судалгаа, шинжилгээний ажил явуулж болох бөгөөд үүнээс бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

## **10 дугаар зүйл. Хамгаалалтын бүсийн дэглэм**

Хамгаалалтын бүсэд энэ хуулийн 9 дүгээр зүйлд зааснаас гадна ургамал, амьтны аймгийн өсч үржих нөхцөлийг хангах, гамшгийн хор уршгийг арилгахтай холбогдсон биотехникийн арга хэмжээг байгаль орчинд сөрөг нөлөөгүй арга хэлбэрээр хэрэгжүүлнэ.

*/Энэ хэсэгт 2017 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

## **11 дүгээр зүйл. Хязгаарлалтын бүсийн дэглэм**

Хязгаарлалтын бүсэд байгаль орчинд нь сөрөг нөлөөгүй арга хэлбэрээр зохих зөвшөөрөлтэйгээр дараахь үйл ажиллагаа явуулж болно:

1/ энэ хуулийн 9,10 дугаар зүйлд заасан үйл ажиллагаа; 2/ хөрс, ургамлын бүрхэвчийг нөхөн сэргээх;

3/ ойд арчилгаа, цэвэрлэгээ хийх;

4/ ан амьтны тооллого, тэдгээрийн тоо, нас, хүйс, сүргийн бүтцийг зохицуулах үйл ажиллагааг батлагдсан хөтөлбөр, аргачлалын дагуу явуулах;

5/ рашаан, эмчилгээ, сувилгааны чанартай бусад эрдсийг ашиглах;

6/ байгалийн аялал, жуулчлалыг тогтоосон зам, чиглэлээр зохих журмын дагуу зохион байгуулах;

7/ аялагч, зөвшөөрөл бүхий бусад хүн түр буудаллах, отоглох, ажиглалт, судалгаа шинжилгээ хийх зориулалтаар зохих журмын дагуу барьсан орон байрыг ашиглах;

8/ зураг авах, дууны болон дүрс бичлэг хийх, тэдгээрийг зохиол бүтээл туурвихад ашиглах;

9/ уул, овоо тахих, уламжлалт зан үйлийн бусад ёслол үйлдэх;

10/ нутгийн оршин суугчид ахуйн хэрэгцээндээ зориулан байгалийн дагалт баялаг, эмийн болон хүнсний ургамлыг зохих журмын дагуу түүж ашиглах.

## **12 дугаар зүйл. Дархан цаазат газарт хориглох үйл ажиллагаа**

Дархан цаазат газарт энэ хуулийн 10,11 дүгээр зүйлд зааснаас өөр зориулалтаар дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

1/ газар хагалах, ухах, тэсэлгээ хийх, ашигт малтмал хайх, олборлох, элс, хайрга чулуу авах, мод, зэгс, шагшуурга бэлтгэх, хязгаарлалтын бүсээс бусад газарт зам тавих зэргээр байгалийн төлөв байдлыг өөрчлөх;

2/ байгалийн дагалт баялаг, эмийн, хүнсний болон техникийн зориулалттай ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар түүж бэлтгэх;

3/ энэ хуулийн 11 дүгээр зүйлийн 4-т зааснаас өөр зориулалтаар ан амьтан агнах, барих, үргээх, тэдгээрийн үүр, ичээ, нүх, ноохойг хөндөх, эвдэж сүйтгэх;

4/ хортон шавьж, мэрэгчид, түймэртэй тэмцэх, тэдгээрээс сэргийлэх арга хэмжээнд байгаль орчинд сөрөг нөлөөлөх арга, техник, бодис хэрэглэх;

5/ энэ хуулийн 11 дүгээр зүйлийн 7-д зааснаас өөр барилга байгууламж барих;

6/ хөрс, ус, агаар бохирдуулах аливаа үйл ажиллагаа явуулах;

7/ тухайн газрын хамгаалалтын захиргааны зөвшөөрөлгүйгээр нохой дагуулж, буу авч явах;

8/ аргагүйгээс бусад тохиолдолд тухайн газрын хамгаалалтын захиргаанаас урьдчилан авсан зөвшөөрөлгүйгээр агаарын хөлгөөр буулт хийх, хэт нам өндрөөр нислэг үйлдэх;

9/ өвөлжөө, хаваржаа, намаржаа, зуслангийн барилга байгууламж барих, зохих зөвшөөрөлгүйгээр мал бэлчээрлүүлэх;

10/ нуур, мөрөн, гол горхи, булаг, шанд зэрэг ил задгай усыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах;

11/ хууль тогтоомж болон хамгаалалтын горимоор хориглосон байгаль орчинд сөрөг нөлөөлөх бусад үйл ажиллагаа явуулах.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ**

### **Байгалийн цогцолборт газар, түүний хамгаалалтын дэглэм**

#### **13 дугаар зүйл. Байгалийн цогцолборт газар**

Байгалийн унаган төрхөө харьцангуй хадгалсан, түүх, соёл, шинжлэх ухааны болон танин мэдэхүй, экологийн хүмүүжилд ач холбогдол бүхий улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгийг байгалийн цогцолборт газар гэнэ.

#### **14 дүгээр зүйл. Байгалийн цогцолборт газрын бүс**

Байгалийн цогцолборт газрыг байгалийн хэв шинж, ургамал, амьтны аймгийн байршил, түүх, соёлын дурсгалыг нь хадгалах шаардлага, аялал, жуулчлал хөгжүүлэх нөхцөл зэргийг харгалзан дараахь бүсэд хуваана:

- 1/ онцгой бүс;
- 2/ аялал, жуулчлалын бүс;
- 3/ хязгаарлалтын бүс.

#### **15 дугаар зүйл. Онцгой бүсийн дэглэм**

Онцгой бүсэд байгалийн унаган төрхийг нь хадгалах шаардлагад нийцүүлэн хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэхийн зэрэгцээ байгальд сөрөг нөлөөгүй арга, хэлбэрээр судалгаа, шинжилгээний ажил явуулах, ургамал, амьтны өсч үржих нөхцөлийг хангах, хөрсийг нөхөн сэргээх, гамшгийн хор уршгийг арилгах арга хэмжээ авна.

*/Энэ хэсэгт 2017 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

#### **16 дугаар зүйл. Аялал, жуулчлалын бүсийн дэглэм**

Аялал, жуулчлалын бүсэд байгаль орчинд нь сөрөг нөлөөгүй арга хэлбэрээр зохих зөвшөөрөлтэйгээр дараахь үйл ажиллагаа явуулж болно:

- 1/ энэ хуулийн 11, 15 дугаар зүйлд заасан үйл ажиллагаа явуулах;
- 2/ зөвшөөрөгдсөн газар загас барих.

#### **17 дугаар зүйл. Хязгаарлалтын бүсийн дэглэм**

Хязгаарлалтын бүсэд дараахь үйл ажиллагаа явуулж болно:

- 1/ энэ хуулийн 11, 15, 16 дугаар зүйлд заасан үйл ажиллагаа;
- 2/ уламжлалт аргаар мал аж ахуй эрхлэх;
- 3/ аялагч, зөвшөөрөл бүхий бусад хүн ашиглах барилга байгууламжийг батлагдсан зураг, төсөл, зөвшөөрлийн дагуу барих;
- 4/ батлагдсан зураг төсөл, зохих журмын дагуу зам тавих, тээврийн хэрэгслийн зогсоол гаргах;
- 5/ биеийн тамир, нийтийн арга хэмжээнд шаардагдах талбайг засч тохижуулах;
- 6/ тухайн нутаг дэвсгэр дэх сууринг экологийн магадлан шинжилгээ хийж баталсан ерөнхий төлөвлөгөөний дагуу хөгжүүлэх.

#### **18 дугаар зүйл. Байгалийн цогцолборт газарт хориглох үйл ажиллагаа**

Байгалийн цогцолборт газарт энэ хуулийн 15, 16, 17 дугаар зүйлд зааснаас өөр зориулалтаар дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

- 1/ энэ хуулийн 12 дугаар зүйлийн 1-8, 11-т заасан үйл ажиллагаа явуулах;
- 2/ онцгой бүсэд энэ хуулийн 12 дугаар зүйлийн 9,10-т заасан үйл ажиллагаа явуулах;
- 3/ батлагдсан ерөнхий төлөвлөгөө, зураг төсвийг зөрчиж суурингийн нутаг дэвсгэрийг тэлэх, барилга байгууламж барих.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ**

### **Байгалийн нөөц газар, түүний хамгаалалтын дэглэм**

#### **19 дүгээр зүйл. Байгалийн нөөц газар**

Байгалийн тодорхой хэв шинж, аль нэгэн нөөц, баялгийг хамгаалах, хадгалах, нөхөн сэргээх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгийг байгалийн нөөц газар гэнэ.

#### **20 дугаар зүйл. Байгалийн нөөц газрын төрөл**

Байгалийн нөөц газрыг дараахь төрөлд хуваана:

- 1/ байгалийн унаган төрх, хэв шинжийг хадгалах зорилго бүхий байгалийн иж бүрдлийн нөөц газар;
  - 2/ ховор ховордсон ургамал, амьтныг хамгаалах, тэдгээрийн нөхөн үржих нөхцөлийг бүрдүүлэх зорилго бүхий биологийн нөөц газар;
  - 3/ эртний амьтан, ургамлын ховор олдворыг байгалийн байдлаар нь хадгалах зорилго бүхий байгалийн түүхэн олдворын нөөц газар;
  - 4/ газрын өвөрмөц тогтоц, илэрц, тэдгээрийн бүтцийг байгалийн байдлаар нь хадгалах зорилго бүхий геологийн нөөц газар;
  - 5/ Мөрөн, гол, усны эх үүсвэрийг хамгаалах зорилго бүхий усны нөөц газар.
- /Энэ заалтыг 2004 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар нэмсэн/*

#### **21 дүгээр зүйл. Байгалийн нөөц газрын дэглэм**

1. Байгалийн нөөц газарт хамгаалалтад авсан байгалийн хэв шинж, тодорхой баялгийн төрх байдал, ургамал, амьтны аймгийн байршил, өсөлт, үржилтэд сөрөг нөлөөгүйгээр уламжлалт аж ахуй эрхлэж болно.

2. Байгалийн нөөц газарт түүний байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй барилга байгууламж барих, үйлдвэрлэлийн зориулалтаар газар ухах, тэсэлгээ хийх, ашигт малтмал хайх, олборлох, ан амьтан агнах, барих, мод, зэгс, шагшуурга бэлтгэх зэргээр байгалийн унаган төрхийг өөрчлөх, голын усыг бохирдуулах аливаа үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

*/Энэ хэсэгт 2004 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар нэмэлт орсон/*

## **ТАВДУГААР БҮЛЭГ**

### **Дурсгалт газар, түүний хамгаалалтын дэглэм**

#### **22 дугаар зүйл. Дурсгалт газар**

Байгалийн өвөрмөц тогтоц, түүх, соёлын ул мөрийг уламжлагдан хадгалагдсан байгалийн байдлаар нь өвлөн үлдээх зорилгоор улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгийг дурсгалт газар гэнэ.

#### **23 дугаар зүйл. Дурсгалт газрын төрөл**

1. Дурсгалт газрыг дараахь төрөлд хуваана:
  - 1/ байгалийн дурсгалт газар;
  - 2/ түүх, соёлын дурсгалт газар;
  - 3/ дэлхийн болон үндэсний соёлын өвийн дурсгалт газар.

*/Энэ заалтыг 2014 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн хуулиар нэмсэн/*

2. Байгалийн дурсгалт газарт өвөрмөц тогтоц, илэрц бүхий газар, эртний ургамал, амьтны чулуужсан үлдэгдэл, давхаргазүйн тулгуур зүсэлт зэрэг эрдэс чулуулгийн ховор олдвор, хүрхрээ, хясаа, хавцал, агуй, хад цохио, явар, цонж, төгөл мод, рашаан булаг, баянбүрд, элсэн манхан, солир, солирын цар, өрх, галт уулын тогоо зэргийг хамааруулж болно.

*/Энэ хэсэгт 2014 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

3. Түүх, соёлын дурсгалт газарт эртний хүний оромж, отог, сууц, агуй, сүг зураг, хадны бичээс, буган ба хүн чулуун хөшөө, булш бунхан, эртний хот, суурины үлдэгдэл, балгас, хэрэм, цайз, суваг шуудуу, далан, эртний зэр зэвсэг хийж байсан орд, уламжлалт зан үйлтэй холбоотой уул, овоо, тахилга бүхий болон түүхэн чухал үйл явдал болсон газар зэргийг хамааруулж болно.

#### **24 дүгээр зүйл. Дурсгалт газрын дэглэм**

1. Дурсгал газарт хаалт, хашлага барих, сэрэмжлүүлсэн дохио, тэмдэг тавих, түүний хамгаалалтыг нутгийн оршин суугчдад хариуцуулан өгөх зэргээр хамгаалалтын арга хэмжээ авна.

2. Дурсгалт газар дахь байгалийн болон түүх, соёлын дурсгалт зүйлээс 0,1-3,0 км-ийн орчимд сүр бараа, үзэмжийг нь дарах барилга байгууламж барих, газар хагалах, ухах, тэсэлгээ хийх, ашигт малтмал хайх, олборлох, байгалийн болон түүх, соёлын дурсгалт зүйлийг хөндөх, эвдэх, буулгах, тэдгээрт хохирол учруулахуйц бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

3. Дэлхийн болон Үндэсний соёлын өвийн дурсгалт газрын хамгаалалтын дэглэмийг хуулиар тогтооно.

*/Энэ хэсгийг 2014 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн хуулиар нэмсэн/*

### **ЗУРГАДУГААР БҮЛЭГ**

#### **Тусгай хамгаалалттай газар нутгийн талаархи төрийн байгууллагын бүрэн эрх**

#### **25 дугаар зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрх**

Улсын Их Хурал тусгай хамгаалалттай газар нутгийн талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах талаар төрийн бодлогыг тодорхойлох;

2/ Засгийн газрын өргөн мэдүүлснээр газар нутгийг тусгай хамгаалалтад авах тухай шийдвэр гаргах, эдгээр газрыг улсын тусгай хамгаалалттай газар нутгийн тодорхой ангилалд хамааруулах, дархан цаазат болон байгалийн цогцолборт газрын хилийн заагийг батлах, өөрчлөх.

#### **26 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх**

Засгийн газар тусгай хамгаалалттай газар нутгийн талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ тусгай хамгаалалттай газар нутгийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулж хангах;

2/ тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалах эдийн засаг, зохион байгуулалтын тогтолцоог бүрдүүлж энэ асуудлаар Засгийн газрын болон Засгийн газрын бус байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулах;

3/ тусгай хамгаалалттай газар нутгийг гамшиг болон аюулаас сэргийлэх, тэдгээрээс учирсан хор уршгийг арилгахад иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүчийг нэгтгэн зохион байгуулж, шаардлагатай арга хэмжээ авах;

*/Энэ хэсэгт 2017 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

4/ тусгай хамгаалалттай газар нутаг, түүний орчны бүсийг хөгжүүлэх, экологийн аюулгүй байдал, байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах үндэсний хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;

5/ энэ хуульд заасан хамгаалалтын дэглэмийн хүрээнд тухайн дархан цаазат газар, байгалийн цогцолборт газрын хамгаалалтын горимыг батлах;

6/ байгалийн нөөц газрын болон дурсгалт газрын хилийн заагийг тогтоох.

## **27 дугаар зүйл. Тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх**

Тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ тусгай хамгаалалттай газар нутгийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

2/ тусгай хамгаалалттай газар нутагт явуулах судалгаа, шинжилгээний ажлын журам, хөтөлбөрийг батлах, зөвшөөрөл олгох, холбогдох тайлан, мэдээллийг авч нэгдсэн санд оруулах;

3/ биологийн төрөл зүйлд судалгаа, тооллого явуулах, бүртгэл хөтлөх аргачлал, хөтөлбөрийг батлах, зөвшөөрөгдсөн бүсээс ажиглалтын зориулалтаар дээж, сорьц авах, хэмжилт хийх, сүргийн бүтцийг зохицуулах зорилгоор ан амьтныг агнах, барих журам тогтоох;

4/ ойг арчлах, ойжуулах, хөрс, ургамлыг нөхөн сэргээх журам, хөтөлбөрийг баталж, нөхөн сэргээх газрын хэмжээ, уг ажлыг гүйцэтгэх арга, технологийг тогтоох;

5/ хортон шавьж, мэрэгчид, түймрээс сэргийлэх, тэдгээртэй тэмцэх журам, аргачлал тогтоох, гамшиг болон аюулаас тусгай хамгаалалттай газар нутагт учирсан хор уршгийг багасгах арга хэмжээ авах;

*/Энэ хэсэгт 2017 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

6/ рашаан, эмчилгээ, сувилгааны зориулалттай бусад эрдэс, байгалийн дагалт баялгийг ашиглах журам, эмийн, хүнсний болон техникийн зориулалттай ургамлын жагсаалт, тэдгээрийг түүж бэлтгэх журмыг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран тогтоох;

7/ аялал, жуулчлалын зам, чиглэл, журам тогтоох;

8/ тусгай хамгаалалттай газар нутгийн зөвшөөрөгдсөн бүс дэх суурин газрын ерөнхий төлөвлөгөө, шинээр байгуулах аялал, жуулчлалын бааз, амралт, сувиллын байршил, төслийг холбогдох төрийн захиргааны төв байгууллагуудтай хамтран хянан батлах;

9/ тусгай хамгаалалттай газар нутгийн зөвшөөрөгдсөн бүсэд тодорхой зориулалтаар ашиглаж болох газар, түүний хэмжээ, ашиглах журам, уг газарт байлгаж болох малын төрөл, тоог тогтоох;

10/ зохих шатны Засаг даргатай зөвшилцөн тухайн дархан цаазат газар, байгалийн цогцолборт газарт хамгаалалтын захиргаа байгуулах асуудлыг шийдвэрлэж, даргыг нь байгаль орчны мэргэжилтэй, тухайн салбарт 3-аас доошгүй жил ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас Төрийн албаны тухай хуулийн 17.1-д заасны дагуу сонгон шалгаруулж томилох;

*/Энэ заалтад 2006 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/*

11/ Усны нөөц доройтон хомсдож, бохирдох бодит аюул учирч байгаа улсын хэмжээний ач холбогдол бүхий том гол, сав газрыг улсын тусгай

хамгаалалтад авах асуудлыг зохих шатанд тавьж шийдвэрлүүлэх.  
*/Энэ заалтыг 2004 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар нэмсэн/*

### **28 дугаар зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх**

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тусгай хамгаалалттай газар нутгийн талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ өөрийн нутаг дэвсгэр дэх тусгай хамгаалалттай газар нутагт холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар Засаг даргын илтгэлийг хэлэлцэж зохих шийдвэр гаргах, түүний биелэлтийг хангуулах;

2/ нутаг дэвсгэрийнхээ тодорхой хэсгийг улсын тусгай хамгаалалтад авах тухай саналыг дээд шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал буюу Засгийн газарт уламжлах;

3/ нутаг дэвсгэрийнхээ тодорхой хэсгийг орон нутгийн хамгаалалтад авах тухай шийдвэр гаргах, түүний хилийн зааг, хамгаалалтын горимыг тогтоох.

### **29 дүгээр зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх**

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга тусгай хамгаалалттай газар нутгийн талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ тусгай хамгаалалттай газар нутгийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

2/ өөрийн нутаг дэвсгэрийн тодорхой хэсгийг улсын тусгай болон орон нутгийн хамгаалалтад авах талаар санал боловсруулж зохих байгууллагад уламжлах;

3/ байгалийн нөөц газар, дурсгалт газрын хамгаалалтыг эрхлэх.

### **30 дугаар зүйл. Дархан цаазат газар, байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны үйл ажиллагаа**

Дархан цаазат газар, байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа /цаашид “хамгаалалтын захиргаа” гэх/ нь дараахь үйл ажиллагаа явуулна:

1/ тусгай хамгаалалттай газар нутгийн талаарх хууль тогтоомж, тухайн газар нутгийн хамгаалалтын горимын биелэлтийг хангуулах;

2/ судалгаа, шинжилгээ хийх зөвшөөрөл авсан байгууллагатай гэрээ байгуулах, тухайн газар нутгийн хамгаалалтын горимын хүрээнд явуулж болох үйл ажиллагаанд зөвшөөрөл олгох, хяналт тавих;

3/ зохих журмын дагуу судалгаа, шинжилгээний зориулалтаар дээж, сорьц авах, ан амьтны сүргийн бүтцийг зохицуулах, байгалийн баялгийг нөхөн сэргээх, ойд арчилгаа, цэвэрлэгээ хийх;

4/ ан амьтанд зориулан ус задгайлах, хадлан бэлтгэх, өвс тэжээл, хужир, шүү тавих, нөмөр хорго барих болон биотехникийн бусад арга хэмжээг зохих журмын дагуу гүйцэтгэх;

5/ рашаан, эмчилгээ, сувилгааны зориулалттай эрдэс, байгалийн дагалт баялгийг зохих журмын дагуу ашиглуулах;

6/ зөвшөөрөгдсөн аялал, жуулчлалын зам, чиглэлийг тэмдэгжүүлэх, шаардлагатай орон байр барих, тээврийн хэрэгслэлийн зогсоол гаргах, биеийн тамирын болон нийтийн бусад арга хэмжээ явуулах газар, журмыг тогтоох, эрүүл ахуйн нөхцөлийг нь хангах, тэдгээрийг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран тохижуулах;

7/ зөвшөөрөгдсөн бүс дэх сууринг тохижуулах, барилга байгууламж барих ажлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж байгаад хяналт тавих;

8/ уул, овоо тахиx, уламжлалт зан үйлийн бусад ёслол үйлдэх ажиллагааг зохицуулах;

9/ тусгай хамгаалалттай газар нутгийн ач холбогдол, хамгаалалтын горим, холбогдох хууль тогтоомжийг сурталчлан таниулах, он дарааллын бичиг хөтлөх, мэдээллийн сан бүрдүүлэх;

10/ зөвшөөрөгдсөн бүсэд байлгаж болох малын төрөл, тоо болон зохих журмын дагуу иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад ашиглуулах газрыг тогтоох.

### **31 дүгээр зүйл. Байгаль хамгаалагчийн бүрэн эрх**

1. Хамгаалалтын захиргааны хамгаалалт хариуцсан ажилтан болон байгаль хамгаалагч нь байгаль орчны хяналтын улсын байцаагчийн эрх, үүрэгтэй байна.

2. Тусгай хамгаалалттай газар нутагт ажиллаж байгаа байгаль хамгаалагч дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ энэ хууль болон байгаль орчныг хамгаалах бусад хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг таслан зогсоож, гэм буруутай этгээдэд зохих хариуцлага хүлээлгэх;

2/ хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих зорилгоор аж ахуйн нэгж, байгууллагад нэвтрэн орох, шалгалт хийх;

3/ хууль тогтоомж зөрчсөн сэжиг бүхий иргэний бичиг баримтыг шалгах, түр хураах, шаардлагатай гэж үзвэл унаа хөсөгт нь үзлэг хийх, зэвсэг хэрэгсэл, агнасан, түүсэн, бэлтгэсэн зүйлийг хураан авах;

4/ хууль тогтоомж, хамгаалалтын горимыг зөрчиж байгаль орчинд сөрөг нөлөөлөх үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг түр зогсоох, тэдгээрт хугацаатай үүрэг, даалгавар өгөх, шаардлага тавих;

5/ албан үүргээ гүйцэтгэх үедээ дүрэмт хувцас, ялгах тэмдэг, зэвсэг, хэрэгсэлтэй байх.

### **32 дугаар зүйл. Байгаль хамгаалагч зэвсэг хэрэглэх**

1. Тусгай хамгаалалттай газар нутагт ажиллаж байгаа байгаль хамгаалагчийн хэрэглэх зэвсэг, хэрэгслийн төрөл, тэдгээрийг хэрэглэх журмыг төрийн захиргааны төв байгууллага цагдаагийн төв байгууллагатай зөвшилцөн тогтооно.

*/Энэ хэсэгт 2008 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

2. Байгаль хамгаалагч албан үүргээ гүйцэтгэж байх үедээ дараахь тохиолдолд зэвсэг хэрэглэж болно:

1/ байгаль хамгаалагчийн амь нас, эрүүл мэндэд гэмт этгээд хохирол учруулж болзошгүй байдал бодитоор бий болсон;

2/ байгаль хамгаалагчийн амь нас, эрүүл мэндэд хохирол учруулж болзошгүй байдлаар зэрлэг амьтан довтолсон.

## **ДОЛДУГААР БҮЛЭГ**

### **Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах, судалгаа, Шинжилгээний ажил явуулах**

### **33 дугаар зүйл. Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах**

1. Дархан цаазат газрын болон байгалийн цогцолборт газрын хязгаарлалтын бүс, байгалийн нөөц газар, дурсгалт газраас Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад тодорхой зориулалт, хугацаа, болзолтойгоор байгаль орчинд сөрөг нөлөөгүй арга, хэлбэрээр гэрээний үндсэн дээр ашиглуулж болно.

2. Тусгай хамгаалалттай газар нутагт гадаад улсын хуулийн этгээд олон улсын байгууллага, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид газар ашиглуулахыг хориглоно.

3.Энэ зүйлийн 2 дахь хэсгийн заалт нь гадаад улсын болон олон улсын байгууллага тусгай хамгаалалттай газрын зохих бүсэд энэ хуулиар зөвшөөрөгдсөн хүрээнд төслийн дагуу үйл ажиллагаа явуулахад хамаарахгүй.

### **34 дүгээр зүйл. Газар ашиглах хугацаа, газрын хэмжээ**

1. Энэ хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан газар ашиглах тухай гэрээний хугацаа 5 жилээс илүүгүй байх бөгөөд уг гэрээг нэг удаад сунгах хугацаа 5 жилээс илүүгүй байна.

2. Тухайн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад ашиглуулах газрын хэмжээг төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон хэмжээний дотор хамгаалалтын захиргаа буюу сум, дүүргийн Засаг дарга тогтооно.

### **35 дугаар зүйл. Газар ашиглах тухай хүсэлт гаргах**

1.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага Газрын тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 8 дахь хэсэгт заасан журмыг баримтлан газар ашиглах тухай хүсэлтээ хамгаалалтын захиргаа буюу хамгаалалтын захиргаа байгуулаагүй тусгай хамгаалалттай газар нутагт сум, дүүргийн Засаг даргад гаргана.

*/Энэ хэсэгт 2002 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн хуулиар нэмэлт орсон/*

2. Хамгаалалтын захиргаа буюу Засаг дарга нь газар ашиглах тухай иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлт болон түүний талаарх саналаа төрийн захиргааны төв байгууллагад уламжилна.

### **36 дугаар зүйл. Газар ашиглуулах тухай шийдвэр гаргах**

1. Төрийн захиргааны төв байгууллага нь дархан цаазат газрын болон байгалийн цогцолборт газрын хязгаарлалтын бүс, байгалийн нөөц газар, дурсгалт газраас иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар ашиглуулах тухай шийдвэрийг хамгаалалтын захиргаа болон сум, дүүргийн Засаг даргын саналыг үндэслэн гаргана.

2. Тухайн газрыг хоёр буюу түүнээс дээш этгээд ашиглах хүсэлт гаргавал газар ашиглалтын зориулалт, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, байгаль орчныг хамгаалах талаар авах арга хэмжээний зардал зэргийг харгалзан сонголт хийнэ.

3. Аялал, жуулчлал эрхлэх зориулалтаар газар ашиглах тухай хүсэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын аялал, жуулчлалын үйл ажиллагаа явуулах материаллаг баазыг олон улсын стандарт, түвшинд хүргэсэн байдлыг нь харгалзан сонголт хийнэ.

4. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан шийдвэрт ашиглуулах газрын зориулалт, орших бүс, байршил, зааг, хэмжээ, дангаар буюу дундаа ашиглах талаар тодорхой заана.

5. Газар ашиглуулахаас татгалзсан бол төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрт үүний шалтгаан, үндэслэлийг заана.

### **37 дугаар зүйл. Газар ашиглах тухай гэрээ**

1. Сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 36 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан шийдвэрийг үндэслэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай газар ашиглах тухай гэрээг өөрөө буюу хамгаалалтын захиргаатай хамтран байгуулна.

2. Газар ашиглах тухай гэрээнд Газрын тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 8 дахь хэсэгт зааснаас гадна дараахь зүйлийг тусгана:

*/Энэ хэсэгт 2002 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн хуулиар нэмэлт орсон/*

1/ тухайн газрын унаган төрхийг хадгалах, хамгаалах, нөхөн сэргээх талаар авах арга хэмжээ, түүнд зарцуулах хөрөнгө;

2/ газрын төлбөрийн хэмжээ, төлөх хугацаа;

3/ газрыг ашиглах, хамгаалах талаарх талуудын эрх, үүрэг, хариуцлага;

4/ гэрээ дуусгавар болсон тохиолдолд газрыг эргүүлж авах нөхцөл, журам, уг газрыг нөхөн сэргээх, засаж тохижуулах, хүлээлгэн өгөх журам.

### **38 дугаар зүйл. Газар ашиглагчийн эрх, үүрэг**

1. Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага Газрын тухай хуулийн 45 дугаар зүйлд заасан эрх эдэлнэ.

*/Энэ хэсэгт 2002 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн хуулиар нэмэлт орсон/*

2. Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага Газрын тухай хуулийн 45 дугаар зүйлд заасан үүргээс гадна дараахь үүрэг хүлээнэ:

*/Энэ хэсэгт 2002 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн хуулиар нэмэлт орсон/*

1/ тухайн газрын унаган төрхийг хадгалах, хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг өөрийн хөрөнгөөр гүйцэтгэх;

2/ ашиглахаар авсан газартаа тогтоосон замаар орж, гарах;

3/ хууль буюу гэрээнд заасан үйл ажиллагаа явуулахтай холбогдуулан ашиглаж байгаа газрынхаа төлөв байдал, ашиглалтын зориулалтыг өөрчлөхөд хүрвэл холбогдох зураг төслөө төрийн захиргааны төв байгууллагад танилцуулж зөвшөөрөл авах;

4/ газар ашиглах эрх дуусгавар болоход ашиглаж байсан газраа нөхөн сэргээх, засаж тохижуулан хамгаалалтын захиргаа буюу сум, дүүргийн Засаг даргад хүлээлгэн өгөх.

### **39 дүгээр зүйл. Газар ашиглагчид хориглох үйл ажиллагаа**

1. Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

1/ ашиглаж байгаа газраа бүхэлд нь буюу зарим хэсгийг бусдад дамжуулан ашиглуулах;

2/ энэ хууль болон тухайн тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын горимоор хориглосон, гэрээнд зааснаас өөр буюу байгаль орчинд сөрөг нөлөөлөх үйл ажиллагаа явуулах.

2. Ашиглагчаас газрыг хуульд заасан үндэслэлээр эргүүлж авах тохиолдолд тусгай хамгаалалттай газар нутгаас түүнд дахин газар олгохгүй байж болно.

### **40 дүгээр зүйл. Газар ашиглах эрх дуусгавар болох, газрыг чөлөөлөх**

1. Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах эрх дараахь тохиолдолд дуусгавар болно:

1/ Газрын тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасан үндэслэлээр;

*/Энэ заалтад 2002 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн хуулиар нэмэлт орсон/*

2/ тухайн тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын горимыг удаа дараа буюу ноцтой зөрчсөн.

2. Газар ашиглах эрх дуусгавар болоход иргэн, аж ахуйн нэгж, байгууллага ашиглаж байсан газраа чөлөөлж энэ хуулийн 37 дугаар зүйлд заасан гэрээнд өөрөөр заагаагүй бол 90 хоногийн дотор тухайн газар нутгийн хамгаалалтын захиргаа буюу сум, дүүргийн Засаг даргад хүлээлгэн өгнө.

### **41 дүгээр зүйл. Тусгай хамгаалалттай газар нутагт судалгаа, шинжилгээний ажил явуулах байгууллага, түүний үүрэг**

1. Тусгай хамгаалалттай газар нутагт төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авсан байгууллага, гадаадын болон олон улсын эрдэм шинжилгээний байгууллага судалгаа, шинжилгээний ажлыг гэрээний үндсэн дээр явуулж болно.

2. Тусгай хамгаалалттай газар нутагт судалгаа, шинжилгээ явуулах байгууллагын үүрэг:

1/ тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль тогтоомж, хамгаалалтын горимыг сахин биелүүлэх;

2/ судалгаа, шинжилгээний ажил явуулахдаа зохих зөвшөөрөл авах, хураамж төлөх;

3/ судалгаа, шинжилгээний ажлыг байгаль орчинд сөрөг нөлөөгүй аргаар гүйцэтгэх;

4/ судалгаа, шинжилгээний ажлын талаар хамгаалалтын захиргаа болон төрийн захиргааны төв байгууллагад тайлагнах;

5/ судалгаа, шинжилгээний ажлын явцад байгаль орчинд хохирол учруулсан бол түүнийг нөхөн сэргээх арга хэмжээ авч тухайн газар нутгийг хамгаалалтын захиргаа буюу сум, дүүргийн Засаг даргад хүлээлгэн өгөх.

## **НАЙМДУГААР БҮЛЭГ**

### **Бусад зүйл**

#### **42 дугаар зүйл. Төрийн хяналт**

1. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль тогтоомжийн биелэлтэд мэргэжлийн хяналтын байгууллага, хамгаалалтын захиргаа, бүх шатны Засаг дарга эрх хэмжээнийхээ хүрээнд хяналт тавина.

*/Энэ хэсэгт 2002 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/*

2. Байгаль орчны хяналтын улсын байцаагчид тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавьж, зөрчигчдөд эрх хэмжээнийхээ хүрээнд хариуцлага хүлээлгэнэ.

#### **43 дугаар зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

1. Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

*/Энэ зүйлийг 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

#### **44 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох**

Энэ хуулийг 1995 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Н. БАГАБАНДИ

# БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ

1995 оны 3 дугаар сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

### 1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, нийгэм, эдийн засгийн хөгжлийг байгаль орчны тэнцэлтэй уялдуулах, өнөө болон ирээдүйн үеийнхний ашиг сонирхлын үүднээс байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, жам ёсны боломжтойг нь нөхөн сэргээхтэй холбогдож төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

### 2 дугаар зүйл.Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж

1.Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

### 3 дугаар зүйл.Хуулиар хамгаалах объект, түүнтэй холбогдсон нэр томъёо

1.Энэ хуулиар байгалийн дор дурдсан объектыг байгаль орчинд хортой нөлөөлж болзошгүй үйл ажиллагаанаас хамгаалж, байгаль орчны тэнцэл алдагдахаас сэргийлнэ:

- 1/ газар, түүний хөрс;
- 2/ газрын хэвлий, түүний баялаг;
- 3/ ус;
- 4/ ургамал;
- 5/ амьтан;
- 6/ агаар.

2.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1/ "байгаль орчин" гэдэгт хүний амьдрал, үйл ажиллагаанд шууд болон шууд бусаар нөлөөлдөг Монгол Улсын нутаг дэвсгэрийн чулуун мандал, усан мандал, шим мандал, агаар мандлын харилцан шүтэлцээт хүрээлэл хамаарна;

2/ "ус" гэдэгт Монгол Улсын нутаг дэвсгэр дэх мөрөн, гол, горхи, булаг, шанд, рашаан, мөнх цас, мөс, мөсөн гол, байгалийн болон хиймэл нуур, цөөрөм зэрэг газрын гадаргын болон газрын доорхи ус хамаарна;

3/ "ургамал" гэдэгт Монгол Улсын нутаг дэвсгэрт ургадаг байгалийн болон таримал ой, мод, бүх төрлийн дээд, доод ургамал хамаарна;

4/ "амьтан" гэдэгт Монгол Улсын нутаг дэвсгэрт байнга буюу түр нутагшсан хөхтөн, шувуу, мөлхөгч, хоёр нутагтан, загас, хавч хэлбэртэн, шавьж, зөөлөн биетэн, эгэл биетэн хамаарна;

5/ "агаар" гэдэгт Монгол Улсын нутаг дэвсгэрийн хийн бүрхэвч хамаарна;

6/ "байгаль орчинд хортой нөлөөлөх" гэдэгт байгаль орчин, түүний

баялгийг бохирдуулах, муутгах, гэмтээх, сүйтгэх, сөнөөж мөхөөх үйлдэл / эс үйлдэхүй/ хамаарна.

7/ “байгаль орчныг хамгаалах” гэдэгт байгаль орчныг бохирдохоос урьдчилан сэргийлэх, байгалийн баялгийг жам ёсоороо нөхөн сэргэх боломжийг нь алдагдуулахгүйгээр, байгалийн даацад нь тохируулан зохистой ашиглах, нөхөн сэргээх, тэдгээрт хяналт тавих ажиллагаа хамаарна;

*/Энэ заалтыг 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмсэн/*

8/ “байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл” гэж /цаашид “нөхөрлөл” гэх/ нутгийн иргэдэд байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх эрхийг олгож, нөөц ашиглалтыг хамтаараа, ил тод, шударга зарчимд нийцүүлэн зохион байгуулж, түүнээс гарсан үр ашгийг иргэдэд тэнцүү хуваарилах зорилготой нөхөрлөлийг;

*/Энэ заалтыг 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

9/ “байгаль орчны мэдээллийн сан” /цаашид “мэдээллийн сан” гэх/ гэж байгаль орчны өгөгдөл, мэдээллийг бүрдүүлэх, цуглуулах, дамжуулах, боловсруулах, ашиглах, хадгалах, баяжуулах, өөрчлөх, шинэчлэх, хамгаалах зэрэг үйл ажиллагааг хангах мэдээллийн технологийн иж бүрдлийг;

*/Энэ заалтыг 2008 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хуулиар нэмсэн/*

10/ “мета мэдээлэл” гэж мэдээний эх сурвалж, хариуцах этгээд, формат, масштаб, чанар, хамрах хүрээ, хугацаа, ашиглалт зэрэг өгөгдлийн талаархи мэдээллийн багцыг.

*/Энэ заалтыг 2008 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хуулиар нэмсэн/*

11/ “байгаль орчинд учруулсан хохирол” гэж байгалийн баялгийг зөвшөөрөлгүй бэлтгэсэн, олборлосон, эсхүл байгаль орчны чадавхын тогтоосон хэм хэмжээ, зөвшөөрөгдөх дээд хэмжээний хязгаараас хэтрүүлэн байгаль орчныг бохирдуулсан, доройтуулсан, гэмтээсэн, байгалийн нөөц баялгийг хомсдуулсан, экологийн тогтолцоог алдагдуулсан аливаа үйлдэл, эс үйлдэхүйг;

*/Энэ заалтыг 2010 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн хуулиар нэмсэн/*

12/ “байгаль орчинд учруулсан хохирлын нөхөн төлбөр” гэж иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтны байгаль орчинд учруулсан хохирол, түүнийг арилгах болон цаашид үүсч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд шаардлагатай байгаль орчны экологи-эдийн засгийн үнэлгээ, аргачлалын дагуу тогтоосон мөнгөн илэрхийллийг;

*/Энэ заалтыг 2010 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн хуулиар нэмсэн/*

13/ “байгаль орчинд учирсан хохирлыг нөхөн төлөгч” гэж энэ хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 11 дэх заалтад заасан үйлдэл, эс үйлдэхүйг хийсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтныг.

*/Энэ заалтыг 2010 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн хуулиар нэмсэн/*

14/ “байгаль орчны аудит” гэж байгаль орчны хууль тогтоомж, төрийн бодлого, үндэсний хөтөлбөрийн биелэлт, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, стандартын хэрэгжилтийг хянаж, дүгнэлт гаргах, мэргэжлийн зөвлөгөө өгөх хараат бус үйл ажиллагааг.

*/Энэ заалтыг 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/*

3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан объект, тэдгээрийн баялгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбогдсон харилцааг тусгай хуулиар зохицуулна.

#### **4 дүгээр зүйл. Байгаль орчныг хамгаалах талаархи иргэний эрх, үүрэг**

1. Иргэн байгаль орчныг хамгаалах талаар дараахь эрхийг эдэлнэ:

1/ гэм буруутай этгээд байгаль орчинд хортой нөлөөлснөөс эрүүл мэнд, эд хөрөнгөндөө учирсан хохирлыг түүгээр нөхөн төлүүлэхээр нэхэмжлэх;

2/ байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн зөрчилтэй тэмцэх болон байгаль орчинд хортой нөлөөлсөн этгээдэд хариуцлага хүлээлгэхийг шаардах, байгаль орчинд учруулсан хохирлыг барагдуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах;

*/Энэ заалтад 2010 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

3/ байгаль орчныг хамгаалах олон нийтийн байгууллага байгуулах, хөрөнгийн сан үүсгэх нутгийн иргэд сайн дурын үндсэн дээр нэгдэж байгалийн баялгийг арчлан хамгаалах, нөхөн сэргээх, түүний ашиг шимийг хүртэх;

*/Энэ заалтад 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмэлт орсон/*

4/ холбогдох байгууллагаас байгаль орчны тухай үнэн, зөв мэдээлэл авах;

5/ байгалийн нөөц, баялгийн халдашгүй байдлыг хангах, байгаль орчинд хортой нөлөөлөх аливаа үйл ажиллагааг хязгаарлах, таслан зогсоох шийдвэр гаргахыг болон байгаль орчинд хортой нөлөөлж болзошгүй аж ахуйн нэгж, байгууллагыг шинээр байгуулах зөвшөөрөл олгохгүй байхыг холбогдох эрх бүхий байгууллагаас шаардах;

*/Энэ заалтад 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

6/ сайн дурын үндсэн дээр зохион байгуулалтад орж, энэ хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 8 дахь заалтад заасан нөхөрлөл байгуулах замаар оршин суугаа нутгийнхаа байгалийн тодорхой төрлийн баялгийг хамгаалах, холбогдох хууль тогтоомжийн дагуу гэрээгээр ашиглах, эзэмших.

*/Энэ заалтыг 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмсэн/*

2. Иргэн байгаль орчныг хамгаалах талаар дараахь үүрэг хүлээнэ:

1/ байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийг сахин биелүүлэх;

2/ байгаль орчныг хамгаалах үндэсний уламжлал, зан заншил эзэмшиж хэрэглэх, үр хүүхэддээ экологийн хүмүүжил олгох;

3/ байгаль орчинд хортой нөлөөлөхөөс сэргийлэх, өөрийн буруугаас учруулсан хортой нөлөөлөл, түүний хохирлыг арилгах буюу нөхөн төлөх.

4/ байгалийн баялгийг хууль бусаар ашигласан, гэмтээсэн, хөнөөж сүйтгэсэн үйлдлийг олж мэдсэн иргэн тэр тухайгаа тухайн орон нутгийн Засаг дарга, улсын байцаагч, байгаль хамгаалагчид нэн даруй мэдэгдэх.

*/Энэ заалтыг 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмсэн/*

#### **5 дугаар зүйл. Байгаль орчныг хамгаалах талаархи төрийн чиг үүрэг, зарчим**

1. Төр нь хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах зорилгоор байгаль орчинд хортой нөлөөлөхөөс болон байгаль орчны тэнцэл алдагдахаас сэргийлэн хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

2. Төр нь байгаль орчныг хамгаалах чиг үүргээ хэрэгжүүлэхдээ дараахь зарчим баримтална:

1/ хүний амьдрах, хөдөлмөрлөх, амрах байгаль орчны тааламжтай нөхцөл бүрдүүлэх;

2/ экологийн баримжаатай эдийн засгийг хөгжүүлж байгаль орчны тэнцлийг хангах;

3/ байгалийн баялгийг шинжлэх ухааны үндэслэлтэй зохистой ашиглах нөхцөлийг хангах;

4/ байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг ашиглах шийдвэр, үйл ажиллагаа ил тод байх.

5/ байгалийн нөөц, баялгийн халдашгүй байдлыг хангах.

*/Энэ заалтыг 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/*

## **6 дугаар зүйл. Байгалийн баялгийг өмчлөх, байгаль орчныг хамгаалах**

*/Энэ зүйлийн гарчигт 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/*

1. Монгол Улсын иргэнд өмчлүүлснээс бусад газар, газрын хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг төрийн өмч мөн бөгөөд төрийн эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрөл, эрхийн бичгээр ашиглахаас бусад тохиолдолд халдашгүй байна.

*/Энэ хэсгийг 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

2. Хуульд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, гадаадын иргэн, хуулийн этгээд байгалийн баялгийг зохих төлбөр, хураамжийг төлж, гэрээ, тусгай зөвшөөрөл буюу эрхийн бичгийн дагуу ашиглаж болно.

3. Хууль, гэрээнд заасан журмын дагуу иргэн өмчийн болон эзэмшлийн, аж ахуйн нэгж, байгууллага эзэмшлийн газар дээрээ өөрийн хөрөнгөөр тарьж ургуулсан ургамал, ой мод, өсгөж үржүүлсэн амьтан болон хурын усыг хуримтлуулах замаар байгуулсан усан сан, нуур, цөөрмийг өмчилж болно.

*/Энэ хэсгийг 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмсэн/*

4. Байгалийн баялгийг энэ хуулийн 6 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу бий болгосон эсэх талаар мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллагын дүгнэлт, орон нутгийн засаг захиргааны болон байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тодорхойлолтыг үндэслэн тэдгээрт өмчлүүлэх асуудлыг хуулийн дагуу шийдвэрлэнэ.

*/Энэ хэсгийг 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмсэн/*

5. Засаг дарга энэ хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 10 дахь заалт, 17 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 8 дахь заалтад заасан үүргээ зохих ёсоор биелүүлээгүйгээс тухайн нутгийн байгаль орчинд онц их хэмжээний хохирол учирсныг эрх бүхий мэргэжлийн байгууллага хуульд заасан аргачлалаар албан ёсоор тогтоосон тохиолдолд Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 32.2-т заасан арга хэмжээ авна.

*/Энэ хэсгийг 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/*

*/Энэ хэсэгт 2015 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

## ХОЁРДУГААР БҮЛЭГ

### БАЙГАЛЬ ОРЧНЫ ҮНЭЛГЭЭ, СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ, АУДИТ

*/Энэ бүлгийн гарчигт 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/*

#### 7 дугаар зүйл. Байгаль орчны үнэлгээ

1. Байгаль орчны унаган төрхийг хадгалах, түүний тэнцэл алдагдахаас сэргийлэх арга хэмжээ боловсруулж хэрэгжүүлэх, байгалийн баялгийн ашиглалтыг зохицуулах зорилгоор байгалийн баялгийн нөөцийн үнэлгээ болон байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг тус тус хийнэ.

2. Байгалийн баялгийг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглахыг хүсч байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үнэлгээг өөрийн зардлаар хийлгэх буюу үнэлгээг урьд нь тогтоосон бол түүнийг гүйцэтгэсний зардлыг төлнө.

3. Байгаль орчны үнэлгээг энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу эрх олгосон аж ахуйн нэгж, байгууллага хийж тухайн төрлийн байгалийн баялгийг хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

4. Аж ахуйн нэгж, байгууллагад байгалийн баялгийн нөөцийн үнэлгээ хийх эрхийг тухайн төрлийн байгалийн баялгийг хамгаалах, зохистой ашиглах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх эрхийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага /цаашид “төрийн захиргааны төв байгууллага” гэх/ олгоно.

*/Энэ хэсэгт 1998 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар нэмэлт, 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/*

5. Дараахь шаардлага хангасан аж ахуйн нэгж, байгууллагад байгаль орчны үнэлгээ хийх эрх олгоно:

1/ үнэлгээний багийн бүрэлдэхүүний гуравны нэгээс доошгүй нь орон тооны мэргэжлийн боловсон хүчин байх;

*/Энэ заалтыг 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

2/ хэмжилт, судалгааны багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмжтэй байх;

3/ магадлан итгэмжлэгдсэн мэргэжлийн байгууллагаас батлагдсан байгаль орчны үнэлгээ хийх арга зүйтэй байх;

*/Энэ заалтыг 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

4/ үнэлгээ хийх асуудлаархи мэдээллийн сантай байх.

*6./Энэ хэсгийг 1998 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/*

#### 8 дугаар зүйл. Байгалийн баялгийн нөөцийн үнэлгээ

1. Байгалийн тодорхой төрлийн баялгийн хэмжээг тоо, чанар болон мөнгөн үзүүлэлтээр тодорхойлсныг байгалийн баялгийн нөөцийн үнэлгээ гэнэ.

2. Үнэлгээгээр байгалийн баялгийн нөөцийн хэмжээ, тухайн баялгийг хамгаалах, зохистой ашиглах, жам ёсны боломжтойг нь нөхөн сэргээх арга хэмжээг тогтоож, байгаль орчны улсын нэгдсэн мэдээллийн санд бүртгэнэ.

*/Энэ хэсэгт 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/*

3. Байгалийн баялгийн нөөцийн мөнгөн үнэлгээг экологи, эдийн засгийн

ач холбогдлыг харгалзан төрийн захиргааны төв байгууллага холбогдох бусад байгууллагатай хамтран тогтооно.

4.Нөөцийн мөнгөн үнэлгээг тухайн баялгийн нөөц ашигласны төлбөр, хураамж, байгальд учруулсан хортой нөлөөлөл, шууд хохирлын нөхөн төлбөрийн хэмжээг тогтоох үндэс болгоно.

### **9 дүгээр зүйл.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ**

*1./Энэ хэсгийг 1998 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар хүчингүй болгоонд тооцсон/*

2.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээтэй холбогдсон харилцааг хуулиар зохицуулна.

*/Энэ хэсгийг 1998 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

3.Нөлөөллийн үнэлгээний зардлыг захиалагч этгээд санхүүжүүлнэ.

4.Нөлөөллийн үнэлгээгээр тогтоогдсон шаардлагыг төсөл хэрэгжүүлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага биелүүлэх үүрэгтэй.

*/Энэ хэсэгт 1998 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/*

### **10 дугаар зүйл.Байгаль орчны төлөв байдлын хяналт-шинжилгээ**

1.Байгаль орчны төлөв байдлын хяналт-шинжилгээнд байгаль орчны төлөв байдал, түүний хувьсал өөрчлөлтөд байнгын ажиглалт, хэмжилт, судалгаа, шинжилгээ хийж дүгнэлт гаргах, илэрсэн сөрөг өөрчлөлтийг зогсоох, арилгах арга хэмжээ боловсруулах үйл ажиллагаа хамаарна.

2.Төрийн захиргааны төв байгууллага энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан ажлыг хэрэгжүүлэх зорилгоор байгаль орчны төлөв байдлын хяналт-шинжилгээний сүлжээ /цаашид “хяналт-шинжилгээний сүлжээ” гэх/ -г зохион байгуулж ажиллуулна.

3.Хяналт-шинжилгээний сүлжээгээр дараахь ажлыг хэрэгжүүлнэ:

1/ байгаль орчинд гарах физик, хими, биологийн хувьсал өөрчлөлт, бохирдолтын түвшинд байнгын ажиглалт, хэмжилт, судалгаа хийж байгаль орчны төлөв байдлын өөрчлөлтийг тогтоох, үнэлгээ өгөх;

2/ байгаль орчин, түүний баялгийн талаар хүн ам, сонирхогч аж ахуйн нэгж, байгууллагыг мэдээллээр хангах;

3/ хүний эрүүл мэнд, байгаль орчинд учруулах хортой нөлөө, байгалийн аюул гамшгаас урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгах арга хэмжээний төсөл боловсруулах.

### **10<sup>1</sup> дүгээр зүйл.Байгаль орчны аудит**

1.Байгаль орчны аудитыг байгалийн нөөц, баялгийг ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллага нь хоёр жил тутам хийлгэж, холбогдох дүгнэлт, зөвлөмж гаргуулан хэрэгжүүлэх бөгөөд зөвлөмжид заасан хугацаанд тайлангаа аймаг, нийслэлийн байгаль орчны албанд хүргүүлнэ.

2.Байгаль орчны аудит хийх зардлыг төлөвлөгөөт хугацаанд хийж байгаа тохиолдолд тухайн аж ахуйн нэгж, байгууллага, төлөвлөгөөт бус хугацаанд Засаг дарга, эсхүл байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага аудит хийлгэх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд захиалагч тал хариуцна.

3.Байгаль орчны аудитын үйл ажиллагааг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрх авсан хуулийн этгээд эрхлэн гүйцэтгэнэ.

4.Байгаль орчны аудит хийх аргачлал, эрх олгох журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

5.Төрийн аудитын байгууллагаас байгаль орчны санхүүгийн болон гүйцэтгэлийн аудит хийхтэй холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулахгүй.

*/Энэ зүйлийг 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/*

#### **11 дүгээр зүйл.Байгаль орчны судалгаа, шинжилгээ, түүний санхүүжилт**

1.Улсын болон бүс нутгийн хөгжлийн баримжааг тодорхойлох, нэн ховордсон амьтан, ургамлыг нөхөн сэргээх, өсгөн үржүүлэх, хөрс, ус, агаарыг хамгаалах болон хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах талаархи судалгаа, шинжилгээний ажлыг улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.

*/Энэ хэсэгт 2003 оны 1 дүгээр сарын 2-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/*

~~2.Төрийн захиргааны төв байгууллага, зөхих шатны Засаг дарга нь эрдэм шинжилгээний болон холбогдох мэргэжлийн байгууллагад байгаль орчны судалгаа, шинжилгээний ажил хийх, төсөл боловсруулах захиалга өгч зөхих төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхээс гадна сонирхогч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад өөрийн хөрөнгөөр судалгаа, шинжилгээ хийхэд нь дэмжлэг үзүүлнэ.~~

~~*/Энэ хэсэгт 2006 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөлт орсон/*~~

~~**12 дугаар зүйл./ Энэ зүйлийг 2008 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/**~~

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ**

### **БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТАЛААРХИ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН БҮРЭН ЭРХ**

#### **13 дугаар зүйл.Улсын Их Хурлын бүрэн эрх**

Улсын Их Хурал байгаль орчныг хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх төрийн бодлогыг тодорхойлох;

2/ Засгийн газрын өргөн мэдүүлснээр байгаль орчныг хамгаалах, экологийн аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөр батлах;

3/ байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийг батлах тэдгээрийн биелэлтэд хяналт тавих;

4/ байгалийн баялгийн нөөцийг ашигласны болон орчныг бохирдуулсны төлбөр, хураамжийн дээд, доод хэмжээг тогтоох;

5/ устгах аюулд орсон амьтан, ургамлын жагсаалтыг батлах, өөрчлөх, байгалийн зарим объектыг улсын тусгай хамгаалалтад авах;

6/ хуульд заасан бусад бүрэн эрх.

#### **14 дүгээр зүйл.Засгийн газрын бүрэн эрх**

Засгийн газар байгаль орчныг хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ байгаль орчныг хамгаалах, экологийн аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

2/ байгалийн баялгийг ашиглах, импортлох, экспортлох хэмжээг хуульд заасан үндэслэлээр хязгаарлах буюу тодорхой хугацаагаар хориглох;

*/Энэ заалтад 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмэлт орсон/*

3/ иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд хортой нөлөөлөл бүхий үйлдвэрлэлийн болон бусад үйл ажиллагааг төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэлийн Засаг даргын саналыг харгалзан өмчийнх нь хэлбэрийг үл харгалзан зогсоох;

4/ амьтан, ургамал, түүнчлэн байгалийн гаралтай түүхий эд экспортлох, импортлоход хил, гааль, хорио цээрийн хяналтыг зохион байгуулах;

~~5/ */Энэ заалтыг 2006 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/*~~

6/ иргэдэд экологийн боловсрол, хүмүүжил олгох ажлыг зохион байгуулах;

7/ хуульд заасан бусад бүрэн эрх.

## **15 дугаар зүйл. Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх**

1. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага байгаль орчныг хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчны тэнцлийг хангах, байгаль орчинд учирч болох хохирлоос урьдчилан сэргийлэх, учирсан хохирлыг арилгуулах төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

*/Энэ заалтад 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

2/ байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх, тогтвортой ашиглах, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх тодорхой асуудлаар төрийн захиргааны бусад төв байгууллага, аймаг, нийслэлийн хэмжээнд мөрдөх шийдвэр, дүрэм, журам батлаж биелэлтийг хангуулах;

*/Энэ заалтад 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

3/ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийн нөөцийг зохистой ашиглах, нөхөн сэргээх талаар салбар дундын болон бүс нутаг хоорондын удирдлага, бодлогын төлөвлөлт, зохицуулалтыг хариуцаж, байгаль орчны чадавхийн хэм хэмжээ, стандартыг боловсруулж, эрх бүхий байгууллагаар батлуулах буюу төрийн захиргааны холбогдох төв байгууллагатай хамтран баталж, биелэлтийг зохион байгуулах, экологи-эдийн засгийн үнэлгээ, хохирол тооцох аргачлалыг батлах;

*/Энэ заалтыг 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

4/ хууль тогтоомжийн дагуу жил бүр ашиглаж болох ой, ургамал, амьтны тоо хэмжээг тодорхойлж, экологийн шаардлага, нөөцийг харгалзан тухайн бүс нутагт байгалийн зарим төрлийн баялгийн ашиглалтыг хязгаарлах буюу тодорхой хугацаагаар хориглох;

*/Энэ заалтад 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмэлт орсон/*

5/ байгаль орчныг хамгаалах талаар улсын захиалга өгч судалгаа, шинжилгээ, зураг төслийн ажил гүйцэтгүүлэх, өөрийн харьяа судалгаа,

шинжилгээ, зураг төслийн болон мэргэжлийн байгууллагын үйл ажиллагааг удирдах;

6/ байгаль орчны тухай мэдээллээр иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг хангах биологийн болон генетикийн нөөцийг тогтвортой ашиглахад чиглэгдсэн уламжлалт мэдлэг, шинэ санаа, амьдралын туршлагыг хэрэглэснээр гарах үр ашгийг тэгш, шударгаар ашиглах явдлыг дэмжих;

*/Энэ заалтад 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмэлт орсон/*

7/ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийн нөөцийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх талаар төрийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагад аргачилсан туслалцаа, санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

*/Энэ заалтыг 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

8/ байгаль орчныг хамгаалах асуудлаар гадаад улс, олон улсын байгууллагатай хамтран ажиллах;

~~9/ Энэ заалтыг 2002 оны 7 дугаар сарын 10-ны хуулиар хүчингүй болсонд тооцсон/~~

~~10/ Энэ заалтыг 2002 оны 7 дугаар сарын 10-ны хуулиар хүчингүй болсонд тооцсон/~~

11/ нөхөрлөлийн менежментийн төлөвлөгөөг боловсруулах, арга зүйн зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх, нэгдсэн удирдлагаар хангах;

*/Энэ заалтыг 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/*

12/ энэ хуулийн 49 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт заасан аргачлалыг батлах;

*/Энэ заалтыг 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/*

13/ байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх, экологийн боловсрол, хүмүүжил олгох ажилд санхүүгийн дэмжлэг үзүүлэх.

*/Энэ заалтыг 2006 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн хуулиар нэмсэн/*

*/Энэ заалтын дугаарт 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/*

14/ идэвхтэн байгаль хамгаалагч ажиллуулах, ажлын үр дүнгээр урамшуулах журам боловсруулан батлах;

*/Энэ заалтыг 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмсэн/*

*/Энэ заалтын дугаарыг 2006 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн хуулиар өөрчилсөн/*

*/Энэ заалтын дугаарт 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/*

15/ байгаль орчны мэдээллийн сангийн үйл ажиллагааны талаархи хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг нэгдсэн удирдлагаар хангаж, хэрэгжилтэд нь хяналт тавих;

*/Энэ заалтыг 2008 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хуулиар нэмсэн/*

*/Энэ заалтын дугаарт 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/*

16/ хуульд заасан бусад бүрэн эрх.

*/Энэ заалтын дугаарыг 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хууль, 2006 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн хуулиар өөрчилсөн/*

*/Энэ заалтын дугаарт 2008 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хууль, 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/*

2.Төрийн захиргааны бусад төв байгууллага байгаль орчныг хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ салбарынхаа хөгжлийн чиг баримтлалд байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээг тухайлан тусгаж хэрэгжүүлэх;

2/ салбартаа байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулж үр дүнг жил бүр Засгийн газарт тайлагнах.

## **16 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Засаг даргын бүрэн эрх**

1. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал байгаль орчныг хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ, төсөв баталж, биелэлтэд хяналт тавих;

2/ нутаг дэвсгэртээ тухайн жилд ашиглах байгалийн баялгийн нөөцийн дээд хэмжээг энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу тогтоох;

3/ байгаль орчны улсын тусгай хамгаалалтад ороогүй объектыг орон нутгийн хамгаалалтад авах шийдвэр гаргаж, түүний хилийн зааг, хамгаалалтын дэглэм тогтоож, биелэлтэд нь хяналт тавих;

4/ хот, тосгон, бусад суурин болон амралт, сувиллын газар, гол, мөрний эх, нуур, рашаан, булаг, шанд, уст цэгийн орчинг хамгаалах, эрүүл ахуйн шаардлагыг хангах тусгай бүсийн заагийг тогтоох;

5/ байгаль орчны төлөв байдал, мэдээллийн сангийн тухай Засаг даргын мэдээлэл, тайланг хэлэлцэх.

6/ шинээр томилогдсон Засаг даргад тухайн нутгийн байгалийн нөөцийн санг энэ хуулийн 35 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-6 дахь заалтад заасан үзүүлэлтээр бүртгэж хүлээлгэн өгөх бөгөөд түүний өөрчлөлтийн тайланг жил тутам хэлэлцэн, үнэлэлт дүгнэлт өгч байна.

*/Энэ заалтыг 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/*

2. Аймаг, нийслэлийн Засаг дарга байгаль орчныг хамгаалах, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

*/Энэ хэсэгт 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

1/ байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах;

2/ нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гарсан шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах;

3/ байгаль орчны мэдээллийн сангийн мэдээ, баримтыг төрийн захиргааны төв байгууллагад хугацаанд нь ирүүлэх;

4/ нутаг дэвсгэрийнхээ аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх үйл ажиллагаанд харьяалал харгалзахгүйгээр хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах, шаардлагатай бол тухайн аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчинд хортой нөлөөлж буй үйл ажиллагааг өөрөө түдгэлзүүлэн зогсоох буюу уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

*/Энэ заалтад 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

5/ нутаг дэвсгэртээ ажиллах байгаль орчны улсын ахлах болон улсын байцаагчийг энэ хуульд заасны дагуу ялгах тэмдэг, дүрэмт хувцас, бие хамгаалах зэвсэг, техник хэрэгсэл, уналгаар хангах;

*/Энэ заалтад 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт орсон/*

6/ аймаг, нийслэлийн байгаль орчны албаны даргыг байгаль хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөж томилох, чөлөөлөх.

*/Энэ заалтыг 2006 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар нэмсэн/*

7/ нутаг дэвсгэртээ нөхөрлөлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг баталж, санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

*/Энэ заалтыг 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/*

8/ нөхөрлөлийн үйл ажиллагааг нутаг дэвсгэртээ батлагдсан төсвийн хүрээнд дэмжин хөгжүүлэх мэргэжлийн болон арга зүйн удирдлагаар хангах ажлыг зохион байгуулах;

*/Энэ заалтыг 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/*

9/ тухайн жилд нөхөрлөлийн хэрэгжүүлсэн үйл ажиллагааны талаарх тайланг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хэлэлцүүлэх;

*/Энэ заалтыг 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/*

10/ байгалийн нөөцийг төрийн нэрийн өмнөөс хамгаалан, халдашгүй байдлыг нь хангах үүргийг тухайн нутаг дэвсгэртээ хариуцах.

*/Энэ заалтыг 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/*

3.Аймаг, нийслэлийн байгаль орчны албаны даргыг байгаль орчны мэргэжилтэй, тухайн салбарт 3-аас доошгүй жил ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас Төрийн албаны тухай хуулийн 17.1-д заасны дагуу сонгон шалгаруулж томилно.

*/Энэ хэсгийг 2006 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар нэмсэн/*

## **17 дугаар зүйл.Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Засаг даргын бүрэн эрх**

1.Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал байгаль орчныг хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ, төсөв баталж, биелэлтэд хяналт тавих;

2/ нутаг дэвсгэртээ тухайн жилд ашиглах байгалийн баялгийн нөөцийн хэмжээг хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу тогтоох;

4/ байгаль орчныг хамгаалах талаар Засаг даргын ажлын тайлан хэлэлцэх.

5/ нутаг дэвсгэрийнхээ байгалийн тодорхой төрлийн баялгийн хамгаалалт, ашиглалт, эзэмшилтийг энэ хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 8 дахь заалтад заасан нөхөрлөлд хариуцуулах асуудлыг баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын саналыг үндэслэн шийдвэрлэх.

*/Энэ заалтыг 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмсэн/*

6/ энэ хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалтад заасан үнэлэлт, дүгнэлт өгч байх;

*/Энэ заалтыг 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/*

7/ нутаг дэвсгэртээ нөхөрлөлд түшиглэсэн байгалийн нөөцийн хамтын менежментийн үзэл баримтлалын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийг батлах, хэрэгжилтийг хянах.

*/Энэ заалтыг 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/*

2.Сум, дүүргийн Засаг дарга байгаль орчныг хамгаалах, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

*/Энэ хэсэгт 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

1/ нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, дээд шатны байгууллагын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах;

2/ иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад байгалийн баялгийн нөөц ашиглах эрхийн бичгийг хууль тогтоомжийн дагуу олгох;

3/ иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын байгалийн баялгийн ашиглалтад хяналт тавьж, тэдний ургуулсан ой, ургамал, өсгөн үржүүлсэн амьтан, сэргээн сайжруулсан, засаж тохижуулсан газар, уст цэгийг хүлээн авах;

4/ нутаг дэвсгэрийнхээ аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд харьяалал харгалзахгүйгээр хяналт тавьж, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах, шаардлагатай бол тухайн аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчинд хортой нөлөөлж буй үйл ажиллагааг өөрөө түдгэлзүүлэн зогсоох буюу уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх; /  
*Энэ заалтад 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

5/ байгаль хамгаалагчийн ажлыг удирдан чиглүүлэх, албан үүргээ гүйцэтгэхэд нь шаардагдах ялгах тэмдэг, дүрэмт хувцас, бие хамгаалах зэвсэг, техник хэрэгсэл, уналгаар орон нутгийн төсөвтөө тусган хангах, шаардлагатай бусад туслалцаа үзүүлэх;

*/Энэ заалтад 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмэлт орсон/*

6/ аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдлын цэг тогтоох, бохирдлыг багасгах арга хэмжээ авах.

7/ энэ хуулийн 17 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтад заасан шийдвэрийг үндэслэн иргэдийн нөхөрлөлд хариуцуулах байгалийн тодорхой төрлийн баялгаас нь зохих болзол, хугацаатайгаар хууль, журмын дагуу хамгаалуулах, ашиглуулах, эзэмшүүлэх гэрээ байгуулж, биелэлтэд нь хяналт тавих.

*/Энэ заалтыг 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмсэн/*

8/ байгалийн нөөцийг төрийн нэрийн өмнөөс хамгаалан, халдашгүй байдлыг нь хангах үүргийг тухайн нутаг дэвсгэртээ хариуцах;

*/Энэ заалтыг 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/*

9/ энэ хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 8 дахь заалтад заасан үүргээ нутгийн иргэдийн байгалийн нөөцийг зохистой ашиглах ухамсрыг төлөвшүүлэх, байгалийн нөөцийн хууль бус ашиглалттай тэмцэх, учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, шүүхэд нэхэмжлэл гаргах зэрэг хэлбэрээр хэрэгжүүлэх;

*/Энэ заалтыг 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/*

10/ нөхөрлөлийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг

зохион байгуулж, мэргэжлийн сургалт явуулж үр дүнг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнах.

*/Энэ заалтыг 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/*

### **18 дугаар зүйл.Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал болон Засаг даргын бүрэн эрх**

1.Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал байгаль орчныг хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ бусдын эзэмшил, ашиглалтад олгоогүй хадлан, бэлчээр, уст цэгийг хамгаалах, ашиглах хуваарь гаргаж зохицуулах;

2/ нийтийн ашиглалтын байгалийн баялгийн хамгаалалт, ашиглалтад хяналт тавих;

3/ байгаль орчныг хамгаалах талаархи Засаг даргын ажлын тайлан сонсох.

4/ нөхөрлөл байгуулах талаар багийн Засаг даргаас ирүүлсэн саналыг хэлэлцэн шийдвэрлэх.

*/Энэ заалтыг 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/*

2.Баг, хорооны Засаг дарга байгаль орчныг хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ байгаль орчныг хамгаалах талаархи хууль тогтоомж, иргэдийн Нийтийн Хурал болон дээд шатны байгууллагын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах;

2/ нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах ажлыг удирдан чиглүүлж орчны бохирдол, хог хаягдлыг цэвэрлэх жил бүрийн ажилд иргэдийг татан оролцуулах;

3/ хууль тогтоомжид заасан тохиолдолд байгалийн баялгийн нөөц ашиглах эрхийн бичиг олгох;

4/ нутаг дэвсгэртээ орчны эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг хангуулах, нийтийн хог хаягдлын цэг тогтоох.

5/ нөхөрлөлийг байгуулах болон түүний үйл ажиллагаатай холбогдсон саналыг иргэдийн Нийтийн Хуралд танилцуулж хэлэлцүүлэх.

*/Энэ заалтыг 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/*

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ**

### **БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, БАЙГАЛИЙН БАЯЛГИЙГ АШИГЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ НИЙТЛЭГ АРГА ХЭМЖЭЭ**

#### **19 дүгээр зүйл.Байгаль орчныг хамгаалах нийтлэг арга хэлбэр**

1.Монгол Улс санхүүгийн баталгаа бүхий “Байгаль орчныг хамгаалах, экологийн аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөр”- тэй байна.

2.Төр, түүний байгууллага, албан тушаалтан дараахь нийтлэг арга хэлбэрээр байгаль орчныг хамгаална:

1/ нэн ховор амьтныг агнах, барих, ургамлыг бэлтгэж ашиглахыг хориглох;

2/ нэн ховор, ховор амьтан, ургамлыг Монгол Улсын улаан номонд бүртгэж хамгаалах;

3/ байгаль орчинд үзүүлэх хортой аюултай нөлөөллийн хэм хэмжээ, стандарт тогтоож мөрдүүлэх;

*/Энэ заалтад 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмэлт орсон/*

4/ хүн амд экологийн боловсрол, хүмүүжил олгох, үндэсний өв

уламжлалыг эзэмшүүлэх;

5/ хоргүй, аюулгүй, бохирдолгүй, хаягдалгүй технологи нэвтрүүлэн ашиглахыг урамшуулах;

*/Энэ заалтад 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмэлт орсон/*

6/ хот, тосгон, бусад суурин газрын орчинд болон гол, мөрөн, нуур, рашаан, булаг, шандын эх, ундаргын орчныг хамгаалах, эрүүл ахуйн бүс тогтоох.

7/ нөхөрлөлд гэрээний дагуу байгалийн тодорхой төрлийн баялгийн хамгаалалт, ашиглалт, эзэмшилтийг хариуцуулах.

*/Энэ заалтыг 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмсэн/*

## **20 дугаар зүйл. Байгаль орчны чадавхийн хэм хэмжээ**

1. Хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангах, байгаль орчныг хамгаалах зорилгоор байгаль орчинд гаргах хортой, аюултай бодисын агууламж, үзүүлэх сөрөг нөлөөллийн түвшний хэм хэмжээ /цаашид “байгаль орчны чадавхийн хэм хэмжээ” гэх/ -г дараахь үзүүлэлтээр тогтооно:

*/Энэ хэсэгт 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/*

1/ агаар, ус, хөрс дэх хими, биологийн хортой аюултай бодисын хүлцэх хэм хэмжээ;

*/Энэ заалтад 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмэлт орсон/*

2/ байгаль орчинд хаяж болох хортой, аюултай бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ;

*/Энэ заалтад 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/*

3/ чимээ, шуугиан, чичиргээ, цахилгаан соронзон талбай болон физикийн бусад хортой нөлөөллийн хүлцэх хэм хэмжээ;

4/ цацраг идэвхжлийн хүлцэх хэм хэмжээ;

5/ газар тариалан, бэлчээр хамгаалахад хэрэглэх агрохимийн бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ;

6/ хүнсний бүтээгдэхүүн дэх химийн бодисын зөвшөөрөх дээд агууламж;

7/ байгаль орчны даацын болон нөөцийн ашиглалтын зөвшөөрөгдөх дээд хэмжээ.

*/Энэ заалтад 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмэлт орсон/*

2. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2, 3, 4, 6-д заасан хэм хэмжээг стандартчиллын байгууллага тогтооно.

*/Энэ хэсэгт 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмэлт орсон/*

3. Байгаль орчны чадавхийн тогтоосон хэм хэмжээг хэтрүүлэн байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага байгаль орчинд учруулсан хохирлыг өөрөө арилгах буюу мэргэжлийн байгууллагаар арилгуулж гарсан зардлыг нөхөн төлнө.

*/Энэ хэсэгт 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/*

## **21 дүгээр зүйл. Байгаль орчныг бохирдохоос хамгаалах**

1. Байгаль орчны чадавхийн тогтоосон хэм хэмжээнээс хэтрүүлж үйлдвэрлэлийн болон ахуйн хог хаягдал хаяхыг байгаль орчныг бохирдуулах гэнэ.

2. Бохирдуулах эх үүсвэрийн улсын нэгдсэн бүртгэлийг төрийн захиргааны төв байгууллага хөтөлнө.

3. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага үйлдвэрлэлийн болон ахуйн хог хаягдлаар байгаль орчныг бохирдуулахгүй байх талаар дараахь үүрэгтэй:

1/ хортой, аюултай бодис болон хог хаягдлыг гагцхүү тусгайлан тогтоосон зориулалтын газар зөвшөөрөгдсөн аргаар булаах, устгах;

*/Энэ заалтад 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/*

2/ хог хаягдлыг ялган, зориулалтын саванд цуглуулан, тусгайлан тоноглогдсон тээврийн хэрэгслээр зөөж тогтоосон цэгт хаях;

3/ оршин суугаа /оршин байгаа/ орчноо болон нүүхдээ бууцаа цэвэрлэж, шаардлагатай бол ариутгаж байх;

4/ хашаа, байрныхаа орчны хог хаягдлыг тогтмол цэвэрлэх.

4. Цацраг идэвхт болон химийн хортой, аюултай бодис, тэдгээрийг агуулсан нэгдлийг үйлдвэрлэх, хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журмыг хуулиар, үйлдвэрлэл, ахуйн хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, хоргүйжүүлэх, халдваргүйжүүлэх, боловсруулах, булаах, устгах журмыг Засгийн газар тус тус тогтооно.

*/Энэ хэсэгт 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/*

## **22 дугаар зүйл. Байгалийн гамшиг, гэнэтийн аюул бүхий газар нутаг**

1. Хүний үйл ажиллагаа болон байгалийн үйл явцаас шалтгаалан байгаль орчин, хүн ам, мал, амьтан, ургамал, тэдгээрийн удмын санд хөнөөл учруулахуйц хортой нөлөөлөл, өөрчлөлт үүссэн нутаг дэвсгэрийг байгалийн гамшиг, гэнэтийн аюул бүхий газар нутаг гэнэ.

2. Байгалийн гамшиг, гэнэтийн аюул бүхий газар нутагт хамрах бүсийн заагийг төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.

3. Байгалийн гамшиг, гэнэтийн аюулаас сэргийлэх, түүний эх үүсвэрийг хязгаарлах, хор уршгийг арилгах, байгаль орчныг засаж сайжруулах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээг төрийн захиргааны төв байгууллага, иргэний хамгаалалтын алба, бүх шатны Засаг дарга, холбогдох бусад байгууллага хамтран авч хэрэгжүүлнэ.

4. Байгалийн гамшиг, гэнэтийн аюулын хор уршгийг арилгах зардлыг улсын төсвөөс гаргаж, учруулсан хохирлын шалтгааныг тогтоосны дараа түүнийг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.

## **23 дугаар зүйл. Онц байдал тогтоосон үед байгаль орчныг хамгаалах**

Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар онц байдал тогтоосон нутаг дэвсгэрт байгалийн гамшиг, гэнэтийн аюулыг сааруулах, түүний хор уршгийг арилгах, байгаль орчин, түүний баялгийг хамгаалах арга хэмжээг онц байдлын тухай болон онц байдал зарласан хуульд заасан үндэслэл, журмын дагуу авч хэрэгжүүлнэ.

## **24 дүгээр зүйл. Байгалийн баялгийн нөөцийн ашиглалтын дээд хэмжээ**

1. Байгалийн баялгийн нөөцийг түүний даац, нөхөн сэргэх чадварыг харгалзан тодорхой хугацаанд ашиглаж болох хэмжээг байгалийн баялгийн нөөцийн ашиглалтын дээд хэмжээ гэнэ.

2. Байгалийн баялгийн нөөцийн ашиглалтын дээд хэмжээг байгалийн тухайн баялгийг хамгаалах, зохистой ашиглах тухай хуульд заасны дагуу тогтооно.

## **25 дугаар зүйл. Байгалийн баялгийг нөхөн сэргээх**

1. Байгалийн баялгийг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага байгаль орчны тэнцлийг хангах зорилгоор дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

1/ ховордсон амьтан, ургамлын ашиглалтыг хязгаарлах, тэдгээрийг үржүүлэх, нутагшуулах, тэжээлээр хангах зэргээр нөөцийг нь нэмэгдүүлэх;

2/ байгалийн баялаг ашигласан газар, орчныг засаж сайжруулах, тохижуулах.

2. Монгол Улсын нутаг дэвсгэрт байдаггүй амьтныг үржүүлэх, нутагшуулах ургамлыг тарималжуулах, эгэл биетнийг өсгөвөрлөх ажлыг төрийн захиргааны төв байгууллага, эрх бүхий бусад байгууллагын зөвшөөрөл, хяналтын дор гүйцэтгэнэ.

## **ТАВДУГААР БҮЛЭГ БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ**

### **26 дугаар зүйл. Байгаль орчны хяналт**

1. Байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээхэд тавих хяналтыг мэргэжлийн хяналтын байгууллага хэрэгжүүлнэ.

*/Энэ хэсэгт 2002 оны 7 дугаар сарын 10-ны хуулиар өөрчлөлт орсон/*

2. Хил, гааль, мал эмнэлэг, эрүүл ахуй, халдвар судлал, уул уурхайн зэрэг хяналтын байцаагч буюу хуульд зааснаар энэхүү хяналтыг хэрэгжүүлэх үүрэг бүхий ажилтанд байгаль орчны улсын байцаагчийн эрх олгож, хяналтын үүрэг гүйцэтгүүлж болно.

*/Энэ хэсэгт 2002 оны 7 дугаар сарын 10-ны хуулиар өөрчлөлт орсон/*

3. Мэргэжлийн хяналтыг хэрэгжүүлэх төв байгууллагад улсын ерөнхий байцаагч, салбарын улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, аймаг нийслэлд улсын ахлах байцаагч, улсын байцаагч, сум дүүрэгт улсын ахлах байцаагч, улсын байцаагч /цаашид “улсын байцаагч” гэх/ болон байгаль хамгаалагч тус тус ажиллана.

*/Энэ хэсгийг 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

4. Улсын байцаагчийг дараахь байдлаар томилж, чөлөөлнө:

1/ улсын ахлах байцаагч, улсын байцаагчийн эрхийг Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10.4-т заасны дагуу олгоно.

*/Энэ заалтыг 2002 оны 7 дугаар сарын 10-ны хуулиар өөрчлөн найруулсан/*

*/Энэ заалтад 2010 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

~~2/ Энэ заалтыг 2002 оны 7 дугаар сарын 10-ны хуулиар хүчингүйд болгож тасалсан/~~

~~3/ Энэ заалтыг 2002 оны 7 дугаар сарын 10-ны хуулиар хүчингүйд болгож тасалсан/~~

4/ байгаль хамгаалагчийг энэ хуулийн 26 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт заасан нормативын дагуу сум, дүүргийн улсын байцаагчийн саналыг харгалзан сум, дүүргийн Засаг дарга.

*/Энэ заалтад 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/*

5.Байгаль орчны хяналтын улсын байцаагчаар байгаль орчны чиглэлийн мэргэжилтэй, эсхүл энэ чиглэлээр мэргэшиж дадлагажсан дээд боловсролын зэрэгтэй иргэнийг томилно.

*/Энэ хэсгийг 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмсэн/*

*/Энэ хэсэгт 2015 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

6.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас байгаль орчны чиглэлээр сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий сургуулийн мэргэжлийн сургалтанд хамрагдаж төгссөн иргэнийг байгаль хамгаалагчаар ажиллуулна.

*/Энэ хэсгийг 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмсэн/*

7.Нэг байгаль хамгаалагчийн хариуцан ажиллах талбайн хэмжээ нь өндөр уулын бүсэд 100.0, ойт хээрийн бүсэд 120.0; тал хээрийн бүсэд 500.0, цөлөрхөг хээрийн бүсэд 600.0, цөлийн бүсэд 800.0 мянга хүртэл га, улсын төсвийн хөрөнгөөр зориудаар тарьж ургуулсан ойн зурваст 30 км тутамд нэг байгаль хамгаалагч байх ба энэ нормативийг хот орчмын ногоон бүсэд 70 хувиар багасгаж тооцно. Тухайн бүсчлэлд хамрагдах сумдын нэрийн жагсаалт, дархан цаазат болон байгалийн цогцолборт газарт нэг байгаль хамгаалагчийн хариуцах талбайн хэмжээг тухайн тусгай хамгаалалттай газрын ангилал, хамгаалах дэглэм, онцлог, ачаалал зэргийг харгалзан Засгийн газар тогтооно.

*/Энэ хэсгийг 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмсэн/*

8.Тухайн орон нутагт байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээхэд тавих хяналтыг хэрэгжүүлэхэд туслах үүрэг бүхий идэвхтэн байгаль хамгаалагчийг томилон ажиллуулж болно.

*/Энэ хэсгийг 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмсэн/*

## **27 дугаар зүйл.Улсын байцаагчийн эрх, үүрэг**

1.Улсын байцаагч дараахь эрхтэй байна:

1/ иргэн, аж ахуйн нэгж, байгууллага байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийг хэрхэн биелүүлж байгаад харьяалал харгалзахгүйгээр хянан шалгах;

2/ хяналтад шаардагдах мэдээ, баримтыг холбогдох иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаар гаргуулах;

3/ хууль тогтоомж, стандарт, зөвшөөрөгдөх дээд хэмжээг зөрчиж байгаль орчинд хортой нөлөөлөл үзүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад уг зөрчлийг арилгахыг шаардах, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу үйл ажиллагааг нь түр зогсоох;

*/Энэ заалтад 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

4/ хяналт, шалгалт хийхээр аж ахуйн нэгж, байгууллагад нэвтрэн орох, сорьц, дээж авах, тэдгээрийг өөрийн хяналтын дор шинжлүүлэх;

5/ байгалийн гамшиг, гэнэтийн аюулын үед шаардлагатай бол нийтийн тээврийн хэрэгслээр дараалал харгалзахгүйгээр зорчих, бусад тээврийн хэрэгслийг дайчилж хөлсийг нь төлөх;

6/ байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянах явцдаа тухайн иргэний болон тээврийн хэрэгслийн баримт бичгийг шалгах, зөрчил илэрсэн тохиолдолд баримт бичиг, хууль бусаар агнасан, түүсэн, бэлтгэсэн, олборлосон байгалийн баялаг, ашигласан техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг хураах;

*/Энэ заалтыг 2002 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн хуулиар нэмсэн/*

7/ Зөрчлийн тухай хууль зөрчсөн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах, албадлагын арга хэмжээ авах;

*/Энэ заалтыг 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

*/Энэ заалтыг 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

8/ байгаль хамгаалагчийн ажлыг шалгах, заавар өгөх.

9/ ноцтой зөрчил гаргах үед ашигласан тээврийн хэрэгслийг хураах.

*/Энэ заалтыг 2002 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн хуулиар нэмсэн/*

*/Энэ заалтад 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/*

*/Энэ заалтыг 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/*

10/ хууль тогтоомж, технологийн зөрчил гаргаж байгаль орчинд хохирол учруулсан аж ахуйн нэгж, байгууллагын лицензи, зөвшөөрөл, байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулах эрхийг хүчингүй болгуулах, үйл ажиллагааг түр болон бүрмөсөн зогсоох саналаа тухайн эрх олгосон байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

*/Энэ заалтыг 2002 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн хуулиар нэмсэн/*

*/Энэ заалтад 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмэлт орсон/*

11/ байгаль орчны тухай хууль тогтоомжийг зөрчсөн шийдвэр гаргасан байгууллага, албан тушаалтны шийдвэрийг хүчингүй болгохыг шаардах, эсхүл дээд шатны байгууллагад гомдол гаргаж, шийдвэрлүүлэх.

*/Энэ заалтыг 2002 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн хуулиар нэмсэн/*

2. Улсын байцаагч дараахь үүрэгтэй байна:

1/ байгаль орчныг хамгаалах үүргээ биелүүлэхдээ хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан дүрэм, журмыг чанд сахин биелүүлэх;

2/ байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн зөрчлийн шинж байдал /зөрчил гаргагчийн нэр, хаяг, үйлдлийн шинж байдал, учруулсан хохирол, хөнгөрүүлэх болон хүндрүүлэх нөхцөл/ -ын тухай тэмдэглэл хөтлөн зөрчил гаргагчийн гарын үсэг зуруулах буюу зурахаас татгалзсан бол энэ тухай тайлбар тэмдэглэл хийж;

*/Энэ заалтыг 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/*

3/ иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад захиргааны шийтгэл ногдуулах, тэдгээрийн хууль бус үйл ажиллагааг түдгэлзүүлэн зогсоохдоо түүний үндэслэл, шалтгааныг хууль тогтоомжийн зүйл, заалтын дагуу тодорхойлж, баталсан загвараар үйлдсэн акт буюу торгуулийн хуудаст тэмдэглэх;

*/Энэ заалтыг 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/*

4/ илрүүлсэн зөрчлийг таслан зогсоох, арилгах арга хэмжээ авахдаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг

хүндэтгэх, үйлдвэрлэлийн нууцыг хадгалах;

~~5/ зөрчил гаргагчаас хуульд заасан үндэслэлээр хураан авсан зүйл, зэвсэг, хэрэгсэл, түр хураасан бичиг баримтын бүртгэлийг үйлдэж эзэнд нь үлдээж, зэвсэг, хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангаж эрх бүхий байгууллагад хугацаанд нь шилжүүлэх.~~

~~/Энэ заалтыг 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/~~

6/ байгаль орчныг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, хяналт тавих үйл ажиллагаанд орон нутгийн иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, тэдний идэвх санаачлагыг өрнүүлэх, зөвлөн туслах, зохион байгуулах, хамтарч ажиллах.

*/Энэ заалтыг 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмсэн/*

## **28 дугаар зүйл. Байгаль хамгаалагчийн эрх, үүрэг**

1. Байгаль хамгаалагч дараахь эрхтэй байна:

1/ нутаг дэвсгэртээ энэ хуулийн 27 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 4, 5-д заасан улсын байцаагчийн эрхийг хэрэгжүүлэх;

2/ нутаг дэвсгэртээ энэ хуулийн 27 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6, 7-д заасан улсын байцаагчийн эрхийг хуульд тусгайлан заасан тохиолдолд хэрэгжүүлэх.

2. Байгаль хамгаалагч энэ хуулийн 27 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаас гадна дараахь үүрэгтэй байна:

1/ хариуцсан нутаг дэвсгэртээ байгаль орчинд учирч болзошгүй аюулаас сэргийлэх, байгалийн баялгийг хамгаалах арга хэмжээ авах;

2/ хууль тогтоомжид заасан тохиолдолд байгалийн баялгийн нөөц ашиглах эрхийн бичиг олгох;

3/ иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад гэрээ, тусгай зөвшөөрөл, эрхийн бичгийн дагуу тухайн баялгийг ашиглах газрыг зааж өгөх, хяналт тавих;

*/Энэ заалтад 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмэлт орсон/*

4/ хариуцсан нутаг дэвсгэртээ байгалийн баялгийн өөрчлөлтийн ажиглалт хийж, мэдээг мэдээллийн санд тусгуулах;

5/ байгалийн гамшиг, гэнэтийн аюул гарсан даруйд зохих шатны Засаг даргад мэдээлж, хор уршгийг арилгах арга хэмжээ авах;

6/ хариуцсан нутаг дэвсгэртээ байгалийн баялгийг нөхөн сэргээх ажлыг зохион байгуулах.

7/ хариуцсан нутаг дэвсгэртээ ажиллах нөхөрлөлийн менежментийн төлөвлөгөө хэрэгжүүлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах.

*/Энэ заалтыг 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/*

8/ уул, ой модонд бүгсэн оргодол яллагдагч, ялтныг эрэн сурвалжилж байгаа цагдаагийн албанд газар орны онцлог, байгалийн тогтоц, байршлын талаар мэдээлэл өгөх, газарчлах, хамтран ажиллах.

*/Энэ заалтыг 2013 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар нэмсэн/*

*/Энэ заалтад 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

9/ хариуцсан нутаг дэвсгэртээ орших гол, мөрөн, нуурт усан замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд хяналт тавих.

*/Энэ заалтыг 2017 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн хуулиар нэмсэн/*

3.Энэ хуулийн 26 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасан шаардлага хангасан байгаль хамгаалагчид байгаль орчны хяналтын улсын байцаагчийн эрх олгох бөгөөд эрх олгох журмыг Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар хамтарч батална.

*/Энэ хэсгийг 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/*

## **29 дүгээр зүйл. Улсын байцаагч, байгаль хамгаалагч галт зэвсэг, бие хамгаалах тусгай хэрэгсэл хэрэглэх**

1.Улсын байцаагч, байгаль хамгаалагч хээрийн нөхцөлд хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгах үедээ галт зэвсэг, бие хамгаалах тусгай хэрэгсэл биедээ авч явах эрхтэй.

2.Улсын байцаагч, байгаль хамгаалагч хээрийн нөхцөлд хяналт, шалгалт хийх үедээ илэрсэн зөрчил, гадны халдлагыг өөр арга хэрэгслээр таслан зогсоох боломжгүй бол дараахь тохиолдолд галт зэвсэг хэрэглэж болно:

1/ байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж зөрчсөн этгээд хууль ёсны шаардлагыг нь илт эсэргүүцэн зэвсэг хэрэглэх буюу өөр аргаар хүч хэрэглэн амь насанд нь халдсан;

2/ зэрлэг амьтан довтолж амь насанд аюул учруулахад хүрсэн.

3.Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж зөрчсөн этгээд улсын байцаагч, байгаль хамгаалагчийн хууль ёсны шаардлагыг хүч хэрэглэн эсэргүүцвэл резинэн болон цахилгаан бороохой, нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагчаар цэнэглэсэн буу, резинэн буюу хуванцар сумтай буу зэрэг нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэж болно.

4.Галт зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэх зааврыг төрийн захиргааны төв байгууллагын саналыг харгалзан Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн цагдаагийн төрийн захиргааны төв байгууллага батална.

## **29<sup>1</sup> дүгээр зүйл. Улсын байцаагч, байгаль хамгаалагчийн нийгмийн болон эрхээ хэрэгжүүлэх баталгаа**

1.Улсын байцаагч, байгаль хамгаалагч нь нийгмийн болон эрхээ хэрэгжүүлэх дараахь баталгаагаар хангагдана:

1/ төрийн албанд 25 ба түүнээс дээш жил, түүнээс сүүлийн 10 жилийг нь байгаль хамгаалах албанд ажилласан байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч нарыг тэтгэвэрт гарахад нь 12 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тусламжийг ажиллаж байгаа байгууллагаас нь нэг удаа олгох;

*/Энэ заалтад 2016 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

*/Энэ заалтад 2016 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

2/ ажил үүргээ гүйцэтгэх зориулалтаар унаа, дүрэмт хувцас, галт зэвсэг, бие хамгаалах тусгай хэрэгсэлээр хангагдах.

2.Улсын байцаагч, байгаль хамгаалагч албан үүргээ гүйцэтгэх явцдаа бусдын нөлөөгөөр хөдөлмөрийн чадвараа түр алдсан, хөгжлийн бэрхшээлтэй болсон, амь насаа алдсан тохиолдолд түүнд болон түүний ар гэрт нь дараахь буцалтгүй тусламж, цалингийн зөрүүг олгоно:

1/ хөдөлмөрийн чадвараа түр алдсан тохиолдолд эмнэлэгийн чөлөөтэй байсан хугацааны тэтгэмж, албан тушаалын үндсэн цалингийн зөрүүг ;

2/ хөгжлийн бэрхшээлтэй болсон тохиолдолд хөгжлийн бэрхшээлтэй

иргэний тэтгэвэр, албан тушаалын үндсэн цалингийн зөрүүг;

3/ амь насаа алдсан тохиолдолд ар гэрт нь хохирогчийн 3 жилийн үндсэн цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламж;

4/ энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан үндсэн цалингийн зөрүү, буцалтгүй тусламжийг төсвөөс олгож, түүнтэй тэнцэх хөрөнгийг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.

5/ хуульд заасан бусад баталгаа.

*/Энэ зүйлийг 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмсэн/*

## **ЗУРГАДУГААР БҮЛЭГ**

### **БАЙГАЛЬ ОРЧИН, БАЙГАЛИЙН БАЯЛГИЙГ ХАМГААЛАХ ТАЛААРХИ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ҮҮРЭГ**

#### **30 дугаар зүйл. Мэргэжлийн байгууллага**

1. Ой, амьтан, ус, ашигт малтмал зэрэг байгалийн баялаг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх асуудлыг хуулиар болон төрийн захиргааны төв байгууллагаас олгосон эрхийн дагуу эрхлэн зохицуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагыг мэргэжлийн байгууллага гэнэ.

*/Энэ хэсэгт 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмэлт орсон/*

2. Мэргэжлийн байгууллагад энэ зүйлийн 1дэх хэсэгт заасан үйл ажиллагааг эрхлэн зохицуулах эрх олгох журмыг Засгийн газар батална.

*/Энэ хэсгийг 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмсэн/*

3. Мэргэжлийн байгууллага хариуцсан нутаг дэвсгэртээ дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

*/Энэ хэсгийн дугаарыг 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар өөрчилсөн/*

1/ төрийн захиргааны төв байгууллага, Засаг даргын шийдвэрийг үндэслэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай байгалийн баялгийг ашиглах гэрээ байгуулах, уг гэрээний дагуу байгалийн баялгийг ашиглах газрыг зааж өгөх;

2/ байгалийн баялгийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх төсөл, төлөвлөгөө боловсруулах, тэдгээрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, эрх олгосон тохиолдолд нөлөөллийн үнэлгээ хийх;

3/ байгалийн баялгийн нөөцийн судалгаа хийлгэх захиалга өгөх;

4/ байгалийн баялгийг өвчин, хөнөөлт мэрэгч амьтан, хөнөөлт шавьж, түймэр зэрэг байгалийн гамшиг, гэнэтийн аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, тэдгээртэй тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлэх;

5/ байгалийн баялгийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад технологийн хяналт тавих, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх;

6/ хариуцсан нутаг дэвсгэртээ байгалийн баялгийн өөрчлөлтийн ажиглалт хийж, мэдээг мэдээллийн санд тусгуулах;

7/ байгалийн баялгийг судлах, хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх талаар саналаа иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргад танилцуулж шийдвэрлүүлэх, шаардлагатай бол төрийн захиргааны төв байгууллагад уламжлах;

8/ байгалийн баялгийг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглах, арчлах, тэдгээрийг ашиглан хууль тогтоомжид заасан журмын дагуу үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх.

9/ байгаль орчинд учруулсан хохирлыг энэ хуулийн 49 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан аргачлалын дагуу тогтоох.

*/Энэ заалтыг 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/*

### **31 дүгээр зүйл. Аж ахуйн нэгж, байгууллагын үүрэг**

Аж ахуйн нэгж, байгууллага байгаль орчныг хамгаалах талаар дараахь үүрэгтэй байна:

1/ байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж, Засгийн газар, нутгийн өөрөө удирдах байгууллага болон Засаг даргын шийдвэр, улсын байцаагч, байгаль хамгаалагчийн шаардлагыг биелүүлэх;

2/ эрх бүхий байгууллагаас баталсан байгаль орчны холбогдолтой стандарт, хэм хэмжээ, дүрэм, журмыг чанд сахин биелүүлж, дотоодын хяналтыг хэрэгжүүлэх;

3/ үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх явцад байгаль орчинд гаргаж байгаа хорт бодис, физикийн хортой нөлөөлөл, хог хаягдлын хэмжээг бүртгэж, тэдгээрийг багасгах, цэвэрлэх талаар авсан арга хэмжээ, хянах төхөөрөмжийн ажиллагааны тухай тайлан мэдээг хугацаанд нь гаргаж холбогдох байгууллагад өгөх;

4/ байгаль орчинд сөрөг нөлөөлөл бүхий үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагааныхаа сөрөг нөлөөллийг бууруулах, зогсоох болон байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг жил бүр төсөвтөө тусган хэрэгжүүлэх;

*/Энэ заалтыг 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

5/ гэрээний дагуу тарьж ургуулсан ой, ургамал, үржүүлсэн амьтан, сэргээн сайжруулсан усны ундарга, засаж тохижуулсан газрыг сум, дүүргийн Засаг даргад хугацаанд нь хүлээлгэн өгөх;

6/ төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмын дагуу экологийн паспорт хөтлөх.

7/ бохирдлын эх үүсвэр бүхий аж ахуйн нэгж, байгууллага нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, өөрийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны улмаас байгаль орчинд ялгаруулж байгаа хатуу, шингэн, хийн хаягдлыг хянах ажлыг зохион байгуулж ажиллуулах үүрэг бүхий дотоод хяналтын нэгжтэй байх.

*/Энэ заалтыг 2010 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн хуулиар нэмсэн/*

*/Энэ заалтад 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/*

8/ хууль зөрчсөн хүн, хуулийн этгээдийн байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, хариуцлага хүлээлгэхийг Засаг дарга, байгаль орчны хяналтын улсын байцаагчаас шаардах;

*/Энэ заалтыг 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/*

*/Энэ заалтад 2015 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

9/ өөрийн үйл ажиллагааны улмаас байгаль орчинд учруулсан хохирлыг арилгах, холбогдох байгууллагад мэдэгдэх, байгаль орчны хяналтын улсын байцаагчийн ногдуулсан нөхөн төлбөрийг ажлын 14 хоногт багтаан

төлөх;

*/Энэ заалтыг 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/  
10/ байгаль орчинд хохирол учруулж болох аливаа үйлдлээс татгалзах.*

*/Энэ заалтыг 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/  
311 дүгээр зүйл./ 311 дүгээр зүйлийг 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн  
хуулиар хүчингүйд болсонд тооцсон/*

### **32 дугаар зүйл. Байгаль орчныг хамгаалахад төрийн бус байгууллага оролцох**

*/Энэ зүйлийн гарчигт 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/*

1. Байгаль орчин, түүний баялгийг хамгаалах дүрмийн зорилго бүхий олон нийтийн байгууллага болон байгалийн нөөцийн хамтын менежмент эрхлэн явуулах нөхөрлөл байгаль орчныг хамгаалах талаар дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлж болно:

*/Энэ хэсэгт 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

1/ байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн биелэлтэд олон нийтийн хяналт тавих, үзлэг хийх, илэрсэн зөрчлийг арилгахыг шаардах, уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, гэм буруутай этгээдээс байгаль орчинд учруулсан хохирлыг барагдуулуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах;

*/Энэ заалтад 2010 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

2/ байгаль орчныг хамгаалах талаархи саналаа төрийн захиргааны төв байгууллага болон зохих шатны Хурал, Засаг даргад уламжлах;

3/ экологийн сургалт, хүмүүжлийн ажлыг өөрөө болон холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах;

4/ байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх төсөл, зөвлөмж, аргачлал боловсруулж холбогдох байгууллагад танилцуулж шийдвэр гаргуулах.

2. Засгийн газар байгаль орчныг хамгаалах талаархи төрийн гүйцэтгэх байгууллагын тодорхой чиг үүргийг гэрээний үндсэн дээр байгаль орчныг хамгаалах дүрмийн зорилго бүхий төрийн бус байгууллагад эсхүл тухайн нутгийн иргэдийн сайн дурын үндсэн дээр нэгдэн байгуулагдсан этгээдэд шилжүүлж, түүний хэрэгжилтийг санхүүжүүлж болно.

*/Энэ хэсэгт 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт орсон/*

## **ДОЛДУГААР БҮЛЭГ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭДЭЭЛЛИЙН САН**

### **33 дугаар зүйл. Мэдээллийн сангийн хэлбэр**

1. Мэдээллийн санг цахим хэлбэрээр бүрдүүлнэ.

2. Мэдээллийн сангийн мэдээлэл нь өгөгдөл, дуу авиа, дүрс бичлэг, зураг, график, бичгийн хэлбэртэй байна. Энэ зүйлд заасан зурган мэдээлэл нь Засгийн газраас баталсан солбилцол, өндрийн тогтолцоонд үндэслэгдэнэ.

3. Мэдээллийн сангийн өгөгдөл тоон хэлбэртэй байна.

4. Хуульд өөрөөр заагаагүй бол мэдээллийн сан олон нийтэд нээлттэй байна.

### **34 дүгээр зүйл.Мэдээллийн сангийн тогтолцоо**

1.Мэдээллийн сан нь дараахь ангилалтай байна:

- 1/ улсын;
- 2/ аймаг, нийслэлийн;
- 3/ сум, дүүргийн.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан мэдээллийн сан нь нэгдмэл байна.

3.Мэдээллийн санг бүрдүүлэх, боловсруулах, түгээх, ашиглах, хадгалах, хамгаалах журам болон эх мэдээний дэлгэрэнгүй жагсаалтыг Засгийн газар батална.

### **35 дугаар зүйл.Мэдээллийн сангийн бүрдэл**

1.Улсын мэдээллийн сан дараахь зүйлийн талаархи мэдээллээс бүрдэнэ:

- 1/ газар, түүний хөрс;
- 2/ газрын хэвлий, ашигт малтмал;
- 3/ ус, рашаан;
- 4/ ой;
- 5/ байгалийн ургамал;
- 6/ амьтан;
- 7/ агаар, түүний бохирдол;
- 8/ уур амьсгал;
- 9/ байгалийн гамшиг;
- 10/ химийн хорт болон аюултай бодис;
- 11/ хог хаягдал;
- 12/ тусгай хамгаалалттай газар нутаг;
- 13/ байгаль орчны эрх зүй;
- 14/ байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ;
- 15/ байгаль орчны бодлого, хөтөлбөрийн хэрэгжилт;
- 16/ байгаль орчны статистик мэдээлэл, тайлан;
- 17/ байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төсөв, зардал;
- 18/ байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, хүний нөөц;
- 19/ мета мэдээллийн сан;
- 20/ байгаль орчны талаархи бусад мэдээлэл.
- 21/ байгаль орчинд учруулсан хохирлын нөхөн төлбөрийн мэдээлэл;  
*/Энэ заалтыг 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/*
- 22/ байгаль орчны холбогдолтой гэмт хэрэг, зөрчлийн мэдээлэл.  
*/Энэ заалтыг 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/*

2.Аймаг, нийслэлийн мэдээллийн сан энэ зүйлийн 1 дэх хэсгийн 1-7, 9-12, 14-18, 20-д заасан зүйлийн талаархи мэдээллээс бүрдэнэ.

3.Сум, дүүргийн мэдээллийн сан энэ зүйлийн 1 дэх хэсгийн 1-6, 9-12, 14, 15, 17, 18, 20-д заасан зүйлийн талаархи мэдээллээс бүрдэнэ.

### **36 дугаар зүйл.Мета мэдээллийн сан**

1.Байгаль орчны мета мэдээллийн сан дараахь мэдээллээс бүрдэнэ:

- 1/ мэдээллийн нэр, товч тайлбар;
- 2/ мэдээллийн чанарын тодорхойлолт;
- 3/ мэдээллийн үндсэн эх сурвалж;
- 4/ мэдээллийн тойм дүрслэл, солбилцлын тогтолцоо;
- 5/ мэдээллийн хэрэглээ, түгээлт.

2.Байгаль орчинтой холбоотой мэдээлэл бүрдүүлдэг иргэн, төрийн болон төрийн бус байгууллага энэ хуулийн 35 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан мэдээллийг бүрдүүлэх, шинэчлэх бүрд мета мэдээллийг бүрдүүлж улсын мэдээллийн санд төвлөрүүлнэ.

### **36<sup>1</sup> дүгээр зүйл.Байгаль орчинд учруулсан хохирлын нөхөн төлбөрийн мэдээллийн сан**

1.Байгаль орчинд учруулсан хохирлын нөхөн төлбөрийн мэдээллийн сан дараах мэдээллээс бүрдэнэ:

1/ байгаль орчинд хохирол учруулсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын тухай мэдээлэл;

2/ байгаль орчинд учруулсан хохирлын экологи-эдийн засгийн үнэлгээ, ногдуулсан хохирлын нөхөн төлбөрийн хэмжээ;

3/ байгаль орчинд учруулсан хохирлын нөхөн төлбөр төлсөн, хохирлыг арилгасан тухай тайлан.

*/Энэ зүйлийг 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/*

### **37 дугаар зүйл.Мэдээллийн санд мэдээлэл төвлөрүүлэх үүрэг бүхий байгууллага, хэрэгжүүлэх хугацаа**

1.Энэ хуулийн 35 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасан мэдээллийг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага жил бүрийн 2 дугаар сарын 20-ны дотор улсын мэдээллийн санд төвлөрүүлнэ.

2.Энэ хуулийн 35 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2-т заасан мэдээллийг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэлийн Засаг дарга жил бүрийн 3 дугаар сарын 1-ний дотор улсын мэдээллийн санд төвлөрүүлнэ.

3.Энэ хуулийн 35 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3, 4, 7-д заасан мэдээллийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага жил бүрийн 12 дугаар сарын 20-ны дотор улсын мэдээллийн санд төвлөрүүлнэ.

4.Энэ хуулийн 35 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, 6-д заасан мэдээллийг эрдэм шинжилгээний болон тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага жил бүрийн 12 дугаар сарын 20-ны дотор улсын мэдээллийн санд төвлөрүүлнэ.

5.Энэ хуулийн 35 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 8, 9-д заасан мэдээллийг ус цаг уур, орчны хяналт шинжилгээ болон онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гамшгийн нөхцөл байдал үүссэн тухай бүр улсын мэдээллийн санд төвлөрүүлнэ.

6.Энэ хуулийн 35 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10-т заасан мэдээллийг байгаль орчин, геологи, уул уурхай болон тухайн асуудал эрхэлсэн бусад төрийн захиргааны төв байгууллага жил бүрийн 12 дугаар сарын 20-ны дотор улсын мэдээллийн санд төвлөрүүлнэ.

7.Энэ хуулийн 35 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 11, 12-т заасан мэдээллийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэлийн Засаг дарга жил бүрийн 12 дугаар сарын 20-ны дотор улсын мэдээллийн санд төвлөрүүлнэ.

8.Энэ хуулийн 35 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 13-18-д заасан мэдээллийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухай бүр улсын мэдээллийн санд төвлөрүүлнэ.

### **38 дугаар зүйл. Мэдээллийн сангийн үйл ажиллагааг хангах байгууллага**

1. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага мэдээллийн сангийн үйл ажиллагааг улсын хэмжээнд удирдан зохион байгуулна.

2. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд байгаль орчны мэдээллийн төв байх бөгөөд уг төв нь улсын мэдээллийн сангийн өдөр тутмын үйл ажиллагааг хэрэгжүүлэх төрийн үйлчилгээний байгууллага байна.

### **39 дүгээр зүйл. Байгаль орчны мэдээллийн төвийн бүрэн эрх**

1. Байгаль орчны мэдээллийн төв дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ мэдээллийн сангийн үйл ажиллагааны талаархи хууль тогтоомжийг хэрэгжүүлэх;

2/ мэдээллийн санг бүрдүүлэх, баяжуулах, хадгалах, хамгаалах, шинэчлэх, ашиглах үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;

3/ мэдээллийн сангийн хүрээнд программ хангамж, техник технологи, хүний нөөцийн нэгдмэл бодлого хэрэгжүүлэх, тэдгээрийг сургаж бэлтгэх, мэргэшүүлэх;

4/ хэрэглэгчийг мэдээллийн сангаас мэдээлэл авах эрхийг хэрэгжүүлэх нөхцөлийг хангах;

5/ нийтийн хэрэгцээний болон хоёрдогч мэдээллийг бий болгоход шаардлагатай мэдээлэл боловсруулах;

6/ мэдээллийн сангийн өгөгдөл, мэдээлэлд бүртгэл хөтлөх, баримтжуулах;

7/ мэдээллийн сангийн мэдээллийг энэ хуулийн 37 дугаар зүйлд зааснаас бусад иргэн, хуулийн этгээдээс цуглуулах, сонгох, нягтлан шалгах ажлыг зохион байгуулах;

8/ мэдээллийн үнэн зөв, мэдээллийн сангийн шуурхай байдал, хэвийн ажиллагаа, хамгаалалт, хадгалалт, нууцлалт, хуулбарлалтыг хариуцах;

9/ мэдээллийн сангийн нөөц хувь бүрдүүлэх;

10/ мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хангах;

11/ мэдээллийн сан бүрдүүлэх асуудлаар мэдээлэл бүрдүүлэх, төвлөрүүлэх үүрэг бүхий байгууллагад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх;

12/ мэдээллийн санд өөрчлөлт хийх, мэдээлэл бүрдүүлэх, мэдээллийн сангийн талаархи тайланг жил бүр гаргах;

13/ мэдээллийн санд халдлага, гэмтэл гарсан даруйд холбогдох байгууллагад мэдэгдэх, түүний хэвийн үйл ажиллагааг сэргээх;

14/ мэдээллийн сангийн асуудлаар гадаадын болон олон улсын байгууллагатай хамтран ажиллах;

15/ мэдээллийн санг зориулалтын байр, программ хангамж, компьютер, тоног төхөөрөмжөөр хангах, шаардлагатай өгөгдөл, мэдээлэл худалдан авахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг жил бүрийн улсын төсөвт тусгуулах.

### **40 дүгээр зүйл. Мэдээллийн санд мэдээлэл төвлөрүүлэх үүрэг бүхий байгууллагын бүрэн эрх**

1. Энэ хуулийн 37 дугаар зүйлд заасны дагуу улсын мэдээллийн санд мэдээлэл төвлөрүүлэх үүрэг бүхий байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ холбогдох мэдээллийг бүрдүүлж, улсын мэдээллийн санд цахим

хэлбэрээр буюу сүлжээгээр нийлүүлэх, техникийн хувьд боломжгүй бол мэдээлэл зөөгч хэрэгслээр өгөх;

2/ байгаль орчны өгөгдөл, мэдээллийг шинэчлэх, өөрчлөлт оруулах, шинэ өгөгдөл, мэдээллээр мэдээллийн санг баяжуулах;

3/ байгаль орчны өгөгдөл, мэдээллийн үнэн зөв, бодит байдлыг хариуцах;

4/ байгаль орчны өгөгдөл, мэдээллийн анхдагч боловсруулалтыг хариуцах;

5/ байгаль орчны өгөгдөл, мэдээлэлийн нэмэлт, өөрчлөлт, шинэчлэлтийн тухай байгаль орчны мэдээллийн төвд ажлын 7 өдөрт багтаан мэдэгдэх;

6/ улсын мэдээллийн санд мэдээлэл төвлөрүүлэх техник, технологийн нөхцөлийг бүрдүүлэх, холбогдох зардлыг хариуцах.

#### **41 дүгээр зүйл.Мэдээллийн санг хэрэглэгчийн эрх, үүрэг**

1.Мэдээллийн сангийн хэрэглэгч дараахь эрх, үүрэгтэй:

1/ мэдээллийн сангийн өгөгдөл, мэдээллийг ашиглан эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх, лавлагааны мэдээлэл бэлтгэх болон бусад хэлбэрээр ашиглахдаа мэдээлэл эзэмшигчийн нэрийг ишлэл болгох;

2/ мэдээллийн сангийн үйл ажиллагаа болон өгөгдөл, мэдээллийн талаар гомдол гаргах.

#### **42 дугаар зүйл.Мэдээллийн санг бүрдүүлэх ерөнхий шаардлага**

1.Мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах, түгээх үйл ажиллагаа, техник, технологи нь мэдээлэл, харилцаа холбоо, технологийн төрийн нэгдсэн бодлоготой уялдсан байна.

2.Мэдээллийн сангийн агуулга, нэр төрөл, хамрах хүрээ нь хэрэглэгчийн эрэлт хэрэгцээгээр тодорхойлогдоно.

3.Мэдээллийн сангийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх байгууллагын техник, технологийн шийдэл нь мэдээллийн нэгдмэл байдлыг хангахад чиглэгдэнэ.

#### **43 дугаар зүйл.Мэдээллийн сангийн үйл ажиллагаанд хориглох зүйл**

1.Мэдээллийн сангийн үйл ажиллагаанд дараахь зүйлийг хориглоно:

1/ мэдээллийн сангийн өгөгдөл, мэдээллийг өөрчлөх, устгах, хулгайлах;

2/ мэдээллийн сангийн программ хангамжийг өөрчлөх, устгах, эвдэх;

3/ мэдээллийн сангийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, сүлжээний найдвартай үйл ажиллагааг санаатай болон санамсаргүйгээр алдагдуулах, эвдэх, гэмтээх;

4/ мэдээллийн санд вирус тараах;

5/ мэдээллийн санд агуулагдаж буй иргэн, хуулийн этгээдийн нууцтай холбоотой мэдээллийг задруулах;

6/ мэдээллийн сангаас авсан мэдээллийг эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр арилжааны зорилгоор ашиглах, бусдад дамжуулах, худалдах;

7/ мэдээллийн сангаас санаатай болон болгоомжгүйгээр мэдээлэл хуулбарлах, ишлэлгүйгээр ашиглах;

8/ ашиглах хүрээг нь хязгаарласан өгөгдөл, мэдээлэлд хууль бусаар нэвтрэх, тэдгээрийг өөрчлөх, хуулбарлах, устгах;

9/ мэдээллийн санд хандах эрхийг хууль бусаар олж авах, бусдад дамжуулах;

10/ мэдээллийн сангийн ажилтан хуулиар хүлээсэн давуу эрхтэй холбоотойгоор өгөгдөл, мэдээлэл болон мэдээллийн сангийн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг алдагдуулах.

#### **44 дүгээр зүйл.Мэдээллийн сангийн санхүүжилт, төлбөрийн нөхцөл**

1.Мэдээллийн сан төрийн өмч байх бөгөөд түүний үйл ажиллагааг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

2.Мэдээллийн сангийн мэдээлэл нь төлбөртэй болон төлбөргүй байна. Төлбөргүй болон нийтэд зориулсан мэдээллийн жагсаалтыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

3.Иргэн, хуулийн этгээд өөрийн хөрөнгөөр цуглуулж бүрдүүлсэн өгөгдөл, мэдээллийн тухай мета мэдээллийг улсын санд төлбөргүй өгөх үүрэгтэй.

4.Байгаль орчны мэдээллийн төв энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан иргэн, хуулийн этгээдээс шаардлагатай мэдээллийг худалдан авч болно.

5.Иргэн, байгууллага, хуулийн этгээд нь улсын төсөв, шинжлэх ухаан, технологийн сан, олон улсын болон гадаадын зээл, тусламжийн хүрээнд бүрдүүлсэн байгаль орчны өгөгдөл, мэдээллийг улсын мэдээллийн санд үнэ төлбөргүй төвлөрүүлэх үүрэгтэй.

6.Мэдээллийн сангийн сургалт, танин мэдэхүй, эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангахтай холбоотой нийтэд зориулсан мэдээллийг иргэн, хуулийн этгээд төлбөргүй ашиглах эрхтэй.

7.Энэ зүйлд заасан төлбөртэй мэдээллийн орлогын 50 хүртэл хувийг мэдээллийн санг шинэчлэх, үйлчилгээний хүрээг нэмэгдүүлэх, түүний хүчин чадлыг сайжруулахад зарцуулна.

*/Энэ бүлгийг 2008 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хуулиар нэмсэн/*

### **НАЙМДУГААР БҮЛЭГ**

#### **БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН ХАМТЫН МЕНЕЖМЕНТ**

##### **45 дугаар зүйл.Байгалийн нөөцийн хамтын менежмент**

1.Энэ хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 8 дахь заалтад заасан нөхөрлөлийн хэлбэрээр зохион байгуулагдсан нутгийн иргэдэд байгалийн нөөцийг дундаа хариуцан хамгаалах, зохистой ашиглах болон нөхөн сэргээх эрхийг олгож, нутгийн иргэд нөөц ашиглалтыг хамтаараа, ил тод, шударга зарчимд нийцүүлэн зохион байгуулж, түүнээс нийгэм, эдийн засгийн ашиг тусыг хүртэж байх үйл явцыг байгалийн нөөцийн хамтын менежмент гэнэ.

##### **46 дугаар зүйл.Байгалийн нөөцийн хамтын менежментийн зарчим**

1.Байгалийн нөөцийн хамтын менежментэд дараах зарчмыг баримтална:

1/ байгалийн нөөцийн ашиглалт нь байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх бодлоготой нягт уялдаатай байх;

2/ байгалийн нөөцийн хамтын менежмент нь экосистемийн тэнцвэрт байдлыг алдагдуулахгүй байх;

3/ тухайн шатны төрийн байгууллага, иргэдийн нөхөрлөл байгалийн нөөцийн менежментийг явуулах эрх, үүргийг тэдгээрийн хооронд байгуулсан хамтын гэрээгээр энэ хуулийн хүрээнд тодорхойлсон байх;

4/ нөхөрлөлд төр, нөхөрлөлөөс гадна сонирхогч бусад талуудын оролцоог бүрэн хангах.

##### **47 дугаар зүйл.Байгалийн нөөцийн хамтын менежментийн хамрах хүрээ**

1.Нөхөрлөлийн хамгаалах, ашиглах, нөхөн сэргээх объектэд энэ хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан байгалийн нөөцөөс гадна дэлхийн болон үндэсний байгаль, соёлын өвд хамаарагдах газар нутаг орно.

#### **48 дугаар зүйл. Байгалийн нөөцийн хамтын менежментийн үйл ажиллагаанд оролцогч талууд**

1. Байгалийн нөөцийн хамтын менежментийн үйл ажиллагаанд дараах талууд оролцоно:

- 1/ энэ хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 11 дэх заалтад заасан хэлбэрээр байгуулагдсан нөхөрлөл;
- 2/ нутгийн өөрөө удирдах байгууллага, бүх шатны Засаг дарга;
- 3/ тухайн суманд ажиллаж байгаа байгаль орчны мэргэжлийн байгууллага.

2. Байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж оролцогч тал байж болно.

#### **49 дүгээр зүйл. Байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлөх**

1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь байгаль орчин болон байгалийн нөөцөд хохирол учруулсан бол нөхөн төлбөр төлөх бөгөөд нөхөн төлбөрийг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан Байгаль орчин, уур амьсгалын санд оруулна. Нөхөн төлбөр төлөгч нь тогтоосон хэмжээнээс илүү төлбөр төлсөн тохиолдолд зөрүүг Байгаль орчин, уур амьсгалын сангаас буцаан олгоно.

*/Энэ хэсэгт 2017 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

2. Байгаль орчинд учруулсан хохирлыг дараах байдлаар ангилна:

- 1/ ойн санд учруулсан хохирол;
- 2/ амьтанд учруулсан хохирол;
- 3/ ургамалд учруулсан хохирол;
- 4/ усны нөөцөд учруулсан хохирол;
- 5/ газарт учруулсан хохирол;
- 6/ газрын хэвлийд учруулсан хохирол;
- 7/ хөрсөнд учруулсан хохирол.

3. Энэ хуулийн 49 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан хохиролд байгаль орчны хяналтын улсын байцаагч нөхөн төлбөр ногдуулна.

4. Энэ хуулийн 49 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 1-5 дахь заалтад заасан хохирлыг тухайн төрлийн байгалийн нөөцийн экологи-эдийн засгийн үнэлгээг үндэслэн дор дурдсан хэмжээгээр тогтооно:

- 1/ ойн санд учирсан хохирлыг ойн экологи-эдийн засгийн үнэлгээг гурав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр;
- 2/ амьтны аймагт учирсан хохирлыг тухайн амьтны экологи-эдийн засгийн үнэлгээг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр;
- 3/ ургамлын аймагт учирсан хохирлыг тухайн ургамлын экологи-эдийн засгийн үнэлгээг тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр;
- 4/ усны нөөцөд учирсан хохирлыг тухайн сав газрын усны экологи-эдийн засгийн үнэлгээг гурав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр;
- 5/ газарт учирсан хохирлыг тухайн ангиллын газрын экологи-эдийн засгийн үнэлгээг гурав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр.

5. Энэ хуулийн 49 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 6, 7 дахь заалтад заасан хохирлыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан байгаль орчинд учирсан хохирлыг тооцох аргачлалаар тогтоосон хэмжээг үндэслэн дор дурдсан хэмжээгээр тогтооно:

1/ газрын хэвлийд учирсан хохирлыг байгаль орчинд учирсан хохирлыг тооцох аргачлалаар тооцсон хохирлын хэмжээг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр;

2/ хөрсөнд учирсан хохирол, байгаль орчныг бохирдуулснаас үүсэх хохирлыг байгаль орчинд учирсан хохирлыг тооцох аргачлалаар тооцсон хохирлын хэмжээг гурав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр;

6.Энэ хуулийн 49 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн 1, 2 дахь заалтад заасан хохирлыг байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний эрх авсан мэргэжлийн байгууллагаар хөлсийг төлж тооцуулна.

7.Хохирол тооцсон ажлын зардлыг нөхөн төлбөрт нэмж тооцно.

8.Нөхөн төлбөрийг ногдуулсан байгаль орчны хяналтын улсын байцаагч ажлын 14 хоногт багтаан тухайн төлбөрийг барагдуулах үүрэгтэй бөгөөд уг хугацаанд барагдуулаагүй тохиолдолд шүүхийн шийдвэр гүйцэтгэх журмаар шийдвэрлүүлэхээр холбогдох байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийг хангуулна.

## **50 дугаар зүйл.Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл**

1.Байгалийн нөөцийн хамтын менежментийн үйл ажиллагаанд тухайн орон нутгийн иргэд энэ хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 8 дахь заалтад заасан нөхөрлөлийн хэлбэрээр зохион байгуулагдан оролцож болох бөгөөд гэрээний үндсэн дээр хамтын менежментээр хариуцаж байгаа нутаг дэвсгэрийнхээ тодорхой төрлийн байгалийн нөөцийг хуулийн хүрээнд гэрээнд заасны дагуу зохистой ашиглах давуу эрхтэй байна.

2.Иргэдийн нөхөрлөлийн гишүүн нь 18 нас хүрсэн, тухайн сум дүүрэгт байнга оршин суугч Монгол Улсын иргэн байна.

3.Тодорхой төрлийн байгалийн нөөцийг гэрээний дагуу нөхөрлөлд хариуцуулахдаа нөхөрлөлийн гишүүдийн тоо, хариуцуулах талбай, баялгийн нөөц, хэмжээ, онцлог зэргийг харгалзана.

4.Сум дүүргийн Засаг дарга дараах баримт бичгийг үндэслэн байгаль хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулах иргэдийн нөхөрлөлтэй гэрээ байгуулан хамтран ажиллаж, тэдний үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулна:

1/ баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын санал, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэр;

2/ нөхөрлөлийн байгалийн нөөцийн менежмент явуулахыг хүссэн өргөдөл;

3/ нөхөрлөлийн бүх гишүүдийн хурлаар хэлэлцэж баталсан байгалийн нөөцийн хамтын менежмент явуулах менежментийн төлөвлөгөө;

4/ нөхөрлөл байгуулсан гишүүдийн хамтран ажиллах тухай гэрээ болон иргэний үнэмлэхний хуулбар.

5.Энэ хуулийн 50 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан бичиг баримтыг бүрдүүлсэн нөхөрлөлтэй сум, дүүргийн Засаг дарга үйл ажиллагаа явуулах гэрээ байгуулж, гэрчилгээ олгоно.

6.Нөхөрлөлийн байгалийн нөөцийн хамтын менежментийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах гэрээ болон гэрчилгээний загварыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

7.Нөхөрлөл нь оролцогч талуудтай Иргэний хуулийн 481.1-д заасны дагуу бичгээр гэрээ байгуулж ажиллана.

8.Нөхөрлөлийн байгалийн нөөцийн хамтын менежментийн чиглэлээр

явуулах үйл ажиллагааг дараах тохиолдолд тухайн сум, дүүргийн Засаг дарга зогсоож, гэрээг цуцална:

1/ нөхөрлөлийн байгалийн нөөцийн хамтын менежментийн чиглэлээр явуулах үйл ажиллагааг зогсоох тухайн баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын санал, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэр гарсан;

2/гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа биелүүлээгүй, гэрээ байгуулснаас хойш зургаан сар байгалийн нөөцийн хамтын менежментийн чиглэлээр үйл ажиллагаа явуулаагүй;

3/ бүх гишүүдийн хурлаар нөхөрлөлийн байгалийн нөөцийн хамтын менежмент явуулах үйл ажиллагааг зогсоох тухай шийдвэр гарсан;

4/ энэ хуулийн 50 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан шаардлагыг хангаагүй;

9.Нөхөрлөл нь энэ хуулийн 31 дүгээр зүйл, тодорхой төрлийн байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх харилцааг зохицуулсан холбогдох хууль тогтоомжид заасан үүргийг биелүүлэхийн зэрэгцээ, тухайн шатны Засаг даргатай байгуулсан гэрээнд заасны дагуу өөрийн үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн эрхэлнэ.

10.Нөхөрлөл нь өөрийн дотоод дүрэмтэй байх бөгөөд дүрмэндээ бүх гишүүдийн хурал, удирдах зөвлөл, хяналтын зөвлөл, ахлагч, гишүүний эрх, үүрэг, хариуцлага, дундын өмч хөрөнгийн харилцааны асуудлыг хуульд заасны дагуу тусгасан байна.

11.Нөхөрлөл байгалийн нөөцийн менежментийн талаарх тайланг жил бүр тухайн сум, дүүрэг, баг, хорооны Хуралд тайлагнах бөгөөд түүнд байгалийн баялгийг хамгаалах, ашиглах, нөхөн сэргээхэд зарцуулсан хөрөнгийн зарцуулалт, түүний үр дүн, нөөц баялгийн төлөв байдал, түүний өөрчлөлт зэргийг тусгасан байна.

12.Нөхөрлөл нь өөрсдийн эрх ашгаа хамгаалах, хамтын ажиллагаагаа зохицуулах үүрэг бүхий нөхөрлөлүүдийн холбоотой байж болох бөгөөд холбооны дүрэм, үйл ажиллагааг Төрийн бус байгууллагын тухай хуулиар[3] зохицуулна.

13.Нөхөрлөл нь өөрийн эзэмшлийн газар болон байгалийн нөөц бусад эд хөрөнгөд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх эрхтэй.

14.Нөхөрлөл нь тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэх бөгөөд банкинд данстай байж болно.

## **51 дугаар зүйл.Нөхөрлөлийн дундын сан**

1.Нөхөрлөл нь үйл ажиллагаагаа санхүүжүүлэх, гишүүддээ дэмжлэг үзүүлэх зорилгоор дундын сан байгуулж болно.

2.Дундын санг бүрдүүлэх, зарцуулах журмыг нөхөрлөлийн бүх гишүүдийн хурлаар хэлэлцэн батална.

3.Дундын санг байгууллага хамт олны хандив, тусламж, нөхөрлөлийн гишүүдийн оруулсан хөрөнгө, дундын сангийн зээлийн хүү, нөхөрлөлийн эд хөрөнгийн ашиглалтын түрээс, үйлдвэрлэл, үйлчилгээ явуулсан орлогын мөнгөн дүнгийн тодорхой хувь зэрэг эх үүсвэрээс бүрдүүлж болно.

4.Дундын санг байгалийн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх ажлын байр бий болгох, нөхөрлөлийн гишүүдийн амьжиргааг дэмжих, байгалийн гамшгийн улмаас учирсан хохирлыг багасгах, нөхөрлөлийн гишүүдийн хурлаас тогтоосон бусад үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зарцуулна.

## **52 дүгээр зүйл.Нөхөрлөлийн менежментийн төлөвлөгөө**

1.Нөхөрлөл нь бүх гишүүдийн хурлаар хэлэлцэж баталсан менежментийн төлөвлөгөөтэй байна.

2.Менежментийн төлөвлөгөөнд дараах асуудлыг тусгана:

1/ хариуцаж байгаа байгалийн нөөц, баялгийн мэдээлэл, нутаг дэвсгэрийн хил хязгаарыг баталгаажуулсан зураг;

2/ байгалийн нөөцийн хамтын менежмент явуулах нөхөрлөлийн ашиглах байгалийн нөөцийн тархацын хил хязгаар, тоо хэмжээ, даац, чанар зэрэг үзүүлэлт;

3/ эдийн засаг, нийгмийн хувьд ашиг тусаа одоо, ирээдүйд үзүүлж байх нөхцөл, арга хэмжээ;

4/ тухайн төрлийн байгалийн нөөцийн онцлог шинж чанарт тохирсон менежмент явуулах арга, хэлбэр;

5/ нөхөрлөлийн ашиглаж, эзэмшиж байгаа байгалийн нөөцийн төлөв байдлыг хянах хяналт-шинжилгээний хөтөлбөр;

6/ менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд нөхөрлөлийн гишүүд тус бүрийн гүйцэтгэх үүрэг болон оролцогч талтай хамтрах ажил;

7/ санхүүгийн төлөвлөгөө;

8/ бүх гишүүдийн хурлаас тогтоосон бусад зүйл.

*/Энэ бүлгийг 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/*

## **ЕСДҮГЭЭР БҮЛЭГ**

*/Энэ бүлгийн дугаарт 2008 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хууль, 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/*

## **БУСАД ЗҮЙЛ**

### **53 дугаар зүйл.Санхүүжилт**

*/Энэ зүйлийн дугаарт 2008 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хууль, 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/*

1.Төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагаас байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг нөхөн сэргээх арга хэмжээ хэрэгжүүлэх, байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавихад шаардагдах зардлыг улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.

*/Энэ хэсэгт 2003 оны 1 дүгээр сарын 2-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/*

2.Хуульд өөрөөр заагаагүй бол байгалийн баялгийн нөөц ашигласны төлбөр, хураамжийн орлого орон нутгийн төсөвт орно.

### **54 дугаар зүйл.Байгаль орчныг хамгаалах эдийн засгийн хөшүүрэг**

*/Энэ зүйлийн дугаарт 2008 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хууль, 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/*

1.Байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчинд үзүүлэх хортой аюултай нөлөөллийг багасгах дэвшилт арга, хоргүй, аюулгүй, бохирдолгүй, хаягдалгүй технологи нэврүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг төрөөс урамшуулна.

*/Энэ хэсэгт 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмэлт орсон/*

2.Экологийн боловсрол, хүмүүжил олгох, байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх ажилд төсвөөс санхүүгийн дэмжлэг үзүүлнэ.

*/Энэ хэсгийг 2006 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах журмыг Засгийн газар тогтооно.

*/Энэ хэсэгт 2006 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөлт орсон/*

4.Байгаль орчны хууль тогтоомж зөрчсөн тухай үнэн бодит мэдээллийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд өгсөн, түүнчлэн зөрчлийг илрүүлсэн, илрүүлэхэд бодитой туслалцаа үзүүлсэн иргэнд зөрчил гаргагчид ногдуулсан торгууль, нөхөн төлбөрийн орлогын дүнгийн 15 хувьтай тэнцэх мөнгөн урамшууллыг сум, дүүргийн Засаг дарга байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос олгоно.

*/Энэ хэсгийг 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмсэн/*

*/Энэ хэсэгт 2015 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

5. Хууль бусаар бэлтгэж хураалгасан байгалийн баялгийн борлуулалтын орлогын 15 хувийг тухайн зөрчлийг илрүүлсэн улсын байцаагчид мэргэжлийн хяналтын байгууллага, байгаль хамгаалагчид тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос олгоно.

*/Энэ хэсгийг 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмсэн/*

*/Энэ хэсэгт 2015 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

6.Энэ зүйлийн 4, 5, 8, 9 дахь хэсэгт заасан урамшуулал олгох журмыг Сангийн болон Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд батална.

*/Энэ хэсгийг 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмсэн/*

*/Энэ хэсэгт 2015 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

7.Энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасан мэдээлэгчийг холбогдох хууль тогтоомжийн дагуу нууцлана.

*/Энэ хэсгийг 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмсэн/*

8.Байгаль орчны хууль тогтоомж зөрчсөн тухай үнэн бодит мэдээллийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд өгсөн иргэн, нөхөрлөл, төрийн бус байгууллагад 150000 төгрөгийн мөнгөн урамшууллыг сум, дүүргийн Засаг дарга ажлын 10 өдөрт багтаан байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос олгоно.

*/Энэ хэсгийг 2015 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн хуулиар нэмсэн/*

9.Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг, зөрчил үйлдэхэд ашиглаж хураалгасан зэвсэг, тээврийн хэрэгсэл, унаа хөсөг, техник, тоног төхөөрөмжийг борлуулсны орлогын 70 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг тухайн гэмт хэрэг, зөрчлийг илрүүлсэн нөхөрлөл, төрийн бус байгууллага, цагдаа, хил хамгаалах байгууллагын ажилтанд байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Байгаль орчин, уур амьсгалын сангаас олгоно.

*/Энэ хэсгийг 2015 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар нэмсэн/*

*/Энэ хэсэгт 2017 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

10.Хууль бусаар бэлтгэж хураалгасан байгалийн баялгийг борлуулсны орлого болон гэмт хэрэг, зөрчил үйлдэхэд ашиглаж хураалгасан зэвсэг, тээврийн хэрэгсэл, унаа хөсөг, техник, тоног төхөөрөмжийг борлуулсны орлогыг Засгийн

газрын тусгай сангийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан Байгаль орчин, уур амьсгалын санд оруулна.

*/Энэ хэсгийг 2015 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар нэмсэн/*

*/Энэ хэсэгт 2017 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

11. Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэргийг мөрдөхөд шаардлагатай үнэлгээ, шинжилгээ, шинжээчийн болон лабораторийн зардлыг эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр Байгаль орчин, уур амьсгалын сангаас санхүүжүүлнэ.

*/Энэ хэсгийг 2015 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар нэмсэн/*

*/Энэ хэсэгт 2017 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

## **55 дугаар зүйл. Байгалийн баялгийн нөөц ашигласны төлбөр, хураамж**

*/Энэ зүйлийн дугаарт 2008 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хууль, 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/*

1. Байгалийн баялгийн нөөц ашигласны төлбөр, хураамжид байгалийн баялгийн нөөц ашиглах эрхийн бичиг олгосны хураамж, нөөц ашигласны төлбөр, зөвшөөрсөн хэмжээнд хог хаягдал, бохирдуулах бодис гаргасны төлбөр хамаарна.

2. Эрхийн бичиг, гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэн ашигласан болон зөвшөөрөлгүй агнасан, түүсэн, бэлтгэсэн, олборлосон байгалийн баялаг болон зөвшөөрсөн хэмжээнээс хэтрүүлэн хог хаягдал, бусад бодис гаргахад нөхөн төлбөр ногдуулна.

*/Энэ хэсэгт 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмэлт орсон/*

3. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан нөхөн төлбөрийг орон нутгийн төсөвт оруулна.

*/Энэ хэсэгт 2006 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөлт орсон/*

4. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан төлбөр, хураамжийн дээд, доод хэмжээ, төлөх журмыг хуулиар тогтооно.

## **56 дугаар зүйл. Экологийн боловсрол, хүмүүжил**

*/Энэ зүйлийн дугаарт 2008 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хууль, 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/*

1. Засгийн газар албан болон албан бус боловсролын тогтолцооны хүрээнд иргэдэд экологийн боловсрол, хүмүүжил, байгаль орчныг хамгаалах арга, дадал олгох хөтөлбөрийг баталж биелэлтийг зохион байгуулна.

2. Экологийн боловсрол, хүмүүжил олгох ажлыг дараахь байдлаар зохион байгуулна:

1/ сургуулийн өмнөх боловсролын байгууллага, ерөнхий боловсролын сургуульд байгаль орчныг хамгаалах анхны мэдлэг, хүмүүжил олгох;

2/ коллеж, их, дээд сургууль болон мэргэжлийн сургалтын байгууллагад мэргэжлийн чиг баримжааг харгалзан байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зохистой ашиглах шинжлэх ухааны үндэс, эрх зүйн мэдлэг олгох;

3/ хэвлэл, мэдээллийн хэрэгслээр экологийн мэдлэг, байгаль орчныг хамгаалах үндэсний уламжлал, зан заншил, хууль тогтоомж сурталчлах.

### **57 дүгээр зүйл.Байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлөх**

*/Энэ зүйлийн дугаарт 2008 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хууль, 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/*

1.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хууль бус үйл ажиллагаагаараа байгаль орчин, түүний баялагт учруулсан шууд хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй.

2.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хууль бус үйл ажиллагааны улмаас байгаль орчны алдагдсан тэнцлийг болон байгалийн баялгийг нөхөн сэргээх, хүн амыг нүүлгэх, мал, амьтныг тухайн нутаг дэвсгэрээс шилжүүлэхэд гарсан зардлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэхээр сум, дүүргийн Засаг дарга шүүхэд нэхэмжлэл гаргана.

*/Энэ хэсэгт 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/*

3.Гэм буруутай этгээд энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан хохирлыг нөхөн төлсөн нь түүнд зохих хууль тогтоомжийн дагуу Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэхээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

*/Энэ хэсэгт 2015 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

### **58 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

*/Энэ зүйлийг 2015 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

### **59 дүгээр зүйл.Хууль хүчин төгөлдөр болох**

*/Энэ зүйлийн дугаарт 2008 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хууль, 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/*

Энэ хуулийг 1995 оны 6 дугаар сарын 5-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Н.БАГАБАНДИ